

# ЖИЛИЙН ТАЙЛАН 2025



НЭЭЛТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ



# ЖИЛИЙН ТАЙЛАН 2025



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

**ДАЛ ЭРГЭЦҮҮЛЭЛ**  
ХУМАГЛИЙН ХАНАА-ТЭГЭЛДИЙН  
МОНГОЛЫН ЭХЭЛЦҮҮЛЭХ  
ШААРДАЛЫН ХЭРЭГЖИЛТ

**СОНГУУЛИЙН МАЖОРИТАР  
ТОЙРГИЙН МАНДАТЫГ ЗОХИСТОЙ  
ТОГТООХ НБ**

**СОНГУУЛИЙН МАРГААН**  
НЭХ ГҮЙНГӨРИЙН ХЭРЭГЖИЛТ,  
ЗӨВШӨМӨК

**БУСАТ**  
ХУМАГЛИЙН ХАНАА-ТЭГЭЛДИЙН  
МОНГОЛЫН ЭХЭЛЦҮҮЛЭХ  
ШААРДАЛЫН ХЭРЭГЖИЛТ

**ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН  
ТЭСЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ  
БА ОЛОН НИЙТЭЭР ХЭЛЭЛЦҮҮЛЭХ  
ШААРДАЛЫН ХЭРЭГЖИЛТ**

**БӨДЛОГЫН АСУУДАЛ**  
ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ  
УР ДАЛАРЫГ  
ХАМГААХ ШААРДАЛЫН ХЭРЭГЖИЛТ

**ХУУЛИЙН ШҮҮМЖ**  
ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ТУХАЙ ХУУМАГ  
ОРУУЛАЖ  
БҮЙ НӨМӨЛ, ӨНӨРЧМӨТГИЙ  
ХАМГААТОЙ  
САЛГАА ШҮҮМЖ

**ШҮҮХ ШИНЖЛЭГЭЭНИЙ  
БАЙГУУЛЛАГЫН ХАРАА  
БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ**

**ЗАСГИЙН ГАЗРЫН Н ИМЭГ ТӨСВИЙН СУРАГЛАЛ**  
ТӨСВИЙН  
ГАНЦАМД  
ХИЛ ДАМНАСАН ТӨМӨР  
ЗАМ

**МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ГҮЙЛГЭЭД  
ЖӨНДӨН АУДИТЫН ТАЛАНГААД**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР  
БОЛОН УЛААБАНД АЖИР НЭМЭГ  
ТӨСВИЙН ТАЛАНГАА**

**2020-2024 ОНД ЭХЭЛСЭН  
ТӨСВИЙН ХАРАНГӨ**

Төрөл	2024 он	2023 он
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР	2,100,000,000	1,100,000,000
МОНГОЛ УЛСЫН БОЛОН УЛААБАНД	7,000,000,000	1,100,000,000

Төрөл	2024 он	2023 он
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР	1,100,000,000	1,100,000,000
МОНГОЛ УЛСЫН БОЛОН УЛААБАНД	1,100,000,000	1,100,000,000

Төрөл	2024 он	2023 он
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР	1,100,000,000	1,100,000,000
МОНГОЛ УЛСЫН БОЛОН УЛААБАНД	1,100,000,000	1,100,000,000

## Гарчиг

<b>ТОВЧИЛСОН ҮГ</b> .....	3
<b>ӨМНӨХ ҮГ</b> .....	4
<b>АРДЧИЛСАН САЙН ЗАСАГЛАЛ</b>	
<b>Ардчиллын институциудыг бэхжүүлэх хөтөлбөр</b> .....	8
<b>Иргэний нийгмийн орон зайн хөтөлбөр</b> .....	25
<b>ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН БОДЛОГО</b>	
<b>Эрх зүйн хөтөлбөр</b> .....	30
<b>НИЙТИЙН БАЯЛГИЙН УДИРДЛАГА, ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ</b>	
<b>Төсвийн хариуцлагыг дээшлүүлэх хөтөлбөр</b> .....	38
<b>Эрдэс баялгийн салбарын засаглалын хөтөлбөр</b> .....	59
<b>САНХҮҮГИЙН ТАЙЛАН</b> .....	75

## Товчилсон үг

ННФ	Нээлттэй нийгэм форум
УИХ	Улсын Их Хурал
ҮХЦ	Үндсэн хуулийн цэц
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АТГ	Авлигатай тэмцэх газар
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
НҮТББ	Нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллага
ГҮТББ	Гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага
МАН	Монгол Ардын Нам
АН	Ардчилсан Нам
ХҮН	Хөдөлмөрийн Үндэсний Нам
ИЗНН	Иргэний Зориг Ногоон Нам
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОУИТБС	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УДШ	Улсын дээд шүүх
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
ҮБС	Үндэсний баялгийн сан
ТӨК	Төрийн өмчит компани
ТӨААН	Төрийн өмчит аж ахуйн нэгж
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ААН	Аж ахуйн нэгж
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
D-Өргөдөл	Нийтийн цахим өргөдөл, гомдлын систем
D-Parliament	Парламентын цахим оролцооны систем
ДЭЗФ	Дэлхийн эдийн засгийн форум

## ӨМНӨХ ҮГ

Төрийн шударга байдал аливаа улс орны хамгийн чухал стратегийн баялаг болохыг өндөр хөгжилтэй орнуудын туршлага харуулсаар байна. Оновчтой тодорхойлж, үр нөлөөтэй хэрэгжүүлдэг шударга ёсны тогтоолцоо нь ардчилсан улсыг авлигаас хамгаалж, иргэдийн төрд итгэх итгэлийг дээшлүүлж, тэгш боломж, шударга өрсөлдөөнийг дэмжиж, хөгжин дэвжих үндсийг бүрдүүлдэг. Харамсалтай нь энэхүү баялгийг манай улс хөгжлийн хөдөлгөгч хүч болгон ашиглаж чадалгүй олон жилийн нүүрийг үзлээ. Авлига, албан тушаалын хэрэг болон нийтийн баялгийг үр ашиггүй үрэн таран хийсэн хэрэг дуулиан тасрахгүй, харин ч улам өргөжин тэлж, тогтолцооны шинжтэй болж байна. Тэрчлэн уул уурхайн бүтээгдэхүүнээс хэт хараат эдийн засагтай манай орны хувьд дэлхийн эдийн засгийн болон геополитикийн нөхцөл байдал, уур амьсгалын өөрчлөлт зэрэг хүчин зүйлс нь шинээр олон хүнд сорилтуудыг тулгаж байна.

Энэхүү нөхцөл байдалд олон намын тогтолцоо, парламентын ардчилал, төрийн хяналт тэнцвэртэй байдлыг улам бэхжүүлж, судалгаа шинжилгээ, нотолгоонд суурилсан, нөөц бололцоогоо үр ашигтай, бүрэн дүүрэн ашигласан, нухацтай, ил тод, иргэдийн оролцоо, дэмжлэгтэй төрийн бодлого боловсруулж, үр нөлөөтэй хэрэгжүүлэх шаардлага урьд урьдаас илүү тулгамдаж байна.

Энэ чиглэлд сүүлийн жилүүдэд эрх зүйн орчны нэлээд шинэчлэл хийгдсэн ч хэрэгжилтийн түвшинд замхрах, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар дэвшилттэй өөрчлөлтүүдийг буцаах хандлага лавширч байна. Тухайлбал, олон намын тогтолцоог дэмжсэн үзэл баримтлал бүхий хуулийг 2023 онд баталсан боловч, хууль бүрэн хэрэгжиж эхлээгүй байхад зарим заалтыг өөрчлөх хуулийн төслийг УИХ-р хэлэлцэж эхэлснийг улс төр судлаачид шүүмжилж буй. Тэрчлэн, УИХ-аас батлах хууль тогтоомж судалгаанд үндэслэсэн байх шаардлагыг 2015 онд хуульчлан мөрдөж буй ч хуулийн төслийг яаралтай горимоор батлах, зарим тохиолдолд дагалдах хууль нэрээр анхдагч хуулийг олон нийтийн хэлэлцүүлэггүй, судалгаа, үндэслэлийг хангалттай бүрдүүлэлгүй батлах байдал газар авч байна.

Нээлттэй нийгэм форум (ННФ) нь үйл ажиллагааныхаа үндсэн зорилгын дагуу төрийн ил тод, хариуцлагатай, нотолгоонд суурилсан бодлого боловсруулах, шийдвэр гаргах орчныг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулахыг зорин ажиллаж ирлээ. Энэ хүрээнд ардчилсан хөгжлийн тулгамдсан асуудлуудыг хөндсөн бодлогын судалгаа, дүн шинжилгээ хийж, олон талт оролцоонд тулгуурласан хэлэлцүүлэг өрнүүлэхийн зэрэгцээ иргэний нийгмийн идэвхтэй оролцоог дэмжих үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлээ.

Тухайлбал, хариуцлагын тогтолцоонд чухал үүрэгтэй бие даасан институциудын удирдлага, бүрэлдэхүүний томилгооны нээлттэй, ил тод байдлыг хангах, үүнд сонсголын механизмыг үр дүнтэй ашиглах асуудлаар холбогдох талуудад мэдээлэл өгөх, иргэний нийгмийн оролцоотой хяналт тавих, Улс төрийн намын тухай хуульд нийцүүлэн намын санхүүжилтийн цахим систем нэвтрүүлэх, улмаар олон улсын жишигт нийцсэн хайлт хийх боломжтой нээлттэй мэдээллийн сан байгуулахад СЕХ-нд техникийн туслалцаа үзүүлэх зэрэг ажлыг хэрэгжүүлсэн юм.

ННФ нь иргэний нийгмийн орон зайг бэхжүүлэх, иргэдийн оролцоог дэмжих талаар түүштай хүчин чармайлт гаргаж ирсэн билээ. Иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, жагсаал цуглаан хийх эрх чөлөө, бодлого, шийдвэр гаргах үйл явцад бодитоор оролцох эрхийн хэрэгжилтийг илэрхийлэх иргэний нийгмийн орон зайн төлөв байдлыг үнэлэх тусгайлсан аргачлал боловсрууллаа. Уг аргачлалын дагуу боловсруулсан үнэлгээ нь иргэдийн оролцоо, ИНБ-ын үр нөлөөтэй үйл ажиллагаа, тогтвортой хөгжлийг дэмжсэн бодлого, эрх зүйн орчны үнэлгээ болон иргэний нийгмийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлуудыг дүгнэсэн хэрэгжилтийн төлөв хэмээх хоёр хэсгээс бүрдэх юм. Эрх зүйн орчны үнэлгээнд олон улсын болон дотоодын тайлан, судалгааг эх сурвалж болгон ашиглаж байгаа бол иргэний нийгмийн төлөв байдлыг 60 орчим ТББ-ыг хамруулан зохион байгуулсан асуумжид тулгуурлан дүгнээд байна.

Монгол Улсын эдийн засаг өсөж байгаа хэдий ч хүн амын орлогын түвшин бодитоор нэмэгдээгүй, инфляцын дарамт өрхийн амьжиргаанд бодит хүндрэл учруулж, орлогын тэгш бүс байдал гүнзгийрч байна. Энэхүү нөхцөл байдал засаглалын чанар, нийтийн баялгийг хэрхэн удирдаж, захиран зарцуулж байгаатай шууд холбоотой билээ. Манай

байгууллагаас эрхлэн хийсэн улсын төсвийн төлөвлөлт, удирдлага, хариуцлагыг сайжруулахад чиглэсэн судалгаа шинжилгээнүүдийн дүнгээс харахад төсөв төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх үйл явцад системийн шинжтэй олон асуудал тулгамдаж байна. Үүнд төсвийн төлөвлөлт хөгжлийн бодлоготой бүрэн уялдахгүй, урсгал зардлын тэлэлт өндөр, эдийн засаг, нийгмийн үр өгөөж нь тодорхойгүй томоохон хөрөнгө оруулалтын төслүүдийг улсын төсөв болон олон улсын зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлж байгаагаас гадна УИХ-аас төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг хэлэлцэх явцад төсөв захирагчдын хөтөлбөрийн зорилт, үр дүнгийн хэрэгжилтэд хангалттай анхаарал хандуулахгүй байгаа нь ажиглагдаж байна.

Түүнчлэн, сонгуулийн мөчлөгтэй уялдан төсвийн зардлыг огцом өсгөх, санхүүжилт нь бүрэн шийдэгдээгүй олон шинэ төсөл эхлүүлснээс хэрэгжилт нь удаашран өртөг зардал нэмэгдэх болсон, улмаар үндэслэл, үр ашгийн тооцоо судалгаа муутай олон тооны мега хэмээгдэх төслүүдийг баталж, хэрэгжүүлж эхэлсэн нь Засгийн газрын өрийн дарамтыг эрс нэмэгдүүлэх эрсдэл дагуулж байгаад судлаачид шүүмжлэлтэй хандаж байна.

Мөн өнгөрсөн онд манай дэмжлэгээр хийгдсэн судалгаа, шинжилгээнүүдэд байгалийн баялаг ашиглах шийдвэр гаргах, үр өгөөжийг шударга, ил тод хуваарилах зэрэг эрдэс баялгийн салбарын засаглалын тогтолцоонд гарч буй доголдлыг онцлон авч үзсэн юм. Өнгөрсөн хугацаанд бий болсон хариуцлагагүй уул уурхайн дүр зураг, хайгуулын талбай тодорхойлох, тусгай зөвшөөрөл олгох зэрэг шийдвэр гаргахад орон нутгийн иргэдийг мэдээллээр хангаж, зөвшилцдөггүй байдал болон орон нутагт хуваарилж буй орлого, уул уурхайн бодит нөлөөлөл хоёрын зөрүү нь итгэлцлийг бууруулж, зөрчил маргаанд хүргэж байна.

Яаралтай горимоор олон нийтийн хэлэлцүүлэггүй баталсан Үндэсний баялгийн сангийн хуульд сангийн бие даасан байдал, хяналт тэнцлийн механизм, ил тод байдалд суурилсан олон нийтийн хяналт зэрэг засаглалын суурь зарчмууд орхигдсон нь хөрөнгийн удирдлагын хараат бус байдлын дархлааг алдагдуулж, тусгай сангуудын өнгөрсөн хугацааны алдаа, сургамж давтагдах эрсдэл дагуулж байна.

Энэ бүхний уг шалтгаан нь бодлого, шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангах хуулийн шаардлагын хэрэгжилт суларсанд оршино. Тухайлбал, Хууль тогтоомжийн тухай хуульд заасан олон нийтийн хэлэлцүүлэг, судалгаа шинжилгээ шаардахгүй нөхцөлүүдийг улам бүр өргөжүүлснээр өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд 130 гаруй хуулийг олон нийтээр хэлэлцүүлэлгүй баталсны 45 нь яаралтай горимоор батлагджээ. Тэрчлэн дагалдах хууль нэрээр хуулийг "бөөндөж" өөрчлөх, зарим тохиолдолд үүнд "анхдагч хууль" оруулах, түүнчлэн дагалдах хууль нь өөрөө дагалдах хуультай байсан тохиолдол ч гарав. Иймд хууль тогтоомжийн үр нөлөөг бүүруулж буй дээрх үзэгдлийг цуврал судалгаагаар баримтжуулан хэлэлцүүлэг өрнүүлсний дүнд хууль бүтээх явцад баримтлах ил тод байдал, олон нийтийн хэлэлцүүлэг, судалгаа шинжилгээнд үндэслэх шаардлагыг улам нарийвчлан хуульчлав.

Түүнчлэн, шударга ёсны тогтолцооны тулгуур институциуд болох шүүх, прокурорын байгууллагын засаглал, томилгооны ил тод байдал, хариуцлагын тогтолцоо нь иргэдийн төрд итгэх итгэлийг тодорхойлох суурь хүчин зүйл юм. Тайлант онд хийсэн судалгаа, хэлэлцүүлгийн үр дүн шүүгч, прокуроруудын сонгон шалгаруулалт, удирдлагын

томилгоо ил тод, мерит зарчимд бүрэн нийцээгүй, улмаар улс төрийн аливаа нөлөөлөлд өртөх эрсдэл оршсоор буйг харуулж байна. Энэ нь зөвхөн салбарын асуудал бус, харин хууль дээдлэх ёс, шударга ёсны тогтолцооны суурь зарчимд нөлөөлөх тулгамдсан асуудал юм. Иймд цаашид эрх зүйн шинэчлэлийг институциудын хараат бус байдлыг хангах, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх бүх шатанд ил тод байхад чиглүүлэн гүнзгийрүүлэх, үр нөлөөтэй хэрэгжүүлэх шаардлага тулгамдаж байна.

ННФ нь төрийн бодлого, шийдвэр гаргах үйл явцыг ил тод, хариуцлагатай, оролцоонд суурилсан, нотолгоонд тулгуурласан тогтолцоо болгон төлөвшүүлэхэд чиглэсэн бодлогын судалгаа, нөлөөллийн үйл ажиллагаагаа цаашид ч түүштай хэрэгжүүлэх бөгөөд институциудын хараат бус байдлыг бэхжүүлэх чиглэлээр бодлогын түвшинд байр сууриа илэрхийлж, хамтын ажиллагаагаа өргөжүүлэн ажиллах болно.

Бид 2025 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, судалгаа, бодлогын дүн шинжилгээнийхээ үр дүнг нэгтгэн [www.forum.mn](http://www.forum.mn) цахим хуудас, сошиал сувгуудаар болон "Форум" подкастын цувралаар олон нийтэд түгээн ажиллав.

Бидэнтэй хамтран ажилласан төрийн болон төрийн бус байгууллагууд, судлаачид, мэргэжилтнүүд, мөн манай үйл ажиллагаанд оролцож мэдлэг, туршлага, үзэл бодлоо хуваалцдаг иргэддээ гүн талархал илэрхийлж байна. Бидний үйл ажиллагаа болон тайлантай холбоотой асуулт, санал байх аваас манай байгууллагын [osf@forum.mn](mailto:osf@forum.mn) хаягаар бидэнд ирүүлээрэй.

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал



# АРДЧИЛСАН САЙН ЗАСАГЛАЛ

Огцрох амархан жагсаал,  
Сүхбаатарын талбай, Гэрэл  
зургийг Б.Бямба-Очир (2025.04)

## АРДЧИЛЛЫН ИНСТИТУЦИУДЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

Дэлхий дахинд ардчилал сорилттой тулгарч буй энэ амаргүй цаг үед ардчиллын институциудын бие даасан байдлыг хангах, тэдгээрийн хүний эрх, нийтийн эрх ашгийг хамгаалах, сайн засаглалыг бэхжүүлэх оролцоо юу юунаас ч чухал болоод байна.

Энэ он засаглал болон улс төрийн хүрээнд онцлох үйл явдлуудаар дүүрэн байж, ардчиллын институциудын чадавхыг сорьсон жил болж өнгөрлөө. Ялангуяа 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд хийгдсэн засаглалын институциудын шинэчлэлийн үр дүнг бодитоор шалгав. 2024 оны УИХ-ын сонгуулийн үр дүнд байгуулагдсан эвслийн Засгийн газрын бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбогдуулан Ерөнхий сайдад итгэл үзүүлэх эсэх болон огцруулах асуудлыг шинэчилсэн хуулийн дагуу анх удаа хэлэлцэж шийдвэрлэсэн. Мөн Үндсэн хуулийн цэцээс сонгуулийн хууль болон үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй хамаатай хэд хэдэн чухал шийдвэр гаргасны зэрэгцээ Ерөнхий сайдыг огцруулсан УИХ-ын шийдвэртэй холбогдох маргааныг хянан шийдвэрлэсэн нь олон нийтийн анхаарлыг татсан томоохон үйл явдал боллоо. Үүний зэрэгцээ 2023 онд шинэчлэн баталсан Улс төрийн намын тухай хуулийн дагуу намүүд их хурлаа хуралдуулан намын дүрмээ шинэчлэн бүртгүүлэх ажил өрнөсөн нь улс төрийн намын шинэчлэлд ахиц гарсан жил байсныг илтгэж байна.

### Сонгууль ба улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдал, шинэчлэл

ННФ нь ардчиллын институциудыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгынхоо хүрээнд улс төрийн санхүүжилтийн ил тод байдлыг хангахад онцгойлон анхаарч ирсэн юм. Ийнхүү 2023 онд УИХ-аас шинэчлэн баталсан Улс төрийн намын тухай хуулийг боловсруулахад техникийн туслалцаа үзүүлж ажилласан билээ. Энэ хуулийн дагуу 2025 онд Дээд шүүхэд бүртгэлтэй 37 улс төрийн намаас 28 нь анх удаа санхүүгийн тайлангаа ирүүлснийг СЕХ олон нийтэд ил тод мэдээлэв.

Улс төрийн санхүүжилтийн эрх зүйн орчинд дахин нэг томоохон дэвшил гарсан нь Катар Улсын Доха хотноо

12 дугаар сарын 15-19-ний өдрүүдэд болсон Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын Оролцогч талуудын 11 дүгээр бага хурлаар Монгол, Албани, Гана, Норвеги улсуудын хамтран санаачилсан тогтоолыг баталсан явдал боллоо. “Улс төрийн нам, сонгуульд нэр дэвшигчид болон сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх тухай” энэхүү НҮБ-ын тогтоол нь олон улсын түвшинд Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын хүрээнд улс төрийн санхүүжилтийн ил тод байдлыг хангах хүрээ, стандартыг тодорхойлж тогтоосон анхны баримт бичиг болж буй түүхэн ач холбогдолтой юм.



“Улс төрийн нам, сонгуульд нэр дэвшигчид болон сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх тухай” НҮБ-ын тогтоолын зохиогч Монгол, Албани, Гана, Норвеги улсын төлөөлөгчид (2023.12.15)

Бага хуралд Монгол Улсын төлөөлөгчдийг тэргүүлэн оролцсон Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг тогтоол батлагдсаны дараа хамтран зохиогч улс орнуудыг төлөөлөн нэгдсэн хуралдаанд үг хэлэхдээ иргэний нийгмийн байгууллагуудын оруулсан хувь нэмрийг онцлон тэмдэглэж, өндөр үнэлснийг тус бага хуралд тив тивийн 192 улсаас оролцсон 700 шахам иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл талархан хүлээж авсан юм.

ННФ нь Монгол Улс олон улсын тавцанд манлайлал үзүүлэн оролцсон дээрх тогтоолыг дэмжин Транспэрэнси Интернэшнл, Ардчилал сонгуулийг дэмжих олон улсын хүрээлэн, Ардчиллын Вестминстер сан, Олон улсын сонгуулийн тогтолцооны хүрээлэн зэрэг нэр хүнд бүхий олон улсын байгууллагуудаас гаргасан ил захидалд нэгдэн, уг тогтоолыг батлахыг улс орнуудад уриалав.

Бага хурлын үеэр Улс төрийн санхүүжилтийн ил тод байдлын асуудлаарх арга хэмжээнүүдэд идэвхтэй

оролцон дээрх тогтоол нь авлигатай тэмцэхэд онцгой ач холбогдолтой улс төрийн нам, нэр дэвшигч, сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийг ил тод болгох эрх зүйн орчныг бэхжүүлэх чухал хөшүүрэг болохыг онцлон тэмдэглэв. Мөн иргэний нийгмийн байгууллагууд энэхүү санаачилгыг дуу нэгтэй дэмжиж буйгаа илэрхийлсэн юм. Түүнчлэн бага хурлын үеэр манай судлаач Сонгуулийн төв байгууллагын төлөөлөл болон Нээлттэй нийгэм сангуудын бүсийн захиралтай үулзалт хийж, тогтоолыг хэрэгжүүлэх чиглэлээр 2026 онд тодорхой арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлэхээр санал солилцов. Энэхүү хамтын ажиллагаа нь улс төрийн санхүүжилтийн ил тод байдлын чиглэлээр манай улсын дэвшүүлж буй санаачилга, сайн туршлагыг бүс нутгийн хэмжээнд төдийгүй олон улсын түвшинд түгээн дэлгэрүүлэхэд бодит хувь нэмэр оруулна хэмээн найдаж байна.

Улс төрийн санхүүжилтийн ил тод байдлыг хангахад Монгол Улсын зүгээс олон улсын тавцанд манлайлан оролцож буй өөр нэг чухал санаачилга нь Нээлттэй Засгийн түншлэл (OGP)-ийн сорилтод нэгдсэн явдал юм. СЕХ улс төрийн намын тухай хуулийг хэрэгжүүлэхдээ цахим систем нэвтрүүлэн санхүүжилтийн ил тод байдлыг хангах, мэдээллийг олон нийтэд нээлттэй хүргэх үүрэг амлалт авч, хэрэгжүүлж байна. ННФ нь СЕХ-г уг сорилтод нэгдэх үйл явцыг дэмжиж ажилласан бөгөөд үүрэг амлалтаа үр дүнтэй хэрэгжүүлэхэд нь туслалцаа үзүүлж байна.

Нээлттэй засгийн сорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Улс төрийн намын санхүүжилтийн тайлангийн цахим систем хөгжүүлэх нь олон улсын туршлага, хэрэгцээ шаардлага” сэдэвт семинарыг СЕХ болон Транспэрэнси Интернэшнл байгууллагатай хамтран зохион байгууллаа. Уг семинар нь улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хангах, олон нийтийн хяналтыг бэхжүүлэхэд технологийн шийдэл ашиглах боломж, олон улсын туршлагаас судлах, харилцан мэдээлэл солилцоход чиглэв. Арга хэмжээнд хамтран зохион байгуулагчдаас гадна Сонгуулийн тогтолцооны олон улсын сан (IFES), Армени улсын Авлигаас сэргийлэх комисс, Английн Бристолийн Их Сургууль, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төслийн зөвлөх болон Сангийн яам, Авлигатай тэмцэх газар, Үндэсний аудитын газар, Улсын дээд шүүхэд бүртгэлтэй 37 улс төрийн намын төлөөлөл, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл оролцлоо. Нийт 40 гаруй оролцогч танхимаар, 30 гаруй оролцогч цахимаар оролцсон нь улс төрийн санхүүжилтийн ил тод байдлыг хангах асуудалд төр, нам, иргэний нийгэм, олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаа тэлж буйг илтгэх бөгөөд улс төрийн санхүүжилтийн ил тод байдлыг институцийн түвшинд бэхжүүлэх, олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх, улмаар авлигын эрсдэлийг бууруулахад чиглэсэн бодитой алхам болж байна.



“Улс төрийн намын санхүүжилтийн тайлангийн цахим систем хөгжүүлэх нь олон улсын туршлага, хэрэгцээ шаардлага” сэдэвт семинарын үеэр (2025.04)

Семинарын үеэр улс төрийн санхүүжилтийг цахим хэлбэрээр ил тод болгож буй олон улсын харьцуулсан туршлагын талаар Сонгуулийн тогтолцооны олон улсын сангийн мэргэжилтэн, олон улсад нэр хүнд бүхий улс төр судлаач Магнус Оман дэлгэрэнгүй танилцуулж, цахим тайлагналын тогтолцоог үр дүнтэй нэвтрүүлэхэд анхаарах бодлогын болон техникийн гол асуудлуудыг онцлон тэмдэглэв. Мөн улс төрийн санхүүжилтийн тайлагналын цахим системийг хэрэгжүүлж буй Латви, Армени, Английн мэргэжилтэн, судлаачид өөрсдийн орны туршлага, хэрэгжилтийн явцад тулгарсан сорилт, сургамжаас хуваалцлаа. Түүнчлэн семинарын гол

зорилго нь цахим системийн гол хэрэглэгчид болох улс төрийн нам, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулан системийн дизайн, зохион байгуулалт, үйл ажиллагааны бүтэц, шийдлийн талаар нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлж, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох боломж бүрдүүлэв. Хэлэлцүүлгийн үр дүнд оролцогчдоос цахим системийн дизайн, зохион байгуулалт, функц, мэдээллийн ил тод байдалтай холбоотой 200 гаруй тодорхой санал гарсан нь цахим системийн техникийн шаардлагыг нарийвчлан тодорхойлох, дараагийн шатны хөгжүүлэлтэд бодит суурь мэдээлэл цугласан чухал ач холбогдолтой арга хэмжээ боллоо.



Дээрх арга хэмжээний үеэр олон улсын мэргэжилтнүүдийн танилцуулсан гадаад орнуудын туршлага болон оролцогчдоос гарсан саналыг нэгтгэж ННФ-аас эрхлэн гаргадаг Чухал сэдэв цувралд нийтэллээ.



<https://forum.mn/product/588437>

Улс төрийн намын санхүүжилтийн хяналт нь шинэчлэн баталсан хуулиар СЕХ-нд шинээр олгогдсон чиг үүрэг тул энэ чиглэлээр институцийн чадавх бэхжүүлэх, олон улсын туршлага судлах, хамтын ажиллагаа өргөжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Энэ хүрээнд манай байгууллагаас улс төрийн намын санхүүгийн бүртгэл, хяналтын системийн талаар Австралийн сонгуулийн хорооны туршлагаас судлах цахим уулзалт зохион байгууллаа. Уулзалтад СЕХ-ны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ, Улс төрийн намын санхүүжилт, хяналтын газрын дарга Н.Булгамаа, Австралийн сонгуулийн хорооны Намын санхүүжилт, мэдээллийн зөвлөх Жоан Рид нар оролцож, санхүүжилтийн тайлагналын зохицуулалт, хяналтын механизм, мэдээллийн ил тод байдлыг хангах цахим шийдлийн талаар дэлгэрэнгүй санал солилцов.



Австрали Улсын сонгуулийн хорооны туршлагаас судлах цахим уулзалтын үеэр (2025.08. 11)

СЕХ-нд үзүүлж буй техникийн туслалцааны хүрээнд энэ онд Швейцарын Гадаад хэргийн яамны Энх тайван, хүний эрхийн газрын тэтгэлгээр улс төрийн намын санхүүжилтийн тайлангийн цахим системийг хөгжүүлэх, мөн улс төрийн санхүүжилтийн дүрэм журам, хуулийн шинэчлэлийн үзэл баримтлал, зорилгын талаар гол оролцогч талууд болох улс төрийн намуудад мэдээлэл өгөх, талуудад харилцан зөвлөлдөх боломж бүрдүүлэх, намуудад хуульд нийцүүлэн санхүү болон үйл ажиллагаагаа тайлагнахад арга зүйн дэмжлэг үзүүлэх цогц төслийг 2025-2026 онд хэрэгжүүлэхээр ажиллаж эхлээд байна.

Төслийн хүрээнд СЕХ-той хамтран 11-р сарын 24-ний өдөр “Улс төрийн намын ил тод байдал” үндэсний зөвлөгөөн зохион байгууллаа. Зөвлөгөөнд улс төрийн намуудын удирдлага, орон нутаг дахь гишүүд, санхүүгийн мэргэжилтнүүд төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн нийт 150 гаруй төлөөлөгч оролцон шинээр бүрэлдсэн эрх зүйн орчин, хуулийн хэрэгжилтийг хангахад цахим систем нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага, ач холбогдлын талаар санал солилцов.

СЕХ-ны зүгээс энэхүү зөвлөгөөн нь нийслэлийн болон орон нутгийн салбар нэгжийн санхүүгийн ажилтан, улс төрийн ажилтан, намын гишүүдийг хамарсан, улс төрийн намын бүх шатны байгууллагын төлөөллийг оролцуулсан анхны томоохон арга хэмжээ болсныг онцолсон юм. Мөн цаашид хуулийн хэрэгжилтийг хангах арга зүйн болон холбогдох мэдээллийг өргөн хүрээнд түгээх, намын бүх шатны байгууллагуудтай хамтран ажиллах боломж нэмэгдэж буйг тэмдэглэв.

Зөвлөгөөнөөр Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгад туссан намын санхүүжилт, үйл ажиллагааны ил тод байдлын талаарх зохицуулалт нь хуулийн үзэл баримтлал, зорилготой хэрхэн уялдаж хэрэгжих талаар танилцуулж, нэгдсэн болон гурван салбар хуралдааны хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлэв. Түүнчлэн төрийн байгууллагын мэдээллийн сан хоорондын уялдаа холбоо (interoperability)-г хангах нь улс төрийн санхүүжилтийн тайлангийн ил тод, үр ашигтай системийг хөгжүүлэхэд онцгой ач холбогдолтойг онцолж, энэ хүрээнд холбогдох төрийн байгууллагууд нээлттэй мэдээллийн системийн хөгжүүлэлт, ашиглалт дээр хамтран ажиллах талаар мөн зөвшилцсөн юм.



“Улс төрийн намын ил тод байдал” сэдэвт үндэсний зөвлөгөөний үеэр (2025. 11.24)

Түүнчлэн дээрх зөвлөгөөнд ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Энхцэцэг улс төрийн намын санхүүжилтийн олон улсын сайн туршлагыг Канад, Латви, Англи зэрэг улсын жишээнд үндэслэн харьцуулж, танилцуулаа.

Мөн СЕХ-оос манай байгууллагатай эхлүүлсэн хамтын ажиллагааны хүрээнд намын санхүүгийн тайланг гаргах арга зүйн нарийвчилсан зөвлөгөө, мэдээлэл өгөх уулзалт зохион байгууллаа. Уулзалтад улс төрийн намын удирдлага, санхүү хариуцсан удирдах ажилтнууд оролцов.



Уулзалт, хэлэлцүүлэгт Улсын дээд шүүхэд бүртгэлтэй 37 намаас 14 намын төлөөлөл оролцов. Үндэсний номын сангийн “Сонгуулийн боловсрол, эрх зүйн үншлагын танхим” (2025.12.22)

Цаашид улс төрийн олон ургалч үзлийг хөхиүлэн дэмжиж, хуулийн хүрээнд улс төрд оролцогч талууд тэгш өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, улс төрийн санхүүжилтийн ил тод байдлыг сайжруулахын тулд эрх зүйн зохицуулалтын үялдаа холбоог боловсронгуй болгох шаардлага тулгарч байна. Одоогийн байдлаар сонгуулийн болон сонгуулийн бус үеийн улс төрийн санхүүжилтийг тусдаа хуулиудаар зохицуулж, хяналтын чиг үүргийг хоёр өөр байгууллага хэрэгжүүлж буй нь зохицуулалтын давхардал, хийдэл үүсгэх эрсдэлтэй тул энэхүү зохион байгуулалтыг дахин авч үзэх хэрэгцээ бий. Энэ хүрээнд манай байгууллагаас холбогдох хуулиудад

ялгаатай байдлаар тусгасан зохицуулалтуудыг тодруулан дүн шинжилгээ хийж, хуулиудын нийцлийг хангахад чиглэсэн санал зөвлөмж боловсруулахаар ажиллаж байна.

Ийнхүү шинээр бүрэлдсэн эрх зүйн орчны хэрэгжилтийг хангах чиглэлд чамлахааргүй санал санаачилгууд гарч, үүнд төрийн байгууллагууд төдийгүй олон улсын болон дотоодын иргэний нийгмийн байгууллагууд хичээл зүтгэл гарган оролцож буй энэ үед УИХ-д Улс төрийн намын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн барив.



Хараахан бүрэн хэрэгжээгүй байгаа Улс төрийн намын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн дөрвөн заалтыг өөрчлөх, нэг заалтыг хүчингүй болгохоор тусгасан хуулийн төслийн талаар МУБИС-ийн багш, дэд профессор, улс төр судлаач доктор (PhD) Э.Гэрэлт-Од болон манай судлаач Д.Энхцэцэг нар хамтран шүүмж боловсруулж бодлого боловсруулагчдад хүргэлээ.



<https://forum.mn/product/571505>

Шүүмжид дурдсанаар уг хуулийн төсөл нь бүхэлдээ намын санхүүжилтийг зохицуулж буй зүйл, хэсгийг өөрчлөхөд чиглэсэн байх бөгөөд улс төрд эргэлдэх мөнгөний урсгалд тавих хяналтыг сулруулах, төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс намууд шударга нөхцөлөөр хүртэх боломжийг багасгах, улс төрд тэгш гараанаас өрсөлдөх хөшүүргийг сулруулах эрсдэл дагуулж болзошгүй хэмээн дүгнэжээ.



Улс төрийн намын тухай хууль (шинэчилсэн найруулга)-д өгсөн шүүмж, зөвлөмжийг танилцуулах хэлэлцүүлэг (2025.06.24)

## Үндсэн хууль ба хяналт-тэнцлийн тогтолцоо

Тайлант онд Монгол Улсын Үндсэн хуулийн цэц сонгуулийн хууль тогтоомжтой холбоотой хэд хэдэн чухал шийдвэр гаргалаа. Үүнд, сонгогдох эрхийн хүрээ, нэр дэвшигчид тавих шаардлага, сонгуулийн өрсөлдөөний тэгш гарааны зарчим, сонгуулийн хувь тэнцүүлсэн өрсөлдөөнд намуудад суудал хуваарилахад баримтлах босго зэрэг сонгуулийн эрх зүйн суурь асуудлуудыг хөндсөнөөрөө цаашдын эрх зүйн хэрэглээнд номлол болох ач холбогдол бүхий шийдвэрүүд байв. Тухайлбал 2-р сарын 6-ны

өдөр гаргасан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41- дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн дүгнэлтэд ННФ-аас 2024 оны УИХ-ын сонгуулийн талаар гаргасан ерөнхий тойм, ажиглалтыг эш татсан нь иргэний нийгмийн байгууллагуудын хараат бус дүн шинжилгээ, бодит ажиглалтыг эрх зүйн маргаан шийдвэрлэх явцад харгалзан үзэж буй бодит жишээ болсныг дурдахад таатай байна.



УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 41.9-д “Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй” гэж заасан. Түүнчлэн, хуулийн 44.6-д “Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн үүлзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй” гэжээ.


УИХ-ын гишүүд сонгогчдодоо ажлаа тайлагнах нь зүй ёсны асуудал боловч хуулийн дээрх заалтууд нь сонгуулийн жил эрх баригчдад давуу тал олгон тэгш гараанаас өрсөлдөх нөхцөлийг дордуулаад зогсохгүй сонгуулийн жил төрийн эх үүсвэрийг улс төрийн сурталчилгааны зорилгоор ашиглах нөхцөлийг бүрдүүлж байна. Ардчилал сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэнгийн 80 гаруй ардчилсан улсын хууль тогтоомжийг түүвэрлэн судалснаас үзэхэд зөвхөн Өмнөд Солонгос улсын хуульд Үндэсний Ассамблейн гишүүн сонгогчдод ажлаа хэрхэн тайлагнах талаар зохицуулсан байдаг байна. Ингэхдээ сонгуулийн өрсөлдөөний тэгш гарааг хангах үүднээс санал хураахаас өмнөх 90 хоногт хэвлэмэл тайлан тараах, үүлзалт зохион байгуулах зэргийг хориглодог ба зөвхөн цахим шуудан, өөрийн интернэт цахим хуудсаар дамжуулж тайлагнахыг зөвшөөрдөг ажээ. Энэтхэг улсын хуулиар парламентын гишүүд албаны томилолтыг сонгуулийн сурталчилгаатай зэрэгцүүлж ашиглахыг хориглодог байна.

Ерөнхий тойм: Монгол Улсын Их Хурлын сонгууль-2024

Чөлөөт, шударга сонгуулийн зарчмуудтай холбоотой зарим анхаарал татсан асуудлууд, 10-р тал

Манай байгууллагаас Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцээс ирүүлсэн хүсэлтийн дагуу сонгуулийн эрхийн асуудлаар мэргэжлийн дүгнэлт гаргаж өгөх ажлыг мөн гүйцэтгэлээ. Түүнчлэн, Цэцийн

шийдвэрүүд цаашид сонгуулийн эрхийг баталгаатай ханган хамгаалахад ямар нөлөө үзүүлэх талаар сэтгүүлчдийг оролцуулсан үүлзалт зохион байгуулсан юм.




Улс төр судлаач Д.Оргил, Бодлогод залуусын хяналт ТББ-ын гүйцэтгэх захирал Ц.Мандхайхатан нар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс гаргасан сонгуулийн хууль тогтоомжтой холбоотой дүгнэлт, шийдвэрүүдийн талаар илтгэл танилцуулж буй нь (2025.04.02)

2019 онд Үндсэн хуульд туссан нэг чухал нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд “Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно” гэсэн зохицуулалт тусгагдсан нь сонгуулийн эрх зүйн тогтвортой байдлыг хангах ач холбогдолтой заалт болсон билээ.

Үүнтэй холбоотой 2028 оны ээлжит сонгуулийг угтан хууль тогтоомжийн шинэчлэлийн асуудал ирэх оноос идэвхтэй яригдах нь тодорхой юм. Бодлогын шинэчлэл, мэтгэлцээнд хувь нэмэр

оруулах зорилгоор энэ онд бид хэд хэдэн судалгааг уншигчдын хүртээл болгов. Үүнд, сум, аймаг, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тойрог, мандатыг шийдвэрлэж байгаа процессын талаарх судалгааг Х.Адилмаа, Л.Амгаланбаатар, Х.Норовсүрэн, Б.Жавхлан тэргүүтэй залуу судлаачид, УИХ-ын сонгуулийн мажоритар тойргуудын мандатыг зохистой хуваарилах асуудлаарх судалгааг Агора институцийн судлаач Д.Оргил, сонгуулийн маргааны шийдвэрлэлтийг боловсронгуй болгох асуудлаарх судалгааг Б.Баялагмаа тэргүүтэй залуу судлаачид тус тус хийж гүйцэтгэлээ.



<https://forum.mn/product/588681>



<https://forum.mn/product/596983>



<https://forum.mn/product/588437>



Монгол Улсын тусгаар тогтнолын асуудлаар бүх ард түмний санал асуулга явуулсны 80 жилийн ойг тохиолдуулан СЕХ, ҮХЦ, “Чимид сан”, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн хамтран Төр, нийгмийн зүтгэлтэн, ардчилсан Үндсэн хуулийн эхийг баригч, Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч, доктор, профессор Бяраагийн Чимидийн “Сонгуульд суралцахуй” номын уншлагыг 10 дугаар сарын 20-ны өдөр зохион байгууллаа. Тус арга хэмжээнд манай Засаглалын хөтөлбөрийн менежер Д. Энхцэцэг “Сонгуулийн сурталчилгаа, санхүүжилт” сэдвээр илтгэл танилцуулан оролцов. Энэхүү үйл ажиллагааны эх сурвалж болсон Б.Чимидийн “Сонгуульд суралцахуй” номыг 2008 оны УИХ-ын ээлжит сонгуулийн үеэр манай байгууллагаас сонгогчдын боловсролд зориулж хэвлэн нийтэлж байсан түүхтэй билээ.

Ийнхүү тайлант онд ННФ-аас улс төрийн намын санхүүжилт, ил тод байдал, тэгш, шударга



сонгуулийн эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн судалгаа мэдээллээр дэмжих, техникийн туслалцаа үзүүлэх, Монгол Улсын бүс нутаг болон олон улсын тавцанд үзүүлж буй санаачилга, манлайллыг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлээ.

Дээрх судалгааны тайланд салбарын эрдэмтэд, экспертүүдийн шүүмжийг тусгахаас гадна олон нийт, бодлого боловсруулагчдад танилцуулах хэлэлцүүлгүүдийг зохион байгуулав. Онцолбол, сонгуулийн маргаан шийдвэрлэлтийг боловсронгуй болгох асуудлаар хийсэн судалгааны дүнг танилцуулан, шүүмж өрнүүлсэн бөгөөд хэлэлцүүлгээс гарсан зарим саналыг тус судалгааны зөвлөмжид тусгалаа.



Сонгуулийн маргаан шийдвэрлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох асуудлаарх судалгааны тайлангийн үр дүнг танилцуулах хэлэлцүүлгийн үеэр (2025.11.20)

### Ардчиллын институциуд, төрийн ил тод байдал

Үндсэн хууль болон түүнд удаа дараа оруулсан нэмэлт, өөрчлөлт, тэдгээрийн улс төрийн динамик, бодит үр нөлөөний талаар бодлого боловсруулагчид болон олон нийтийн дунд өрнөж буй хэлэлцүүлэгт хувь нэмэр оруулах, Үндсэн хуулийн эрх зүй судлаачдын байр суурийг түгээх зорилгоор Хууль зүйн ухааны доктор, дэд профессор О.Машбатын “Төрийн эрх мэдлийн хянал-тэнцлийн тогтолцоонд хийсэн тохиргоо: шалтгаан үр дүн” сэдэвт судалгааг нийтлэн уншигчдын хүртээл болгов.

Түүнчлэн зохиогчийн оролцсон “Сонгодог парламентын эрэлд” сэдэвт хэлэлцүүлгийг 6 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан бөгөөд уг арга хэмжээнд УИХ-ын гишүүд, улс төр болон эрх зүй судлаач эрдэмтэд, улс төрийн нам, иргэний нийгмийн төлөөлөл оролцон парламентын институцийн түүхэн хөгжил, засаглалын онцлогийн талаар хэлэлцэв. Хэлэлцүүлгийн хүрээнд “сонгодог” парламентын загвар гэж бий эсэх талаар хэлэлцэн сонирхолтой мэтгэлцээн өрнөсөн юм.

Судалгаанд Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийг “Үндсэн хуулийн реализм”-ын хандлагаар шинжилж, анх батлагдах үеийн улс төрийн зөвшлийн үр дүнд бий болсон “програмчилагдсан зөрчил” нь төрийн эрх мэдлийн хуваарилалт, хяналт-тэнцлийн тогтолцоонд хэрхэн нөлөөлж ирснийг тайлбарлажээ. Хуулийн төслийг боловсруулсан болон хэлэлцэн баталсан

үеийн улс төрийн ашиг сонирхлын зөрчил, тэдгээрийн буулт-зөвшлийн үр дүнд бий болсон институци хоорондын үл нийцэл, Засгийн газрын тогтворгүй байдалд нөлөөлсөн сонгуулийн мөчлөгийн уялдаа, “зөвшилцөх” ойлголтын тайлбарын маргаан зэрэг бодит улс төрийн динамикийг түүхэн жишээ, эрх зүйн өөрчлөлтийн үр дагавартай уялдуулан авч үзсэн байна. Улмаар 2000, 2019, 2022, 2023 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд нь дээрх “програмчилагдсан зөрчил”-ийг шат дараатайгаар засахад чиглэж, Ерөнхий сайдыг томилох журам, итгэл үзүүлэх болон эс үзүүлэх механизм, сонгуулийн мөчлөгийн асинхрончлол зэрэг зохицуулалтаар дамжуулан гүйцэтгэх засаглалын тогтвортой байдлыг бэхжүүлэх зорилготой байсныг судалгаанд онцлон тайлбарлажээ.



[https://forum.mn/uploads/users/3093/files/Asuudal\\_Ergetsuulel%20\(6\)-HEWLELTED.pdf](https://forum.mn/uploads/users/3093/files/Asuudal_Ergetsuulel%20(6)-HEWLELTED.pdf)

2019 болон 2023 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн нэг чухал зорилго нь парламентын институцийг бэхжүүлэх, гүйцэтгэх засаглалд хяналт тавих чадавхыг сайжруулахад чиглэж, улмаар УИХ-ын суудлын тоог 126 болгон нэмэгдүүлсний дээр сонгуулийн тогтолцоог хосолсон холимог болгон өөрчилсөн билээ. Шинэчлэлийн анхны үр дүн 2024 оны сонгуулиар бүрэлдсэн УИХ-д илэрч, өмнөх парламентуудтай харьцуулахад УИХ-д сөрөг хүчний төлөөлөл хоёр дахин нэмэгдсэн явдал болсон юм. Бүрэлдэхүүний хувьд гарсан энэхүү дэвшил нь парламентын бодит үйл ажиллагаанд хэрхэн үр

дүнтэй нөлөө үзүүлж буй нь шинэчлэлийн үр дүнг илтгэх гол шалгуур мөн болно.

Үүнтэй холбогдуулан “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хэрэгжилт” судалгааг гүйцэтгэхэд Цогц Хөгжлийн Үндэсний Төв ТББ-д дэмжлэг үзүүлэв. Судалгааны хүрээнд тус хууль болон парламентын үйл ажиллагааг зохицуулж буй бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтийн явц, тэдгээрт тулгарч буй хүндрэл, зөрчил, практик асуудлыг тодорхойлон шинжилж, цаашдын эрх зүйн шинэчлэлд чиглэсэн бодлогын зөвлөмж боловсруулахад анхаарч ажиллаж байна.



**“Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хэрэгжилт” судалгааны урьдчилсан дүнгээс үзэхэд:**

- Чуулганы дэгд гишүүдийн эрх тэгш оролцоо, цөөнхийн байр суурийг хамгаалах зохицуулалт туссан боловч хэрэгжилт хангалтгүй байна. Үг хэлэх, асуулт асуух хугацааг нам, эвслийн суудлын тоонд хувь тэнцүүлэн хуваарилж буй нь олонхын давуу байдлыг баталгаажуулж, цөөнхийн дуу хоолойг хязгаарлах нөхцөл үүсгэжээ.
- УИХ-ын даргын дэргэдэх Зөвлөл хэлэлцэх асуудал, дараалал тогтооход чухал нөлөөтэй ч үйл ажиллагааны журам, шийдвэр гаргалтын ил тод байдал хангалтгүй байна. Асуудлыг ямар шалгуураар хэлэлцэх жагсаалтад оруулж буй нь нээлттэй бус байгаа нь парламентын ил тод байдал, гишүүдийн тэгш оролцоонд сөргөөр нөлөөлж байна.
- Хэдийгээр дэгийн тухай хуульд гишүүн бүр тэгш эрхтэй байхаар тусгасан ч практикт намын харьяалал, олонх цөөнхийн харьцаа, хурал даргалагч болон бүлгийн удирдлагын нөлөөллөөс шалтгаалан оролцооны боломж, хууль тогтоох үйл явцад нөлөөлөх чадавх ялгаатай байна. Энэ нь парламентын дотоод ардчилал, төлөөллийн чанарт сөргөөр нөлөөлж байна.
- Хууль, тогтоолын төслийг яаралтай горимоор хэлэлцэн батлах практик түгээмэл болсон бөгөөд уг горимын шалгуур тодорхой бус байгаагаас олон нийтийн хэлэлцүүлэг, судалгаа дутмаг хууль батлагдах нөхцөл бүрдэж, улмаар хүний эрхэд сөрөг нөлөө үзүүлэх, парламентаар баталсан хууль тогтоолын чанар муу байх зэрэг эрсдэл бодитоор бий болсон.
- Ерөнхий сайдад асуулт тавих “асуулгын цаг” нь чухал механизм мөн ч урьдчилан бичгээр хүргүүлэх шаардлага, хариултын чанарт хяналт тавих болон танхимын мэтгэлцээний боломж хязгаарлагдмал байгаа нь хяналтын үр нөлөөг сулруулж байна.
- Ил тод байдлын хувьд чуулганы хуралдааны тэмдэглэл, дуу дүрс бичлэгийг олон нийтэд нээлттэй байршуулах эрх зүйн зохицуулалт бий ч практикт цаг тухайд нь бүрэн байршуулдаггүй. Энэ нь иргэд, судлаачид, хэвлэл мэдээлэл парламентын үйл ажиллагааг бодитоор хянах боломжийг бууруулахад нөлөөлж, үнэлгээ, хариуцлагын механизмыг сулруулж байна.

Дээрх судалгаанаас гадна Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийн асуудлаар хийгдсэн бусад хэд хэдэн судалгааны үр дүнг оролцогч талуудад

танилцуулах хэлэлцүүлгийг 4 дүгээр сард зохион байгууллаа.

## Хараат бус институци, нээлттэй сонсгол ба мэдээллийн илт тод байдал

Ардчилсан тогтолцоонд шударга, зарчимч байдлыг хангах, үндсэн хуульт ардчиллыг бататгах, нийтийн эрх ашгийг хамгаалахад бие даасан агентлагуудын үүрэг оролцоо чухал билээ. Энэ үүднээс Ардчилал, сонгуулийг дэмжих олон улсын хүрээлэн эдгээр институцийг “засаглалын дөрөв дэх салаа мөчир” хэмээн нэрлэж, “Улс төрийн хувьд төвийг сахисан, төрийн эрх мэдлийн гурван салаа мөчрөөс хараат бус, шударга ёсыг сахиулж, ардчилсан засаглалын чанар, тогтвортой байдлыг хангах зорилго бүхий нийтийн эрх зүйн этгээд” гэж тайлбарладаг. Улс төрийн болоод институцийн хувьд хараат бус байх нь ардчилсан тогтолцоонд хүлээх үүргээ гүйцэтгэх гол нөхцөл болно.

ННФ-аас бие даасан институциудын удирдлага, бүрэлдэхүүнд тавигдах шалгуурыг чиг үүрэгтэй нь уялдуулан тодорхой болгох, томилгооны үйл явцыг нээлттэй, илт тод болгох, үүнд сонсголын механизмыг үр дүнтэй ашиглах замаар эрх зүйн орчныг боловсронгуй болгоход анхаарч ирсэн билээ.

УИХ-аар Монгол Улсын Ерөнхий аудиторыг томилох, чөлөөлөх тухай асуудлыг 5 дугаар сард хэлэлцсэн бөгөөд уг шийдвэрийг угтан “Төрийн аудитын хараат бус байдал ба Ерөнхий аудиторын томилгоо” сэдэвт нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж, Оюуны инноваци ТББ-ын гүйцэтгэх захирал Б.Төрболд илтгэл танилцууллаа.

Хэлэлцүүлгээр хөндсөн асуудлыг олон нийтэд өргөнөөр хүргэх зорилгоор Форум подкастын №13 дугаараар ярилцаж, хараат бус хяналтын байгууллагуудыг яагаад “дөрөв дэх засаглалын байгууллага”-ууд гэж нэрлэдэг, удирдлагын томилгоо болон сонсголын ач холбогдол, МУ-ын Ерөнхий прокурор, АТГ-ын даргыг улираан томилох, Ерөнхий аудиторыг нөхөн томилохдоо сонсгол хийхгүй байгаа нь хуулийн үндэслэлтэй эсэх зэрэг асуудлаар дэлгэрэнгүй ярилцав. Мөн Ерөнхий аудиторын айсуй томилгоонд анхаарвал зохих асуудлын талаар хөндсөн юм.



Хараат бус хяналтын байгууллагууд буюу дөрөв дэх засаглалын институциудын тухай, тус байгууллагуудын томилгоо болон нээлттэй сонсголын талаар Оюуны Инноваци ТББ-ын Гүйцэтгэх захирал, эрх зүйч, судлаач Б.Төрболдтой ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Энхцэцэгийн ярилцсан дугаар

<https://www.youtube.com/watch?v=P-o5ultHlpA&t=26s>

Томилгооны сонсголоос гадна Нийтийн сонсголын тухай хуульд заасан бусад хэлбэрийн сонсголыг иргэний нийгмийн байгууллагууд оролцооны үр нөлөөтэй арга хэрэгсэл болгон ашиглах чадавхыг бэхжүүлэхэд анхаарч, видео болон танхимын сургалт тогтмол зохион байгуулж ирсэн билээ. Энэ хүрээнд 7

дугаар сарын 2-ны өдөр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр болон Бодлогод залуусын хяналт ТББ-ын урилгаар орон нутгийн иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөлд зориулан “Нээлттэй сонсгол” сургалт явуулав.



Сургалтын үеэр зохион байгуулсан туршилтын буюу mock сонсгол нь энэхүү оролцооны механизмын талаар илүү гүнзгий ойлголт авч, практик үр чадвар эзэмшихэд дөхөм болсон гэж оролцогчид онцлон тэмдэглэв.

ННФ-ын үйл ажиллагааны нэг чухал чиглэл нь засаглалын асуудлаарх бодлогын хэлэлцүүлэгт хувь нэмэр оруулах, дэмжихэд анхаарч ирсэн явдал билээ. 2025 онд олон улсын ардчиллын судалгааны В-Дем байгууллагын үнэлгээгээр Монгол Улс анх удаа сонгуульт ардчиллаас ухарч, сонгуульт

авторитари хэв шинжид дөхөж буй дүн гарсан юм. Үүнтэй холбогдуулан тус судалгааны хүрээлэнгийн хөндлөнгийн эксперт, Германы Маннхеймын Их Сургуулийн Нийгмийн ухааны сургуулийн декан доктор Жулиан Дьеркесийн оролцоотой хэлэлцүүлэг зохион байгууллаа.



Хэлэлцүүлэгт улс төр судлаач эрдэмтэд, иргэний нийгмийн төлөөлөл, сэтгүүлчид оролцон В-Дем байгууллагын индекс Монгол Улсын байр суурь өөрчлөгдөхөд ардчиллын ямар үзүүлэлтүүд голлон нөлөөлсөн тухай арга зүйн талаар ярилцсан санал солилцсон юм. (2025.04. 25)

Манай байгууллага стратегийнхаа хүрээнд мэдээллийн ил тод байдлыг сайжруулах, мэдээллийн эрүүл орчныг дэмжих чиглэлээр иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжихэд онцгой анхааран хамтран ажиллаж ирлээ.

Энэ хүрээнд нийтийн сүлжээн дэх хуурмаг мэдээллийн асуудлаарх судалгааг Германы Томсон сан, Монголын эрэн сурвалжлагчдын төлөө төв ТББ-тай хамтран 2024-2025 онд гүйцэтгэж, судалгааны үр дүнг танилцуулах хэлэлцүүлгийг 2 дугаар сард зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт Канад, Япон, АНУ, Их Британийн элчин сайдын яамдын төлөөлөл, улс төр судлаачид сэтгүүлчид оролцож, судлаачдаас асуулт тодруулан сонирхолтой хэлэлцүүлэг өрнүүлэв. Нийгмийн сүлжээг мэдээллийн гол эх сурвалж болгон ашигладаг идэвхтэй хэрэглэгч олонтой манай орны хувьд иргэдийн мэдээллийн боловсролд анхаарахаас гадна хиймэл оюун болон технологийн бусад шийдлийг хуурмаг мэдээлэлтэй тэмцэхэд ашиглах арга замыг хайх нь чухал байгаа талаар хэлэлцүүлгийн үеэр онцолж байв.

Түүнчлэн 12-р сарын 11-нд Глоб Интернэшнл ТББ-аас "Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө - Иргэний орон зайн баталгаа болох нь" сэдэвт олон талт хэлэлцүүлэг зохион байгуулахад дэмжигчээр оролцов. Хэлэлцүүлэгт ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Эрдэнэчимэг "Олборлох салбарын ил тод байдал" сэдвээр илтгэл танилцуулан олборлох салбарт гэрээний болон эцсийн өмчлөгчийн мэдээллийн ил тод байдал хангалтгүй хэвээр байгаа талаар шүүмжлэл өрнүүлэв.



Эрдэс баялгийн салбарт ил тод байдлын санаачилга 20 жилийн хугацаанд хэрэгжиж байгаа боловч нээлттэй мэдээллийн стандартыг бүрэн хангахгүй бол энэ салбарыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангижруулж чадахгүй.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн шийдвэрээр 2003 оноос эхлэн жил бүрийн 12-р сарын 9-ний өдрийг Авлигын эсрэг олон улсын өдөр болгон тэмдэглэдэг уламжлал тогтсон билээ. Эл өдрийг угтан Бодлогод залуусын хяналт ТББ-аас зохион байгуулдаг "Дата эрх чөлөө" үзэсгэлэнг жил бүр дэмжин оролцож ирсэн бөгөөд тайлант онд тав дахь удаагаа зохион байгуулагдсан уг арга хэмжээнд шүүхийн хараат бус байдал, сонгуулийн судалгааны тоон мэдээлэл болон холбогдох өгөгдлийг олон нийтэд ойлгомжтой дүрслэлээр танилцуулсан юм.



"Дата эрх чөлөө" үзэсгэлэнд ННФ-ын Эрх зүйн хөтөлбөрийн менежер П.Бадамрагчаа "Шүүхийн индекс" судалгааг танилцуулж буй нь (2025.12.09)

ННФ нь иргэний нийгмийн байгууллагууд нээлттэй мэдээлэл ашиглан төрийн үйл ажиллагаанд хяналт тавих, технологийн дэвшил ашиглан хариуцлагыг нэмэгдүүлэх санаачилгуудыг түүштай дэмжиж, санхүүгийн болон мэргэжлийн түслалцаа үзүүлж хамтран ажиллаж ирсэн юм.

## ИРГЭНИЙ НИЙГМИЙН ОРОН ЗАЙН ХӨТӨЛБӨР

Иргэний нийгмийн идэвхтэй, үр нөлөөтэй оролцоо нь ардчиллын амин сүнс юм. Иргэд ганцаар болон эвлэлдэн төр, нийгмийн амьдралд оролцох орон зайг хууль эрх зүйн орчноор хамгаалж, хэрэгжилтийг практикаар баталгаажуулах нь ардчилсан төрийн иргэдийнхээ өмнө хүлээсэн үүрэг билээ. Гэвч сүүлийн арав гаруй жилд дэлхий нийтээр ардчиллын чанар доройтож, иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, жагсаж цуглах, мэдээлэл авах эрхэд халдах замаар иргэний нийгмийн орон зайг хүмийх үзэгдэл өрнөж байгааг олон улсын индекс, үнэлгээнүүд баримтжуулаад байна. Манай улсад ч мөн ардчиллын чанар сулрах үзэгдлийг дагаад иргэний нийгмийн орон зайн хүмийгдаж буйг В-Дем хүрээлэнгийн Ардчиллын индекс, СИВИКУС олон улсын байгууллагын Иргэний нийгмийн орон зайн мониторинг, мөн идэвхтэй иргэн, иргэний нийгмийн байгууллагуудын туршлага, ажиглалтаас харж болох ч тоймтой судалгаа алга байна.

Иймээс хөтөлбөр нь иргэний нийгмийн орон зайн төлөв байдлын үнэлгээг санаачлан хэрэгжүүлж, мөн ТББ-ын эрх зүйн орчны тулгамдсан болон шинэлэг асуудлаар судалгаа гүйцэтгэлээ. Мөн иргэний нийгмийн оролцооны чухал арга механизм болох стратегийн өмгөөллийг дэмжихийн зэрэгцээ ИНБ-уудын дунд ардчилал, иргэний нийгмийн асуудлуудаарх чөлөөт хэлэлцүүлэг өрнүүлэв. ИНБ-уудад зориулсан [www.cso.mn](http://www.cso.mn) сайтаараа дамжуулан тэтгэлэг, арга хэмжээний зар, мөн шинэ судалгаа, шинжилгээний тоймыг хүргэсээр байна.

### Иргэний нийгмийн орон зайн үнэлгээ

ННФ нь энэ чухал асуудлаар нотолгоо бүрдүүлэх, мэдээллийг системтэй болгох зорилгоор тайлант онд иргэний нийгмийн орон зайн төлөв байдлыг үнэлэх тусгайлсан аргачлал боловсрууллаа. Уг аргачлал нь СИВИКУС байгууллагын "Дэлхий нийтийн иргэний нийгмийн орон зайн рейтинг", Европын Суурь эрхийн хүрээлэнгийн Европын үнэлгээ болон бусад улс орны туршлагад тулгуурласан болно. Үнэлгээний тайлан нь иргэний оролцоо, ИНБ-ын тогтвортой байдал болон үр нөлөөтэй үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн орчны үнэлгээ болон эрх зүйн орчны хэрэгжилт, иргэний нийгмийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлуудыг дүгнэсэн хэрэгжилтийн төлөв хэмээх хоёр хэсгээс бүрдэнэ. Эрх зүйн орчны үнэлгээнд олон улсын болон дотоодын тайлан, судалгааг эх сурвалж болгон ашиглаж байгаа бол иргэний нийгмийн төлөв байдлыг 12 дугаар сард 60 орчим ТББ-ыг хамруулан

зохион байгуулсан асуумжид тулгуурлан дүгнэлээ.

Урьдчилан дүгнэхэд, манай улсын эрх зүйн орчин иргэний нийгэмд ерөнхийдөө ээлтэй байгаа ч нөхцөл байдал тогтворгүй, муудах эрсдэл буураагүй байна. Нэг талаас иргэний нийгмийн идэвх, оролцоонд эерэг нөлөөтэй Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн төсөл зэрэг, нөгөө талаас иргэдийн суурь эрхэд сөрөг нөлөөтэй Холбооны болон Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Цахим орчинд хүний эрхийг хамгаалах тухай хууль (Ерөнхийлөгч хориг тавьсныг УИХ хүлээн авснаар хүчингүй болсон) зэрэг санаачилга гарч байгаа нь эрх зүйн орчныг анхааралтай ажиглах хэрэгцээг үүсгэж байна. Хяналтын бие даасан механизм болох зарим институци иргэний нийгмийн орон зайд

ээлтэй шийдвэрүүд гаргаж байна. Үүнд, жишээлбэл, Хүний эрхийн үндэсний комиссын жагсаал, цуглааны явцад хийсэн ажиглалт дүгнэлтүүд, Үндсэн хуулийн цэцээс гаргасан Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр заалт (Гүтгэх)-тай холбоотой дүгнэлт зэрэг нь үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хамгаалахад чухал алхам боллоо.



Огцрох амархан жагсаалын үеэр Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих холбооны захирал Ш.Ариунаа, Ийгл телевизийн сэтгүүлч Г.Улсболд нар (2025.04). Гэрэл зургийг Д.Энхцэцэг

Эрх зүйн орчны хэрэгжилт, иргэний нийгмийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлох зорилготой асуумжийн урьдчилсан дүнгээс харахад эрх зүйн орчинд ноцтой өөрчлөлт ороогүй хэдий ч төрийн байгууллагуудын үйл ажиллагаа зарим талаар хаалттай илүү чирэгдэлтэй болж,

## Татварын орчны судалгаа

1997 онд батлагдсан Төрийн бус байгууллагын тухай хуулийг шинэчлэх санаачилга 2005 оноос хойш тасралтгүй өрнөж буй ч өнөөг хүртэл тодорхой үр дүнд хүрээгүй байна. ННФ нь ТББ-ын эрх зүйн орчныг сайжруулахад хувь нэмэр оруулах зорилгоор

мэдээллийн олдоц болон оролцооны чанар дордож буйг оролцогчид онцолж байна. Иргэний нийгмийн зохион байгуулалттай хэсэг болох ТББ-уудад бодлогын дэмжлэг дутсаны улмаас санхүүгийн болон хүний нөөцийн тогтворгүй байдал нүүрлэхийн зэрэгцээ бодлого, шийдвэрт оролцох боломж хумигдаж, үйл ажиллагааны үр нөлөө буурах эрсдэл үүсжээ. Хамгийн их бэрхшээлийг жагсаал, цуглаанд оролцогчид туулсан байх ба ноцтой нь, олон нийтээс далдуур айлган сүрдүүлэх, нийгмийн сүлжээнд зохион байгуулалттайгаар харлуулах, өөрийг нь болон гэр бүлийнхнийг нь ажлаас халах, бизнесийг нь хааж боогдуулах зэрэг үйлдлээр дарамталж байна.

Дэлхий нийтээр КОВИД 19-ийн цар тахлын үеэр иргэний нийгмийн идэвхтэн, байгууллагуудын үр нөлөөтэй оролцоо, хамгаалагдсан байдал эрс муудсан ч эргээд сэргэсэн бол Монголд иргэний суурь эрхүүдийн хэрэгжилт цар тахлын хязгаарлалттай үеийнхээс нэг их сайжраагүй гэж дүгнэж болно. 2021 онд батлагдсан Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах замаар иргэний нийгмийн идэвхтэн, манлайлагчдын хамгаалалт, аюулгүй байдлын баталгааг сайжруулах нь нэн тулгамдсан асуудал болжээ.

Монгол Улс дах иргэний нийгмийн орон зайн төлөв байдлын 2025 оны үнэлгээний тайланг 2026 оны эхний улиралд багтаан олны хүртээл болгох төлөвлөгөөтэй ажиллаж байна.

хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэвэл зохих асуудлуудаар цуврал судалгаа гүйцэтгэж ирсэн билээ. Энэхүү ажлын хүрээнд тайлант онд судлаач Э.Тамир ахлагчтай баг ТББ-ын тодорхойлолт, ангилал, татварын хөнгөлөлт үзүүлэх нөхцөлийн хэрэглээ

зэрэг тулгамдсан асуудлыг хамруулсан судалгаа гүйцэтгэж, бусад орны туршлагад тулгуурлан, бодлогын зөвлөмж боловсруулаа.

Өөрийн олсон хөрөнгө, нөөцийг ашиг болгож хуваарилахгүйгээр нийгмийн сайн сайхны төлөө үйл ажиллагаанд зарцуулж ажилладаг тул ТББ-ыг орлогын татвараас чөлөөлөх замаар санхүүгийн шүүд бус дэмжлэг үзүүлэх нь дэлхийн нийтлэг жишиг төдийгүй Монголд хэрэгжиж буй бодлого болохыг уг судалгаанд онцолжээ. Гагцхүү татварын орчинд ТББ-ыг нийгэмд тустай үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллага гэдэг утгаар бус, ашгийн төлөө бус үйл ажиллагаа эрхэлдэг гэсэн эдийн засгийн утгаар нь ойлгож байна. Гэвч ашгийн төлөө бус салбар нь ТББ-аас гадна төрийн үйлчилгээний ачааллыг хуваалцан, төлбөртэй үйлчилгээг ашгийн бус зарчмаар хэрэгжүүлдэг хувийн сургууль, эмнэлэг зэрэг үйлчилгээний байгууллагыг багтаасан

илүү өргөн ойлголт юм. Ийнхүү татварын орчинд төлбөртэй үйл ажиллагаа хэрэгжүүлдэг хувийн сургууль, эмнэлэг, мөн төлбөртэй үйл ажиллагаанаас орлого олох маш хязгаарлагдмал боломжтой ТББ-ууд нэг ангилалд багтаж байна. 2021 оны Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр ашгийн төлөө бус хуулийн этгээд орлого олох үйл ажиллагаа эрхэлсэн бол аж ахуйн нэгж гэж тооцогдох болсон тул өөрийн үйл ажиллагаанаас их, бага хэмжээний орлого олсон ТББ-ууд аж ахуйн нэгж болжээ. Ашгийн бус салбарын ангиллыг нарийвчлан тогтоож, иргэний нийгмийн болон ашгийн бус арилжааны байгууллагыг зааглах замаар ТББ-уудад дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэхтэй холбоотой олсон орлогоо татвараас чөлөөлүүлэх хуулийн боломжийг саадгүй эдлэх нөхцөлийг бүрдүүлэх, мөн аж ахуйн нэгжийг оновчтой тодорхойлох арга хэмжээ авахыг судлаачид зөвлөжээ.

## ТББ-ын санхүүжилтийн инновацын судалгаа

Нийгмийн асуудлыг иргэний нийгмийн байгууллагын уламжлалт загвараас гадна арилжааны суурьтай бизнесийн загвараар шийдвэрлэх боломжтой. Нийгмийн энтерпрайз нь арилжаа эрхэлж, олсон ашгийн дийлэнх хэсгийг нийгмийн зорилтод чиглэсэн үйл ажиллагаагаа санхүүжүүлэхэд зарцуулдаг ашгийн төлөө бус байгууллага юм. Дэлхийн олон оронд Нийгмийн энтерпрайзыг нийгмийн асуудлыг шийдэх санхүүгийн хувьд тогтвортой загвар гэж үзэн, бодлогоор дэмжин, хөгжүүлж байна. Судлаач Д.Батбуян ахлагчтай баг Монгол дахь нийгмийн энтерпрайзын хэрэгцээг судалж, ажилгүйдэл, ядуурал, хог хаягдал, цөлжилт зэрэг нийгмийн асуудлыг бизнесийн аргаар шийдэж буй

байгууллагууд хэдийн бий болсныг баримтжуулав. Гэвч эрх зүйн хувьд хүлээн зөвшөөрөгдөөгүй тул эдгээр нэгж нь компани хэлбэрээр бүртгүүлэн, ашгийн төлөөх бусад аж ахуйн нэгжтэй зах зээл, хөрөнгө оруулалтын төлөө ижил нөхцөлд өрсөлдөж байна. Манайд нийгмийн энтерпрайзын талаар олон нийт, бодлого боловсруулагч болон хөрөнгө оруулагчдын ойлголт төлөвшөөгүй байгаа тул бие даасан хууль гаргах нь ач холбогдол багатай байх сул талтай юм. Иймээс шаардлага хангасан компани, эсвэл ТББ-д “нийгмийн энтерпрайз” гэсэн статус олгож, зорилтот дэмжлэгээр хангах шилжилтийн бодлого хэрэгжүүлэх нь илүү оновчтой гэж судалгааны баг дүгнэж байна.

## Иргэний оролцооны механизмууд

Захиргааны шийдвэр гаргахдаа судалгаа, шинжилгээнд үндэслэх, мөн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй иргэд, олон нийттэй зөвлөлдөх тухай заасан Захиргааны ерөнхий хуулийн 26, 27, 61, 62, 74-76 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор зарласан стратегийн өмгөөллийн тэтгэлэгт хөтөлбөрт шалгарсан Иргэний үндсэн эрх хөгжил ТББ нь Улаанбаатар хотын нийтийн эзэмшлийн зам, талбайн засвар үйлчилгээтэй холбоотой захиргааны шийдвэр дэх хуулийн зөрчлийг арилгуулахаар ажиллаж байна. Нийслэлийн хэмжээнд 2025 онд нийт 16 байршилд 186.839 ам метр явган хүний замыг байгалийн барзгар чулуун хавтангаар солих ажил төлөвлөгдсөн гэх боловч уг төлөвлөгөө, түүнийг баталсан шийдвэр, хэрэгжилтийн мэдээлэл нийтэд ил тод бус төдийгүй бүрэн бүтэн байгаа замын хашлага, бордюр, хучилтыг хүртэл сольж буй нь тооцоо судалгаа зохих ёсоор хийгдээгүйг харуулж байна.



Гэрэл зургийг tra.mn

Төслийн баг Улаанбаатар хотын явган болон автозамын засвар, тохижилт үйлчилгээтэй холбоотой хотын захиргаа, НИТХ-аас гаргасан шийдвэр, төсөв, хөрөнгийн зарцуулалтын мэдээллийг холбогдох байгууллагуудаас гаргуулж, нотлох баримт бүрдүүлэх, нэхэмжлэлийн үндэслэл, шаардлагыг тодорхойлох зэрэг бэлтгэл ажлыг хангажээ. Үүний үр дүнд шүүхэд нэхэмжлэл гаргахад бэлэн болоод байна.

## Иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагаа

ННФ нь Зориг сан, “Бүх нийт боловсролын төлөө” иргэний нийгмийн эвсэл зэрэг байгууллагатай хамтран залуучууд болон хөдөө орон нутгийн ИНБ-үүдийн идэвхтэн, дэмжигчдийн дунд ардчилсан засаглал, иргэний нийгмийн орон зайн талаар яриа хэлэлцүүлэг зохион байгуулж, иргэний оролцооны механизмуудыг танилцууллаа. Хоёр удаагийн үүлзалтад нийт 50 орчим оролцогч хамрагдаж, чөлөөт ярилцлага өрнүүлэн, мэдээлэл, түршлага солилцох үйл явцад идэвхтэй оролцлоо.

Мөн бид [www.cso.mn](http://www.cso.mn) сайтаараа дамжуулан, ИНБ-үүдэд зориулсан тэтгэлэг, сургалт, олон улсын арга хэмжээний зар мэдээлэл, түүнчлэн сүүлийн үеийн судалгаа, шинжилгээний тоймыг тогтмол хүргэх ажлаа үргэлжлүүлж байна.



# ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН БОДЛОГО

ҮХЦ-ийн Их суудлын  
хуралдаан (2025.10.22)  
Гэрэл зургийг Б.Бямба-Очир

## ЭРХ ЗҮЙН ХӨТӨЛБӨР

2025 он шударга ёсны салбарын хувьд Үндсэн хуулийн цэцийн (ҮХЦ) шийдвэрүүдээр тодорхойлогдсон онцлог жил байв. ҮХЦ нь байгууллагын дотоод зохион байгуулалт, удирдлагын эрх хэмжээний хүрээнд өөрийн үйл ажиллагааны хараат бус, ил тод байдлыг бэхжүүлэх чиглэлээр дүрэм журмаа шинэчлэн мөрдөхийн зэрэгцээ 2025–2028 оны хөгжлийн стратегия боловсруулан баталсан нь ҮХЦ-ийн үйл ажиллагааны үр нөлөөтэй байдлыг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэжээ.

ҮХЦ 2025 онд улс төрийн тогтвортой байдал (№08), хэвлэл мэдээллийн эрх чөлөө (№10), хүний эрхийн баталгаа (№07) зэрэг чиглэлээр онцгой ач холбогдолтой дүгнэлт гаргасан нь ардчилал, хууль дээдлэх зарчмыг бэхжүүлэхэд чухал нөлөө үзүүлэх боллоо.

Тухайлбал ҮХЦ-ийн №10 дүгнэлтийн дараа Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах ажлын хэсэг байгуулагдсан юм.

“

## ҮХЦ-ийн 2025 онд гаргасан гол дүгнэлтүүд:

**Дүгнэлт №01:** Бие даан нэр дэвшигчийн гарын үсэг цуглуулах шаардлага (Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31.2, 31.3, 31.4 дэх хэсэгт заасан 801-ээс доошгүй сонгогчийн гарын үсэг).

**Шийдвэр:** Үндсэн хууль зөрчсөн. Уг босго нь нам, эвслээс нэр дэвшигч болон бие даан нэр дэвшигчдийн хооронд тэгш бус байдал үүсгэж, сонгогдох эрхийг хязгаарласан гэж үзэв. УИХ дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөн.

**Дүгнэлт №02:** Шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах зохицуулалт (Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47.6 дахь хэсэг).

**Шийдвэр:** Үндсэн хууль зөрчсөн. Нас, ажилласан жилээр ялгаварлан албадан тэтгэвэрт гаргах нь шүүхийн хараат бус байдал, иргэний хөдөлмөрлөх эрхийг зөрчсөн гэж дүгнэв.

**Дүгнэлт №03:** УИХ-ын гишүүний ажлын тайлан ба сонгуулийн сурталчилгаа (УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 41.9, 44.6 дахь хэсэг).

**Шийдвэр:** Үндсэн хууль зөрчсөн. Одоогийн гишүүдэд давуу байдал олгож, бусад нэр дэвшигчийн тэгш өрсөлдөх боломжийг хязгаарласан гэж үзэв.

**Дүгнэлт №04:** Саналын хуудсыг хүчингүйд тооцох (УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 72.1 дэх хэсэг).

**Шийдвэр:** Үндсэн хууль зөрчсөн. Сонгогч өөрийн хүсэл зоригоор цөөн нэр дэвшигчийг дэмжих эрхтэй байхад “дүтүү” дүгуйлсан гэсэн үндэслэлээр саналыг бүхэлд нь хүчингүйд тооцох нь сонгох эрхийг зөрчсөн.

**Дүгнэлт №05:** Хувь хүний орлогын албан татварын шатлал (Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21.1).

**Шийдвэр:** Үндсэн хууль зөрчсөн. Татварын шатлал нь иргэдийн тэгш байдал, шударга ёсны зарчимд нийцээгүй гэж үзэв.

**Дүгнэлт №06:** Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл (Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9.3 дахь хэсэг).

**Шийдвэр:** Үндсэн хууль зөрчсөн. Иргэний үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийг хууль бусаар хязгаарласан гэж дүгнэв. УИХ дүгнэлтийг хүлээн авч, хуульд өөрчлөлт оруулах ажлын хэсэг байгуулсан.

**Дүгнэлт №07:** Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ (Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10.11).

**Шийдвэр:** Үндсэн хууль зөрчсөн. Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг зөрчиж, үндэслэл муутай цагдан хорих нөхцөлийг бүрдүүлсэн. УИХ хүлээн авсан.

**Дүгнэлт №08:** Ерөнхий сайдыг огцруулсан үйл явц (УИХ-ын 95 дугаар тогтоол).

**Шийдвэр:** Үндсэн хууль зөрчсөн. Хууль дээдлэх болон шударга ёсны зарчмыг алдагдуулсан гэж дүгнэв.

**Дүгнэлт №09:** Олон улсын гэрээний соёрхон батлах тухай (“Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр”).

**Шийдвэр:** Үндсэн хууль зөрчөөгүй. УИХ дүгнэлттэй танилцаж, гэрээг соёрхон батлах ажлыг үргэлжлүүлсэн.

**Дүгнэлт №10:** “Худал мэдээлэл тараах” гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл).

**Шийдвэр:** Үндсэн хууль зөрчсөн. Иргэний үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг хэтрүүлэн хязгаарлаж, тодорхойгүй байдлаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх нөхцөл бүрдүүлсэн.

**Дүгнэлт №11:** ИТХ-ын төлөөлөгчийн давхар ажил эрхлэлт.

**Шийдвэр:** Үндсэн хууль зөрчөөгүй. Орон нутгийн эрх мэдлийн хуваарилалт, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх зорилготой хязгаарлалт хууль ёсны гэж үзэв.

## Шударга ёсыг сахиулан хамгаалах институциудын хараат бус байдал

Энэ онд шударга ёсны салбарын гол институтүүдийн үйл ажиллагаа, хараат бус байдлыг үнэлэх бодлогын судалгаа хийж, үр дүнг нийтэд хүргэх, оролцогч талуудын оролцоог хангах, томилгооны ил тод, хариуцлагатай байдлыг дэмжихэд

анхаарлаа төвлөрүүлээ гэжээ. Учир нь шударга ёсны тогтолцоонд итгэх иргэдийн итгэл нь нэг байгууллагын бус, харин тогтолцооны бүх институцийн хараат бус, хариуцлагатай үйл ажиллагаанаас шууд хамаардаг юм.

2024 онд нээлттэй зарласан бодлогын судалгааны тэтгэлгийн шалгаруулалтад Хууль эрх зүйн хөгжлийн хүрээлэнгийн “Прокурорын хараат бус байдлыг бэхжүүлэх” сэдэвт төсөл шалгарч тайлан нийтлэгдсэн юм. Судалгаанд Монгол Улсын шүүх эрх мэдлийн хүрээний хийгээд эрүүгийн эрх зүйн шинэтгэл прокурорын эрх зүйн орчны өөрчлөлтөд хэрхэн тусгалаа олсон болон олон улсад прокурорын байгууллага хэрхэн шинэчлэгдэн өөрчлөгдөж буй чиг хандлагыг харьцуулан шинжиллээ. Түүнчлэн тус институцийн хараат бус байдлын гол баталгаа болсон шударга, ил тод томилгооны процесс болон хариуцлагын механизмыг онцлон авч үзсэн юм.



Тайланг бодлогын түвшинд хэлэлцүүлэх зорилгоор 3 дугаар сард Улсын Ерөнхий прокурорын газрын удирдлагын баг, судлаачдыг урьж хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хэлэлцүүлэг нь талуудын хувьд ойлголтоо нэгтгэх, мэдээлэл солилцох, мэргэжлийн шүүмж өрнүүлэх боломж бүрдүүлэн бодлогын шийдэл боловсруулахад чухал ач холбогдолтой болов.

Мөн судалгааны гол дүгнэлт, зөвлөмжийг олон нийтэд хүргэх зорилгоор “Форум” подкастын ээлжит дугаарт судлаачдыг урин ярилцлаа.



[https://www.youtube.com/watch?v=\\_uRTLlkk1NI&t=793s](https://www.youtube.com/watch?v=_uRTLlkk1NI&t=793s)

Дээрх хэлэлцүүлэгт Молдав Улсын Ерөнхий прокурорын газрын Эрх зүйн туслалцаа, гадаад хамтын ажиллагааны газрын дарга Диана Ротунду оролцож, өөрийн улсын прокурорын байгууллагын шинэтгэл, сургамж, сорилтын талаар танилцуулсан нь Европын холбооны стандарт, чиг хандлагын талаар ойлгоход тус дөхөм болох мэдээлэл байлаа.

Прокурорын үйл ажиллагаатай өргөн хүрээнд уялдах дараагийн судалгааг “Виндекс партнерс” ХХН-ийн хуульч, судлаачид гүйцэтгэж, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ил тод байдал, хэрэгжүүлэх арга зам” сэдэвт тайлан боловсруулав. Судалгаагаар бүртгэл, мөрдөн байцаалт, шүүхийн шатанд хэргийг нийтэд мэдээлэх шалгуур, зарчмыг нарийвчлан шинжилж, ил тод байдлыг хангах бодлогын зөвлөмж дэвшүүлсэн юм.



ННФ өмнөх жилүүдэд шүүхийн шатны процесс, шүүхийн шийдвэрийн ил тод байдалд чиглэсэн судалгааг түлхүү дэмжиж ирсэн бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шүүхээс өмнөх шатны оролцогч байгууллагуудын хараат бус байдал, процессын ил тод байдлын талаар хийгдсэн судалгаа дутмаг байсан тул энэ чиглэлд түлхүү анхаарч ажиллалаа. Энэ хүрээнд АНУ, БНСУ, ХБНГУ, Австри болон Япон Улсын эрүүгийн процессын ил тод байдлыг хангах зохицуулалт, платформ, технологийн шийдлүүдийг харьцуулан авч үзсэн нь бодит нөхцөлд нийцсэн бодлогын шийдэл боловсруулахад чухал ач холбогдолтой мэдээлэл, дүн шинжилгээ болсныг дурдах нь зүйтэй. Судалгааны тайлан танилцуулах хэлэлцүүлэгт УДШ, УЕПГ, ЦЕГ, ХЗДХЯ зэрэг байгууллагын төлөөлөл, судлаач, хуульчид оролцож мэргэжлийн санал шүүмж өрнүүлсэн болно.

Түүнчлэн 12 дугаар сард Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс санаачлан иргэний нийгмийн байгууллагуудтай мэдээлэл солилцох уулзалт зохион байгуулж, прокурорын байгууллагын нээлттэй, ил тод байдлыг тогтолцооны түвшинд бэхжүүлэх талаар санал солилцсон нь цаашид иргэний нийгмийн



байгууллагууд энэ чиглэлээр хамтран ажиллах боломж, нөхцөлийг бүрдүүлсэн чухал арга хэмжээ байв.

2024 оны судалгааны тэтгэлэгт хамрагдсан Б.Оюунжаргал, М.Болор-Эрдэнэ, Л.Энхтайван нарын баг “Шүүхийн шинжилгээний байгууллагын хараат бус байдлыг бэхжүүлэх арга зам” сэдэвт судалгааг хийж, тайлант онд хэвлүүллээ.



Энэхүү судалгаа нь 2022 онд шинэчлэгдсэн Шүүхийн шинжилгээний тухай хууль хэрэгжсэнээр тус байгууллагын тоног төхөөрөмжийн хангамж олон улсын түвшинд хүрснийг тэмдэглэхийн сацуу байгууллагын дотоод хараат бус байдалд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлс арилаагүй хэвээр байгааг тодорхойлсон нь чухал үр дүн байв. Энэ байгууллагын хараат бус байдал нь иргэдийн шударга ёсны тогтолцоонд итгэх итгэлд шууд нөлөөлдөг тул бодлого боловсруулагч, хууль тогтоогч, мэргэжилтнүүд тус тайланг эх сурвалж болгон ашиглах боломжтой юм.

## Шударга ёсны салбар дахь томилгоо

2023 оны 06 дугаар сард Үндсэн хуулийн цэцийн гаргасан Улсын Дээд шүүхийн шүүгч, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Улсын Ерөнхий прокурорыг томилохдоо томилгооны нээлттэй сонголт хийх нь Үндсэн хууль зөрчсөн хэмээсэн дүгнэлт нь шударга ёсны салбарын томилгоог ил тод, хариуцлагатай явуулах тогтолцоог сулруулсан юм. УИХ уг дүгнэлтийг зөвшөөрөөгүй ч 2024 онд ҮХЦ –ийн их суудлын хуралдаанаар дүгнэлт хэвээр үлдсэн билээ. Үүний үр дагавраар Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Улсын Дээд шүүхийн шүүгч, Улсын Ерөнхий прокурор зэрэг албан тушаалтнуудын томилгоог нээлттэй сонголт зохион байгуулахгүйгээр явуулах болсон юм. Улмаар 2025 онд Улсын Ерөнхий прокурор, түүний орлогч болон Авлигатай тэмцэх газрын даргыг сонголтгүйгээр улираан томилоод байна.

Энэ оны хувьд 2021 онд томилогдсон Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусаж байгаатай холбогдуулан 5 шүүгч гишүүн болон 4 шүүгч бус гишүүн томилох үйл явц 10 дугаар сараас эхэлсэн нь салбарын хувьд анхаарал татсан

“Шүүхийн индекс 2025” судалгааны мэдээлэл цуглуулах ажил энэ оны 11 дүгээр сараас эхэллээ. Судалгааны арга зүйг өмнөх хувилбараар хадгалж, стратегийн түнш, хамтрагч байгууллагуудтай хамтын ажиллагаагаа үргэлжлүүлж байна. Нийт 2000 иргэнийг хамарсан олон нийтийн санал асуулга, 500 орчим хуульч, мэргэжилтнийг хамруулсан мэргэжилтний санал асуулга, мөн шүүхийн албан ёсны статистик, тайлан мэдээлэлд үндэслэн 2025 оны байдлаарх шүүхийн үйл ажиллагааны түвшнийг үнэлнэ. Судалгааны үр дүнг ирэх оны эхний хагаст танилцуулахаар төлөвлөж байна.

үйл явдал байв. 12 дугаар сарын 31-ний байдлаар долоон гишүүнийг шинээр томилж, найман гишүүн бүрэн эрхийн хүрээнд ажиллаж байна. Томилогдоогүй үлдсэн хоёр гишүүнийг УИХ-аас дахин сонгон шалгаруулах зохицуулалтын дагуу томилгоо хүлээгдэж байгаа билээ. Тэрчлэн, 12 дугаар сарын 24-ний өдөр УИХ-ын Хууль зүйн байнгын хорооноос шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн томилгооны сонголт зохион байгуулж, дөрвөн нэр дэвшигч оролцсон юм. УИХ хоёр дэвшигчийг дэмжин томилсон бөгөөд үлдсэн орон тоонд 2026 онд дахин сонгон шалгаруулалтыг цаг алдалгүй зохион байгуулах шаардлага үүссэн болно.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүдийн сонгон шалгаруулалт, томилгооны үйл явцыг ажиглах, олон нийтэд мэдээлэх, нөлөөллийн үйл ажиллагааг Бодлогод залуусын хяналт ТББ-тай хамтран хэрэгжүүллээ. Оюуны Инновац ТББ, Хууль эрх зүйн хөгжлийн хүрээлэн ТББ зөвлөх чиг үүрэгтэй оролцсон юм.

Мөн “Шүүхийн захиргааны үндсэн чиг үүрэг, түүний хэрэгжилт” сэдвээр хуульчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, шүүгчийн томилгоо болон шүүхийн төсөв нөөцийн удирдлагын асуудлыг хөндөн ярилцлаа. Хэлэлцүүлгийг шууд дамжуулж, гарсан санал, зөвлөмжийг нэгтгэн нээлттэй ил захидал хэлбэрээр УИХ-ын гишүүдэд хүргүүлээ.

Сонгон шалгаруулалтын явцад УИХ-ын зарим гишүүд журмыг өөрчлөх, хүчин төгөлдөр шийдвэрийг үгүйсгэх оролдлого хийсэнтэй холбогдуулан зөвлөх баг мэргэжлийн байр суурь илэрхийлж олон нийтэд мэдээлэл түгээн нөлөөллийн ажил хийсэн нь үйл явцын ил тод, шударга байдлыг хангахад тодорхой үр нөлөө үзүүлсэн гэж үзэж байна.

ННФ нь шүүхийн салбарын томилгооны ил тод, хараат бус байдалд онцгой анхаарал хандуулж ирсэн бөгөөд тайлант онд энэ чиглэлээр бие даасан бодлогын судалгаа танилцууллаа. 2021 онд батлагдсан Шүүхийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш дөрвөн жил өнгөрсөн нь шүүгчийн сонгон шалгаруулалт, томилгоотой холбоотой

## Олон нийтэд мэдлэг, мэдээлэл түгээх

Манай байгууллага иргэдийн шударга ёсны тогтолцоонд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, эрх зүйн боловсролыг дэмжих зорилгоор мэдлэг, мэдээлэл түгээх дараах төслүүдийг дэмжин хэрэгжүүлэв.

ҮХЦ болон УДШ-ийн хууль тогтоомжийг нэг мөр хэрэглэх, жишиг тогтоох ач холбогдол бүхий шийдвэрүүдийг олон нийт, ялангуяа залууст ойлгомжтой, энгийн хэлбэрээр хүргэх зорилгоор “Завсарлага” подкаст төслийг дэмжин тэтгэлэг олголоо. Төслийн хүрээнд дараах сэдвээр эхний

зохицуулалтын хэрэгжилтийг үнэлэх боломж бүрдсэн гэж үзэн уг судалгааг захиалан гүйцэтгүүлэв. 2021 оноос хойш есөн удаагийн сонгон шалгаруулалтаар 443 сул орон тоо зарлагдаж, 1576 хүн бүртгүүлснээс 1226 нь баталгаажсан, 350 хүнд татгалзсан, мэдлэг, үр чадварын шалгалтад 185 хүн оролцож 179 нь тэнцсэн бөгөөд нийт 117 шүүгч томилогджээ.

*Судалгааны гол дүгнэлтүүдээс дурдвал:*

- Сонгон шалгаруулалтын явц, шалгалтын үр дүнг мэдээлэх байдал хангалтгүй байгаа нь маргаан, үл итгэлцэл үүсгэж байна.
- Цахим системийн алдаа, эрүүл мэндийн баримт бичгийн шаардлага, мэргэжлийн бус гишүүдийн оролцоо, улс төрийн нөлөө зэрэг хүндрэл тулгарч байна.
- Үнэлгээний аргачлал хуучинсаг, объектив бус байгаа нь хараат бус байдлыг сулруулж байна.
- Ерөнхийлөгчийн хоригийн эрх зэрэг зохицуулалт шүүхийн хараат бус байдалд нөлөөлж болзошгүй.

гурван дугаарыг YouTube болон олон нийтийн сүлжээгээр дамжуулан олон нийтэд хүргэв. Үүнд:

- Эрүүгийн хуулийн 13,14-р зүйл Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаарх Үндсэн хуулийн 10 дугаар дүгнэлт
- Сууц өмчлөгчдийн холбооны талаарх шүүхийн шийдвэрүүд
- Хүүхэд асрах цалинтай чөлөөг эцэгт олгох асуудлаарх Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт



Подкастыг бэлтгэн гаргаж буй Монголын залуучуудын эвсэл ТББ дараагийн гурван дугаар дээр ажиллаж буй бөгөөд ҮХЦ болон УДШ зэрэг байгууллагууд, тэдэнтэй хамтран ажилладаг төсөл, хөтөлбөрийн зүгээс олон нийтэд хандсан энэхүү төслийг цаашид үргэлжлүүлэн дэмжих нь нээлттэй. Энэ төсөл нь иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хүний эрхийн ойлголтыг гүнзгийрүүлэх, Үндсэн хуулийн цэц болон шүүхийн үйл ажиллагааны талаар бодит, тэнцвэртэй мэдээлэл түгээхэд чиглэж байна.

Монголын залуучуудын эвслээс гаргасан богино рийлс



Түүнчлэн эрх зүйн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн Шүүхийн шийдвэрийн судалгааны тэтгэлэгт төслийн үр дүнг олон нийт, хуульч мэргэжилтнүүдэд танилцуулах зорилгоор “Legal Talks” подкастын тусгай цувралыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэв. Оюуны Инноваци ТББ энэ онд зургаан дугаар бэлтгэн нийтэлснээр “Шүүхийн шийдвэрийн шинжилгээ” цуврал нийт 25 дугаарт хүрч, [www.legaldata.mn](http://www.legaldata.mn) цахим хуудас болон нийгмийн сүлжээгээр олон нийтэд хүрчээ. Энэхүү цуврал нь шүүхийн шийдвэрийн агуулга, эрх зүйн үндэслэл, практикт үзүүлэх нөлөөллийг задлан шинжилж, мэргэжлийн хүрээ болон олон нийтэд эрх зүйн ойлголтыг системтэй, хүртээмжтэй байдлаар хүргэхэд чиглэж байна.



- S2  
EP20
- S2  
EP21
- S2  
EP22
- S2  
EP23
- S2  
EP24
- S2  
EP25

# НИЙТИЙН БАЯЛГИЙН УДИРДЛАГА, ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ

Өмнөговь аймаг, Ухаа худаг  
Гэрэл зургийг Б.Мөнхгэрэл  
(2015 он)

### Нийтийн баялгийн удирдлага, ил тод, хариуцлагатай байдал

Монгол Улс байгалийн арвин баялаг нөөцтэй боловч нийгэм, эдийн засгийн тодорхой сорилтуудтай тулгарсан хэвээр байна. 2022 оны байдлаар ядуурлын түвшин 27.1 хувь байгаа нь гурван хүн тутмын нэг нь ядуурлын нөхцөлд амьдарч буйг илтгэнэ. Орлого багатай өрхүүдийн дийлэнх нь ариун цэврийн байгууламж, төвлөрсөн халаалтын системгүй гэр хороололд амьдарч, хатуу түлш хэрэглэж буй нь нийслэл болон бусад суурин газрын агаар, хөрсний бохирдлын түвшин гамшгийн хэмжээнд хүрэх шалтгаан болоод байна. Энэ нөхцөл байдал нь иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хязгаарлаж, хүн амын эрүүл мэндэд урт хугацааны сөрөг нөлөө үзүүлсээр байгаа юм. Үүний зэрэгцээ орлогын тэгш бус байдал гүнзгийрч, инфляцын өсөлт өрхийн бодит орлогыг бууруулан, амьжиргааны нөхцөл байдлыг дордуулж байна.

Эдийн засаг эрдэс баялгийн салбараас улам бүр хамааралтай болсоор байна. Улсын төсвийн орлогын ойролцоогоор 30 хувь, нийт экспортын 90 орчим хувийг уул уурхайн бүтээгдэхүүний экспорт бүрдүүлдэг. Төсвийн бодлого хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдтэй уялдахгүй, уул уурхайн салбараас төсөвт төвлөрөх орлогын нөхцөл байдал түүхий эдийн үнэ, гадаад зах зээлийн эрэлтээс хамааран хэлбэлзэх нь төсвийн тогтвортой байдалд ихээхэн эрсдэл дагуулж байна.

Үүний зэрэгцээ нийтийн баялгийг үр ашиггүй, зүй бус ашиглах байдал хэвээр байна. Төсөв захирагчид болон төрийн өмчит компаниудын үйл ажиллагаанд хийсэн иргэний нийгмийн ажиглалт, төрийн аудитын

байгууллагын хяналт шалгалтаар илэрсэн үр ашиггүй, зориулалтын бус зарцуулалт, авлига, ашиг сонирхлын зөрчлийн тохиолдлууд нь төсвийн сахилга, хариуцлагын тогтолцооны сул талыг илчилж байна. Гэвч Төрийн аудитын байгууллагын дүгнэлт, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэхгүй, зөрчил гаргасан этгээдэд зохих хариуцлага тооцохгүй явж ирсэн нь алдаа давтагдах нөхцөл бүрдүүлэн, олон нийтийн итгэлийг сулруулж, төсвийн үрэлгэн байдал үргэлжлэн гарахад хүргэж байна. Ил тод байдал, хариуцлагын механизм сул хэвээр байгаа нөхцөлд нийтийн баялгийн үр ашигтай, шударга хуваарилалтыг хангах боломж хязгаарлагдмал юм.

Түүнчлэн эдийн засаг, нийгмийн үр өгөөж нь тодорхойгүй томоохон хөрөнгө оруулалтын төслүүдийг улсын төсөв болон олон улсын зээл, тусламжийн эх үүсвэрээр санхүүжүүлэх явдал үргэлжилж байна. Эдгээр төслийн эдийн засгийн үр ашгийн тооцоо, судалгаа болон хэрэгжилтийн талаарх мэдээлэл хаалттай байгаа нь олон нийтийн хяналтыг хязгаарлаж, үр ашиггүй зарцуулалт, авлига, ашиг сонирхлын зөрчлийн эрсдэлийг нэмэгдүүлсээр байгаа юм. Улмаар төсвийн сахилга алдагдах, Засгийн газрын өрийн дарамт нэмэгдэх эрсдэл бодитой оршсоор байна.

Дээрх нөхцөл байдлыг харгалзан хөтөлбөрийн зүгээс иргэдийн орлогын тэгш бус байдлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэв. Зарлага талаас нийтийн төсөв, санхүүгийн бодлогыг сайжруулах зорилго дор улсын төсөв, санхүүгийн удирдлага, Засгийн газрын болон нийслэлийн

мега төслүүд, цаг үеийн асуудлуудаар судалгаа, шинжилгээ хийж үр дүнг нийтэд хүргэлээ. Харин орлогын хувьд нөлөөлөх хүчин зүйлсийн хүрээнд

боловсролын салбарын хөтөлбөрүүдийн төлөвлөлт, эдийн засаг дахь төрийн оролцоо зэрэг чиглэлээр хэлэлцүүлэг өрнүүлсэн юм.

### Төсөв, санхүүгийн удирдлагыг хөгжлийн бодлогод чиглүүлэх нь

ННФ нь төсөв, санхүүтэй холбоотой цаг үеийн асуудлуудад шуурхай дүн шинжилгээ хийж, төсвийн төлөвлөлтийг улсын хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдтэй уялдуулах, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулахад нөлөөлөх чиглэлээр ажиллаж ирлээ. Энэ хүрээнд эдийн засаг, төсөв, санхүү, засаглалын чиглэлээр хараат бус мэргэжилтнүүдээс бүрдсэн ННФ-ын дэргэдэх Эдийн засгийн зөвлөл тогтмол уулзаж, улсын төсөв, санхүүгийн бодлоготой холбоотой асуудлуудаар хэлэлцэн, бодлогын шинжилгээ хийн санал, зөвлөмж боловсруулан

УИХ-ын Төсвийн байнгын хороо болон холбогдох байгууллагад хүргүүлж, олон нийтийн анхааралд оруулан ажиллаж байна. Тухайлбал, төсвийн шинэчлэлтэй холбоотой хуулийн төслүүдийг хэлэлцэн санал, дүгнэлтээ УИХ-ын Төсвийн байнгын хороонд хүргүүлснээр 2023 оны 07 дугаар сард батлагдсан Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөд төсвийн удирдлагыг боловсронгуй болгох чиглэлийн нааштай зохицуулалтууд тусгагдахад тодорхой хувь нэмэр оруулсан юм.



ННФ-ын дэргэдэх Эдийн засгийн зөвлөлийн гишүүд Монгол Улсын 2026 оны төсвийн төлөвлөлтийн асуудлыг хэлэлцэж буй нь (2025.09)

Нийтийн төсвийн төлөвлөлтийг хүртээмжтэй өсөлтийг дэмжихэд чиглүүлэх нь ядуурлыг бууруулах бодлогын чухал бүрэлдэхүүн хэсэг болдог. Эдийн засгийн зөвлөл тайлант онд төсөв, санхүүгийн чиглэлээр Засгийн газраас боловсруулсан бодлогын баримт бичгийн төслүүдийг хэлэлцэн санал, зөвлөмжөө бодлого боловсруулагчдад хүргэлээ. Тухайлбал, УИХ-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл, Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөл, Монгол Улсын 2026 оны төсвийн төлөвлөлт, Засгийн газрын өрийн

удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичгийн төсөлд тус тус дүгнэлт өгч, зөвлөмж өглөө. Мөн Сангийн яамнаас боловсруулсан Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төсөл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас боловсруулсан “Төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2025-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлийн төсөл”-тэй танилцаж санал, зөвлөмжөө хүргүүлэв. Түүнчлэн 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг хэлэлцэн, төсвийн сахилга, үр ашиг, ил тод байдлыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж гаргалаа.

“

#### Улсын төсвийн төлөвлөлттэй холбоотой зөвлөмж:

- Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах**
  - Төсвийн зарлагын өсөлтийг хязгаарлаж, түр зуурын орлогын өсөлтөд тулгуурлан үрсгал зардлын тэлэлтийг зогсоох.
  - Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагуудын хэрэгжилтийг сэргээж, үр нөлөөг бэхжүүлэх.
  - Уул уурхайн үнийн өөдрөг таамагт хэт найдахгүй, бодитой орлогын төсөөлөлд суурилсан төлөвлөлт хийх.
- Төсвийн зарлагын шинэчлэл**
  - Хөтөлбөр–үр дүнгийн үзүүлэлтийг санхүүжилттэй уялдуулж, үр дүнд суурилсан төсөвлөлтийг бүх салбарт нэвтрүүлэх.
  - Үрсгал зардлын бүтэц, өсөлтийн шалтгаан өртгийн өөрчлөлтийг системтэйгээр судалж, ил тод тайлагнах, үрсгал зардлын ДНБ-д эзлэх хувийг үе шаттай бууруулах.
  - Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын суурь зардлыг өсгөсөн бүтэц, төлөвлөлтийн алдааг засах.
- Хөрөнгө оруулалтын бодлогын оновчлол**
  - Төсвийн хөрөнгө оруулалтыг эдийн засгийн өгөөж, нийгмийн ач холбогдлоор эрэмбэлж, үр дүнгийн үнэлгээг бодитоор хэрэгжүүлэх.
  - Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт дэх Эдийн засаг, хөгжлийн яамны үүрэг, оролцоог нэмэгдүүлж, зардал–үр ашгийн тооцоог чанартай хийдэг болох.
  - Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг иргэдийн нэн тулгамдсан асуудалд чиглүүлэх, хүлээж болохуйц “гоёлын” төслүүдээс татгалзах.
- Өрийн удирдлагын шинэчлэл**
  - Төсвийн тухай хуульд өрийн удирдлагын зохицуулалтыг тусгайлан нарийвчлан тусгаж, Засгийн газрын өрийн дээд хязгаар, баталгаа болон орон нутгийн өрийн зохистой хязгаарыг тодорхой болгох.
  - Гадаад зээл, томоохон төслийн санхүүжилтийн хувилбаруудыг УИХ-д олон сонголттой, харьцуулсан байдлаар (төсвөөс, гадаад зээлээр, төр-хувийн хэвшлийн түншлэлээр гэх мэт) өргөн мэдүүлж шийдвэрлүүлэх.

Сүүлийн жилүүдэд төсвийн тухай хуулийн төслийг дагалдуулан тухайн жилийн төсвийн зохицуулалттай шууд хамаарал багатай хууль, тогтоомжуудын төслийг хамтатган өргөн мэдүүлэх, улмаар хууль тогтоомжийн төсөл боловсруулах, батлахад тавигдах шаардлагыг хангахгүйгээр батлах хандлага ажиглагдах болсон. Засгийн газраас Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийг дагалдуулан 2025 оны 9 дүгээр сард УИХ-д өргөн мэдүүлсэн хоёр хууль болох Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон Засгийн газрын үнэт

цаас гаргах эрх олгох тухай, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай УИХ-ын хоёр тогтоолын төсөлд манай байгууллагын захиалгаар Тогтолцоо дүн шинжилгээ судалгааны хүрээлэн ТББ дүн шинжилгээ хийлээ. Энэхүү дүн шинжилгээгээр 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн бүрдэл нь Хууль тогтоомжийн тухай хууль болон Төсвийн тухай хуульд нийцсэн эсэх, мөн дагалдуулан өргөн мэдүүлсэн хоёр хууль, УИХ-ын хоёр тогтоолын төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.5-д заасан шаардлагад нийцсэн эсэхийг үнэлэв.

“

#### Судалгааны дүгнэлтээс:

- НӨАТ-ын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.3, 29.5-д нийцсэн байна. Гэвч татвартай холбоотой зохицуулалтыг төсвийн тухай хуультай дагалдуулан батлах практикт нэгдсэн байр суурь шаардлагатай.
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.3-т нийцсэн боловч 29.5-д заасан шаардлагыг хэлбэрийн төдий хангасан. Чухал өөрчлөлтүүдийг нарийвчилсан судалгаа, харьцуулалтгүйгээр тусгасан нь сөрөг үр дагавар үүсгэх эрсдэлтэй.
- Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төсөл нь шаардлагатай тооцоолол үндэслэл дутмаг бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 36.3, 36.4-т заасан шаардлагыг хангаагүй байна.

Дээрх судалгааны дүнг “Хуулийн шүүмж” цувралынхаа 51 дэх дугаараар бид нийтэд хүргэж, танилцуулах хэлэлцүүлэг зохион байгуулав. Хэлэлцүүлгийн үеэр Сангийн яамны төлөөлөл Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай

УИХ-ын тогтоолын төсөл болон Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн талаар танилцуулга хийж, оролцогчдын асуултад хариулсан юм.



“Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуультай хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд” сэдэвт хэлэлцүүлгийн үеэр (2025. 10)

Мөн ирэх оны төсвийн төлөвлөлтөд анхаарах асуудлыг хэлэлцүүлэх зорилгоор “Монгол Улсын 2026 оны төсвийн төлөвлөлт” сэдэвт хэлэлцүүлгийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлтэй хамтран 10 дугаар сард зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс 2026 оны төсвийн төлөвлөлтөд өгсөн дүгнэлтээ, Сангийн

яамнаас төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, судлаач Д.Баярмаа хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих төслүүдийн төлөвлөлтөд хийсэн дүн шинжилгээг тус тус танилцуулж, бодлого боловсруулагчид болон олон нийтийн анхааралд хүргэсэн юм.



“Монгол Улсын 2026 оны төсвийн төлөвлөлт” сэдэвт хэлэлцүүлгийн үеэр (2025. 10)

Хөрөнгө оруулалтын шинэ төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө эдийн засаг, нийгмийн үр өгөөж, бүс, орон нутгийн тэнцвэр, хөгжлийн төлөвлөгөөтэй үялдуулах байдлыг сайжруулах, эрэмбэлэх, санхүүжилт дутуу төсөл, арга хэмжээнүүдийн санхүүжилтийн зөрүү ба эрсдэлийг үнэлж, тооцоог дахин хийх, санхүүжилтийн боломжит эх үүсвэрийг тодорхойлох шаардлагатай байгаа талаар судлаач дүн шинжилгээндээ онцоллоо.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл болон 2027-2028 оны төсвийн төсөөлөлд өгсөн дүгнэлтэд эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулах бодлогын чиглэл нь эдийн засгийн өсөлтийг дэмжих оновчтой түвшинд хүрээгүй, мөчлөг сөрсөн төсвийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх шаардлага хэвээр байгааг онцолсон юм. Мөн алдагдалгүй төсөв батлах зарчмаас ухарсан, төсвийн хүрээ нь төсөв даган өөрчлөгдөх хандлага үргэлжилж буйг анхаарах асуудлаар тэмдэглэсэн байна.

Мөн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирэх оны төсвийн төсөлд хөгжлийн бодлого, төлөвлөлт болон төсвийн бодлогын үялдааг хангах, бодлогын тогтвортой байдлыг бэхжүүлэх, түүнчлэн үндэсний аюулгүй байдлын зорилтуудыг хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тодорхой тусган хэрэгжилтийг хангах шаардлагатайг онцлон тэмдэглэсэн юм. Түүнчлэн бодлогын тогтвортой байдлыг хангах, үндэсний аюулгүй байдлын асуудлыг хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тодорхой тусгаж, тулгамдсан асуудлуудыг зорилтод нийцүүлэн хэрэгжүүлэх, улсын болон орон нутгийн төсвийн хоорондын харилцааг сайжруулах, бүсчилсэн хөгжлийн бодлоготой үялдуулах, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, үнэлэх, эрэмбэлэх тогтолцоог сайжруулах хэрэгцээг тодорхойллоо. Мөн төсвийн зарлага болон үр дүнгийн үзүүлэлтүүдийн нийцлийг бүрэн хангах, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг институцийн хувьд боловсронгуй болгох шаардлагатайг дурдсан байна.



<https://forum.mn/post/169277>



<https://forum.mn/post/171883>



<https://forum.mn/product/459021>

Улсын төсвийн хөрөнгө оруулалт нь дэд бүтцийн бүтээн байгуулалт, тоног төхөөрөмжийн шинэчлэлээр дамжуулан эдийн засгийг идэвхжүүлэх, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдийн амьдралын чанарыг сайжруулах бодлогын чухал хэрэгсэл юм.

Сүүлийн жилүүдэд төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ эрчимтэй өсөж, 2020 онд 1.3 их наяд төгрөг байсан бол 2024 онд 3.8 их наяд төгрөгт хүрсэн юм. Гэвч төслүүд төлөвлөлтийн шаардлага хангахгүй байх, хэрэгжилт удаашрах, өртөг нэмэгдэх зэрэг асуудал төрийн аудит болон иргэний нийгмийн ажиглалтаар тогтмол хөндөгдөж, хөрөнгө оруулалтын үр ашигт нөлөөлсөөр байна.

УИХ-аас 11 дүгээр сарын 12-нд Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль баталсны дараа 2026 оны төсвийн төсөл болон батлагдсан төсөвт туссан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд харьцуулсан дүн шинжилгээг судлаач Д.Баярмаа хийлээ. Судалгаанаас үзэхэд УИХ-аас төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд тодорхой хэмжээний өөрчлөлт оруулж баталсан бөгөөд төсвийн төсөлтэй харьцуулахад 2026 онд хэрэгжих нийт төсөл, арга хэмжээний тоо 159-өөр, санхүүжилт 12.86 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Шинээр хэрэгжих төслүүдийн тоо 147-оор, нийт төсөвт өртөг 1.28 их наяд төгрөгөөр, 2026 онд олгох санхүүжилт 227.8 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Ялангуяа зам, тээврийн салбарын шинээр хэрэгжих төслүүдийн тоо мэдэгдэхүйц нэмэгджээ. Мөн 2025 оны төсвийг батлах явцад өмнөх онуудаас шилжих хөрөнгө оруулалтын төслүүдэд оруулсан өөрчлөлтийн тоймыг бэлтгэн сонирхогч талуудад хүргэлээ.

2020-2024 онд улсын төсвийн санхүүжилтээр эхэлсэн хөрөнгө оруулалтын төслүүдэд “Зэт Файнаншил энд Инвестмент Консалтинг” ХХК-ийн судалгааны баг дүн шинжилгээ хийж, Монгол Улсад мөрдөгдөж буй төсвийн хөрөнгө оруулалтын аргачлалыг олон улсын жишигтэй харьцуулан үнэлэв. Судалгаагаар төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг зөвхөн тоон гүйцэтгэлээр бус, эдийн засаг, нийгмийн бодит нөлөөллөөр хэмжих шаардлага улам бүр нэмэгдэж буй бөгөөд хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд төсөл сонголт, төлөвлөлтийн ил тод байдал, хэрэгжилтийн хяналт, бодлогын үялдааг сайжруулах шаардлагатайг онцлон, холбогдох зөвлөмжүүдийг боловсруулаад байна.



<https://forum.mn/post/172300>



<https://forum.mn/product/557742>



<https://forum.mn/product/583347>

## Орон нутгийн төсвийн дүн шинжилгээ

Монгол Улсын нэгдсэн төсөв нь улсын төсөв, орон нутгийн төсөв, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сан, Үндэсний баялгийн сангаас тус тус бүрддэг билээ. Өмнөх жилүүдэд бид улсын төсвийн зарцуулалтад төвлөрч ажилласан бол тайлант онд орон нутгийн төсвийн төлөвлөлтөд дүн шинжилгээ хийхийг зорив. Энэ хүрээнд Нийслэлийн Засаг даргын 11 дүгээр сард Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьсан 2026 оны нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөлд дүн шинжилгээ хийсэн юм. Судалгааны үр дүнг “Чухал сэдэв” цувралаар нийтэлж, орон нутгийн төсвийн

хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг сайжруулахад ач холбогдолтой гэж үзэн сонирхогч талуудад хүргэлээ.

Дүн шинжилгээнээс үзэхэд Нийслэлийн 2026 оны төсвийн төсөлд нийт 4.1 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт тусгасан байна. Үүнээс 1.67 их наяд төгрөгийг нийслэлийн төсвөөс, 1.3 их наяд төгрөгийг нийслэлийн үнэт цаасны эх үүсвэрээс, 227.9 тэрбум төгрөгийг Нийслэлийн Замын сангийн хөрөнгө оруулалтаар, 17 тэрбум төгрөгийг Нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар, 34 тэрбум төгрөгийг Нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар, 80 тэрбум төгрөгийг

Газрыг дахин төлөвлөх гэр хорооллын хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тусгажээ. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд нийт 12.3 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 98 төсөлд 1.67 их наяд төгрөгийн санхүүжилт олгохоор

тусгасан байна. Төслийн тоо өмнөх оноос буурсан ч нийт төсөвт өртөг ба тухайн онд олгох санхүүжилтийн хэмжээ өссөн нь хөрөнгө оруулалтын төвлөрөл, цар хүрээ нэмэгдэж буйг илгэнэ.

**Нийслэлийн 2026 оны хөрөнгө оруулалтын зардал (эх үүсвэрээр)**

 <p><b>Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт</b></p> <p>Төсөл, арга хэмжээний тоо: 98 Нийт төсөвт өртөг: 12.3 их наяд ₮ Санхүүжих дүн: 1.67 их наяд ₮</p>	 <p><b>Нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалт</b></p> <p>Төсөл, арга хэмжээний тоо: 56 Нийт төсөвт өртөг: 2.8 их наяд ₮ Санхүүжих дүн: 227.9 тэрбум ₮</p>	 <p><b>Нийслэлийн үнэт цаасны хөрөнгө оруулалт</b></p> <p>Төсөл, арга хэмжээний тоо: 3 Нийт төсөвт өртөг: 2 их наяд ₮ Санхүүжих дүн: 1.3 их наяд ₮</p>	
 <p><b>Нийслэлийн орон нутгийн сангийн хөгжлийн хөрөнгө оруулалт</b></p> <p>Төсөл, арга хэмжээний тоо: 70 Нийт төсөвт өртөг: 17 тэрбум ₮ Санхүүжих дүн: 17 тэрбум ₮</p>	 <p><b>Нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалт</b></p> <p>Санхүүжих дүн: 34 тэрбум ₮</p>	 <p><b>Газрыг дахин төлөвлөх гэр хорооллын сангийн хөрөнгө оруулалт</b></p> <p>Санхүүжих дүн: 80 тэрбум ₮</p>	 <p><b>2025-2026 он дамжин санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ</b></p> <p>Төсөл, арга хэмжээний тоо: 321 Нийт төсөвт өртөг: 10.7 их наяд ₮ Санхүүжих дүн: 761.3 тэрбум ₮</p>

2026 ОНД НИЙТ САНХҮҮЖИХ ДҮН: 4.1 ИХ НАЯД ₮

Эх сурвалж: Нийслэлийн 2026 оны төсвийн төсөл

Нийслэлийн 2026 оны төсвийн төслөөс гадна дүүргүүдийн төсвийн төслүүдэд мөн дүн шинжилгээ хийхээр төлөвлөсөн боловч холбогдох мэдээлэл олдоогүй юм. Иргэдийн төлөөлөгчдийн хуралд 12 дугаар сард өргөн барьсан төсвийн төслийг ирүүлэх тухай албан хүсэлтийг дүүргүүдэд хүргүүлсэн ч шаардлагатай баримт бичиг ирүүлээгүй болно. Энэ нь улсын төсвийн мэдээллийн ил тод байдал тодорхой хэмжээнд сайжирсан ч орон нутгийн түвшинд хангалтгүй хэвээр буйг харуулж байна.

Иймд нийслэл болон дүүргүүдийн Засаг даргын тамгын газар Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган, жилийн төсвийн төслийг Иргэдийн төлөөлөгчдийн хуралд өргөн барьсан даруйд цахимаар нээлттэй байршуулж хэвших шаардлагатай байна. Ингэснээр иргэний нийгмийн байгууллагууд төсвийн төслүүдэд шуурхай дүн шинжилгээ хийх, орон нутгийн төсвийн төлөвлөлтийн асуудлаар бодит хэлэлцүүлэг өрнүүлэх нөхцөл бүрдэх юм.

**Боловсролын салбарын төлөвлөлтийн дүн шинжилгээ, хэлэлцүүлэг**

Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийг УИХ-аас батлахдаа тухайн жилд хэрэгжүүлэх хөтөлбөрүүд болон хүрэх үр дүнгийн чанарын тоон үзүүлэлтийг хамтад нь

баталдаг. Гэвч төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг хэлэлцэх явцад эдгээр хөтөлбөрийн зорилт, үр дүнгийн хэрэгжилтэд хангалттай анхаарал хандуулахгүй байгаа нь ажиглагдаж байна.



“Боловсрол, шинжлэх ухааны сайдын хөтөлбөрүүдийн үр дүнгийн үнэлгээ” хэлэлцүүлгийн үеэр (2025.12)

Иймд Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Сургуулийн өмнөх боловсрол”, “Ерөнхий боловсрол”, “Мэргэжлийн боловсрол, сургалт”, “Дээд боловсрол”, “Насан туршийн боловсрол”, “Тусгай хэрэгцээт боловсрол”, “Шинжлэх ухаан, технологи” зэрэг хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийг юу гэж тодорхойлсон, гүйцэтгэлийг төсвийн тайланд хэрхэн үнэлж буйд “АрБиДи Консалтинг” ХХК-ийн судалгааны баг дүн шинжилгээ хийв. Судалгаагаар урт, дунд хугацааны хөгжлийн баримт бичгүүдэд туссан зарим зорилт жилийн төлөвлөлтөд бүрэн тусгагдаагүй, үр дүнгийн үзүүлэлтүүд оновчтой тодорхойлогдоогүй зэрэг асуудал буйг тогтоож, хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлтийг сайжруулах, гүйцэтгэл, тайлагналыг боловсронгуй болгох санал дэвшүүлсэн юм. Судалгааны дүгнэлт, зөвлөмжийг танилцуулах “Боловсрол, шинжлэх ухааны сайдын

хөтөлбөрүүдийн үр дүнгийн үнэлгээ” хэлэлцүүлгийг 2025 оны 2 дугаар сард зохион байгуулж, гол зөвлөмжүүдийг Форум подкастын №8 дугаараар нийтэд хүргэлээ.




БШУ-ны сайдын хөтөлбөрүүдийн үр дүнгийн үнэлгээний талаар судлаачдын байр суурь, Форум подкаст №8 (2025.02) (<https://forum.mn/post/164295>)

## Улсын төсөв ба сонгууль

Улсын төсвийн зардал УИХ-ын ээлжит сонгуулийн өмнөх жилүүдэд огцом өсөх, олон тооны шинэ хөрөнгө оруулалтын төсөл эхлүүлэх, улмаар тэдгээрийн эхний жилийн санхүүжилтийг хэт бага төлөвлөхөөс шалтгаалан хэрэгжилт удаашрах, төсвийн үр ашиг буурах зэрэг хандлага ажиглагдаж ирлээ. Энэ нөхцөл байдлыг судлах зорилгоор судлаач

Д.Баярмаа сонгуулийн болон сонгуулийн бус жилүүд дэх хөрөнгө оруулалтын төслүүдийн төлөвлөлтөд дүн шинжилгээ хийв. 2012-2024 оны хооронд улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн шинэ төслүүдийг хамруулсан уг судалгааг “Чухал сэдэв” цувралын 01 дүгээр сарын дугаарт нийтлэн сонирхогч талуудад хүргэлээ.

### Монгол Улсын 2012-2024 оны төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжихээр батлагдсан хөрөнгө оруулалтын төслийн тоо



Эх сурвалж: Монгол Улсын 2012-2024 оны төсвийн тухай хууль


Судалгаанаас үзэхэд 2012-2024 оны улсын төсвийн тухай хуулиудад тусгагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд сонгуулийн жилүүд (2012, 2020, 2024)—д шинээр хэрэгжих төслийн тоо болон нийт төсөвт өртөг нэмэгдэх хандлагатай байна. Мөн сонгуулийн болон сонгуулийн бус жилүүдийг үл харгалзан шинээр батлагдсан олон төсөл эхний санхүүжилтийн шаардлага бүрэн хангаагүй, хуульд нийцэхүйц төлөвлөлт дутмаг байв. Шинээр хэрэгжих төслүүдийн нийт төсөвт өртгийн дийлэнх нь боловсрол, соёл, шинжлэх ухаан, зам тээвэр, эрчим хүч барилга, хот байгуулалт, эрүүл мэнд, хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрлэлийн салбарт ногджээ. Ялангуяа сонгуулийн авто зам, сургуулийн барилга, өргөтгөл, шинэчлэлийн төслүүдийн эзлэх хувь харьцангуй

өндөр байсан бөгөөд сонгуулийн жилийн төсвийн төслийг УИХ-аар хэлэлцэх явцад хөрөнгө оруулалтын төслүүдийг нэмж батлах хандлага илэрсэн юм.

2025 оны байдлаар Монгол Улсад нийгмийн халамжийн бодлогын хүрээнд нийт 12 багцын 70 гаруй хөтөлбөр хэрэгжиж байна. Эдгээр нь эмзэг бүлгийн наад захын хэрэгцээг хангах, ядуурал, ажилгүйдлийг бууруулах зорилготой боловч халамжийн бодлого зорилтот бүлгээсээ хальж, нийтлэг шинжтэй болж буй шүүмжлэл нэмэгдэж байна. Иймд халамжийн зардал болон УИХ-ын сонгуулийн жилийн хоорондын хамааралд хийсэн Д.Болортуяа ахлагчтай судалгааны багийн дүн шинжилгээг “Чухал сэдэв” цувралаар нийтэд хүргэлээ.

Энэхүү дүн шинжилгээнд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хассан нийгмийн халамжийн зардал болон халамж авагчдын тоог авч үзэхэд сонгуулийн дараагийн жилүүдэд шинээр хэрэгжиж эхэлсэн хөтөлбөрүүдтэй уялдан өсөх хандлага ажиглагдаж байна. Нийгмийн халамжийн зардлын гол өсөлт нь сонгуулийн болон түүний дараах жилүүдэд төвлөрч байв. Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн хүрээнд

хэрэгжүүлсэн халамжийн арга хэмжээнүүд нь зорилтот бүлэгт чиглэхээс илүүтэй нийтийг хамарсан, бүх өрхийн түвшинд олгогдох шинж ажиглагдсан байна. Мөн сонгуулийн өмнөх үед хэрэгжиж буй тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ болон үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хандлага давамгайлсан байна.



<https://forum.mn/product/459432>



<https://forum.mn/post/164491>



<https://forum.mn/product/457813>

## Төрийн хяналтын байгууллагуудаас гаргасан дүгнэлт, зөвлөмжийн үр нөлөөг нэмэгдүүлэх нь

Төрийн аудитын байгууллага жил бүр төсвийн зарцуулалтад хяналт, шалгалт хийж олон зөрчил илрүүлдэг. Гэвч аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, хариуцлага тооцсон мэдээлэл нийтэд төдийлөн хүрэхгүй байна. Иймд төсвийн гүйцэтгэл, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилтэд хийсэн аудитын дүнгийн нийтэд хүрэх үрсгалыг нэмэгдүүлэх зорилгоор 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилтийн аудитын дүнгээс инфографик багц бэлтгэн нийтэд хүргэлээ.

2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитын хүрээнд Сангийн сайдад өгсөн зөвлөмжөөс дурдвал:


- Төсвийн бодлогыг хэрэгжүүлэхдээ хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхой, хэмжигдэхүйц байдлаар төлөвлөж, хэрэгжилт болон үр дүнг төсвийн гүйцэтгэлтэй уялдуулан тайлагнах, төсвийн үр ашиг, хариуцлага, ил тод байдлыг нэмэгдүүлэх;
- Төсвийн төлөвлөлтийг төсвийн хязгаарт нийцүүлэн төлөвлөсөн эсэхийг хянаж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулахад төсөв захирагчдын санхүүгийн сахилга бат, хариуцлагыг сайжруулахад анхаарч, оновчтой удирдлагыг хэрэгжүүлэх;
- Бараа, үйлчилгээний бусад зардал болон бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж зэрэг зардлуудыг хэт ерөнхий багцалсныг нарийвчилж, үйл ажиллагааны хөтөлбөрийн нэгэн адил баталсан эдийн засгийн ангиллаар хуваарилан төлөвлөж, зарцуулалтын ил тод хариуцлагатай байдлыг сайжруулах;
- Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын төсөвт эрхлэх асуудлын хүрээнд нь хамаарахгүй хороо, зөвлөл, ажлын албаны зардлыг төлөвлөж, санхүүжүүлэхгүй байх;
- Орон нутгийн зарим сан, ерөнхий данс, ангилагдаагүй данс, хөтөлбөр арга хэмжээний нэр, зориулалт ангиллыг хуульд нийцүүлэн тодорхой болгож, орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад мөрдүүлэх, хяналт, удирдлагын нэгдсэн бодлогоор хангах;
- Гадаад зээлээр санхүүжиж байгаа төсөл хөтөлбөрийн мөнгөн үрсгалыг бодитой төлөвлөж, зээлийн ашиглалт, өрийн менежментийг сайжруулах зэрэг болно.

Эдгээр зөвлөмж нь төсвийн сахилга бат, ил тод байдал, үр ашиг, хариуцлагыг бэхжүүлэхэд чиглэж буй.



## МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАНГААС


### Гадаадын зээл, тусламжийн санхүүжилт, 2024 он



### Улсын төсвийн тэнцэл, 2024 он

**1.28 их наяд төгрөг** Монгол Улсын 2024 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлого 20 их наяд төгрөг, нийт зарлага ба цэвэр зээл 21.3 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1.28 их наяд төгрөгийн алдагдалтай гарсан байна.

### 2024 оны улсын төсвийн алдагдлыг нөхсөн эх үүсвэр (тэрбум төг)



Эх сурвалж: МУ-ын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан (2025.6)

Боловсруулсан: О.Сэлэнгэ  
Нээлттэй Нийгэм Форум  
МУ, УБ-14240, Сүхбаатар дүүрэг,  
Жамъян гүний гудамж-5/1

Утас: (976) 76113207  
Веб: www.forum.mn  
И-мэйл: osf@forum.mn

Авлигатай тэмцэх газрын авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, түүнчлэн төрийн байгууллагууд нийтийн төсөв, өмч хөрөнгийг захиран зарцуулахтай холбоотой авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, санаачилгын талаар тус газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ахлах ажилтан, ахлах комиссар Д.Цэнд-Аюуштай Форум подкастын №12 дугаарт ярилцан нийтэд хүргэлээ.



“Нийтийн төсөв, өмч хөрөнгийн захиран зарцуулалтад тулгарч буй асуудлууд” сэдвээр АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ахлах ажилтан, ахлах комиссар Д.Цэнд-Аюуштай ярилцаж буй нь, Форум подкаст №12 (2025.04) (<https://forum.mn/post/165645>)

Тэрээр төрийн байгууллагуудад худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй ажлуудыг “яаралтай” гэсэн үндэслэлээр шууд гэрээгээр гүйцэтгүүлэх, нээлттэй сонгон шалгаруулалтаас зайлсхийх, гэрээний дүнг 20 сая төгрөгт багтаан хуваах зэрэг зөрчил түгээмэл болохыг онцоллоо. Мөн төрийн өмчит зарим компани гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсны дараа ажлын биелэлтэд нь үнэлгээ хийн, тайланг нь авч гэрээг дүгнэх зэрэг хяналтын үйл ажиллагаа хангалтгүй гэв. Түүнчлэн төрийн байгууллага, төрийн өмчит компаниудын хэвлэл, мэдээллийн байгууллагатай байгуулсан гэрээний мэдээллийг ил тод болгох талаар АТГ-аас зөвлөсөн ч хэрэгжилт хангалтгүй хэвээр буйг анхаарах шаардлагатай гэв.

## Засгийн газрын болон нийслэлийн мега төслүүдийн зураглал

Засгийн газраас 2025 оны улсын төсвийг батлахдаа 14 мега төсөл хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн юм. Үүнд Гашуунсухайт-Ганцмод төмөр зам, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын төсөл, Зэс боловсруулах болон Нүүрс-хими, кокс-химийн цогцолбор, Гангийн үйлдвэр, Тавантолгойн дулааны станц, Богдхан уулын туннель, Туулын хурдны зам, ган татлагат гүүрийн төслүүд багтаж байна. Эдгээрийг улсын төсөв, төрийн өмчит компанийн хөрөнгө, төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд санхүүжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд зарим хувийн санхүүжилттэй төсөлд Засгийн газрын баталгаа гаргахаар тусгасан юм. Энэ нь зээлдэгч зээлээ төлж чадахгүй тохиолдолд төлбөрийг татвар төлөгчдийн хөрөнгөөр төлөх баталгаа юм. Мега төслүүдийн санхүүжилт нь улсын өрийн түвшинд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх эрсдэлтэй тул эдгээр төслийн удирдлага, санхүүжилтийн шийдвэрүүдийг холбогдох хууль, журмын хүрээнд ил тод, хариуцлагатай хэрэгжүүлэх шаардлагатай.

Иймд Засгийн газар болон нийслэлээс 2024-2040 он хүртэл хэрэгжүүлэхээр зарласан нийт 38 мега төслийн эдийн засгийн үндэслэл, нийгмийн үр нөлөө, хэрэгжилтийн явц, санхүүжилтийн үндэслэл, хууль эрх зүйн дагалдах процесс, олон нийтэд нээлттэй байдлын түвшний зураглалыг судлаач А.Батпүрэв боловсрууллаа. Мега төслийн зураглал гаргахдаа Open Contracting for Infrastructure Data Standard (OC4IDS), мөн Олон улсын валютын сангийн Public Investment Management Assessment (PIMA) аргачлалд тулгуурлан төсөл бүрд үнэлгээ хийсэн юм. Судалгаагаар төрийн болон орон нутгийн түвшинд томоохон төслийн бодлого төлөвлөлт, хэрэгжилтийн чадавхад тодорхой сул тал, сорилтууд байгааг онцолж, менежментийг сайжруулах зөвлөмж дэвшүүлсэн бөгөөд үр дүнг 10 дугаар сард танилцууллаа.



“Засгийн газар болон нийслэлийн мега төслүүд” уулзалтын үеэр (2025.10)

Засгийн газрын болон нийслэлийн мега төслүүдийн мэдээллийг олон нийт нэг дороос үзэх боломжтой мэдээллийн цахим санг бий болгохоор зорьж, энэ хүрээнд 38 мега төслийн эдийн засаг, нийгэмд

үзүүлэх үр нөлөө, хэрэгжилт, санхүүжилт, хууль эрх зүйн дагалдах процесс, мэдээллийн ил тод байдлын түвшинд хийсэн зураглалыг инфографик хэлбэрээр бэлтгэн тус цахим санд байршууллаа.



<https://forum.mn/post/169045>



<https://forum.mn/mega-tusul>



<https://forum.mn/mega-tusul>



## ЗАСГИЙН ГАЗРЫН 14 МЕГА ТӨСЛИЙН ЗУРАГЛАЛ

Төлөвлөлт, санхүүжилт, хууль эрх зүйн дагалдах процесс, олон нийтэд нээлттэй байдал



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

### ТӨСӨЛ 1: ГАШУУНСУХАЙТ-ГАНЦМОД ХИЛ ДАМНАСАН ТӨМӨР ЗАМ



Төслийн зорилго	Экспортын хүчин чадлыг нэмэгдүүлэх
Хүрэх үр дүн	1. Экспортын орлого 2 дахин нэмэгдэнэ. 2. Тээврийн зардал 50% буурна. 3. Төмөр замаар нүүрс тээвэрлэх хүчин чадал 3 дахин нэмэгдэнэ. 4. Евро-Азийг холбосон транзит тээврийн шинэ гарц бий болно.
Хэрэгжүүлэх үе шат	1 үе шат
Байршил	Өмнөговь аймаг
Үйл ажиллагааны салбар	Зам, тээвэр
Төсөл баталсан шийдвэр, огноо	2025.3.27
Төсөл хэрэгжүүлэгч хуулийн этгээд	Эрдэнэс-Тавантолгой ХК
Санхүүжилтийн эх үүсвэр	Эрдэнэс-Тавантолгой ХК
ЗГ-ын баталгаа, батлан даалт байгаа эсэх	Нийтэд ил мэдээлэл байхгүй
Батлагдсан төсөв	848.9 тэрбум төгрөг
Батлагдсан төсөв төгрөгөөр (1 ам.доллар = 3576.53 төгрөг)	848.9 тэрбум төгрөг
Санхүүжилт батлагдсан эсэх	Тийм
Зарцуулалтын төлөвлөгөө, хэрэгжилтийн мэдээлэл	Нийтэд ил мэдээлэл байхгүй
Санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт байгаа эсэх	Үгүй
Төслийн хэрэгжилтийн байдал	Хэрэгжиж эхэлсэн
Үйл ажиллагааны тайлан байгаа эсэх	Үгүй
Шаардлагатай зөвшөөрлүүд авсан эсэх	Тийм
Техник-эдийн засгийн үнэлгээ хийсэн эсэх	Тийм
Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийсэн эсэх	Нийтэд ил мэдээлэл байхгүй
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайлан байгаа эсэх	Нийтэд ил мэдээлэл байхгүй
Холбогдох талуудтай зөвшилцөлд хүрсэн эсэх, үр дүн	Тийм
Төсөл хэрэгжүүлэгчийн сонгон шалгаруулалтын мэдээлэл нээлттэй эсэх	Тийм
Төслийн хэрэгжилттэй холбоотой худалдан авалтын төлөвлөгөө, сонгон шалгаруулалтын мэдээлэл нээлттэй эсэх	Нийтэд ил мэдээлэл байхгүй
Ханган нийлүүлэх гэрээ, үүний дүн, ханган нийлүүлэгчдийн жагсаалт байгаа эсэх	Нийтэд ил мэдээлэл байхгүй
Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт байгаа эсэх	Үгүй

Тайлбар: Зураглалыг нийтэд нээлттэй мэдээлэлд үндэслэн гаргав.  
2025 оны 9 дүгээр сар

Боловсруулсан:  
Судлаач  
А.Батпүрэв

Нээлттэй Нийгэм Форум  
Монгол Улс, Улаанбаатар-14240,  
Сүхбаатар дүүрэг, Жамьян гүний гудамж-5/1

Утас: (976) 76113207  
Веб: www.forum.mn  
И-мэйл: osf@forum.mn

## Төсвийн нээлттэй байдлын олон улсын судалгаа

Төсвийн төлөвлөлт, зарцуулалтын хариуцлагыг сайжруулахад иргэний нийгмийн оролцоо нэн чухал бөгөөд төсвийн ил тод байдлыг хангах нь иргэдийг мэдээлэлтэйгээр хэлэлцүүлэг, мэтгэлцээнд оролцох нөхцөлийг бүрдүүлдэг юм. Олон улсын төсвийн түншлэл ([www.internationalbudget.org](http://www.internationalbudget.org)) байгууллагаас хоёр жил тутам эрхлэн гаргадаг "Төсвийн нээлттэй байдлын олон улсын судалгаа"-ны 2023 оны дүнгээр манай улсын төсвийн ил тод байдлын үзүүлэлт авбал

зохио 100 онооноос 62, хяналтын тогтолцоогоор 80 оноо авсан бол олон нийтийн оролцооны үзүүлэлтээр дөнгөж 19 оноо авч байсан нь энэ чиглэлд ахиц гараагүйг харуулж байна.

Энэ онд мөн манай судлаач дэлхийн 100 гаруй орныг хамарсан "Төсвийн нээлттэй байдал 2025" ээлжит олон улсын судалгаанд Монгол Улсын үнэлгээг гүйцэтгэн оролцлоо. Уг судалгааны нэгдсэн дүнг 2026 онд дэлхий даяар танилцуулах юм.

## Эдийн засаг дахь төрийн оролцоо

Эдийн засаг дахь төрийн оролцоо нь стратегийн салбаруудыг хамгаалах, байгалийн баялгийн үр өгөөжийг иргэдэд тэгш, шударга хүртээх, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг хангахад чухал ач холбогдолтой. Гэвч хэт давамгайл оролцоо эдийн засгийг улс төржүүлэх, уул уурхайгаас улам бүр хамааралтай болгох, хувийн хэвшлийн орон зайг хүмийх, хөрөнгө оруулалтыг бууруулах, авлигын эрсдэлийг нэмэгдүүлэх зэрэг сөрөг үр дагавартай. Иймд "Ай Би менежмент консалтинг" ХХК-ийн судалгааны баг төрөөс төсөв болон төрийн өмчит аж ахуйн нэгжээр дамжуулан эдийн засагт оролцож

буй түвшнийг үнэлсэн харьцуулсан судалгаа хийж, оролцоог оновчтой болгох бодлогын зөвлөмж боловсрууллаа. Судалгаагаар эдийн засаг дахь төрийн оролцоог зөвхөн багасгах бус, харин зохистой түвшинд, чанартай, үр ашигтай байлгах нь урт хугацааны тогтвортой хөгжил, бүтээмж, нийгмийн тогтвортой байдлыг хангахад чухал болохыг онцолсон юм. "Монгол Улсын эдийн засаг дахь төрийн оролцоо" хэлэлцүүлгийг 2025 оны 11 дүгээр сард зохион байгуулж, судалгааны үр дүнг танилцуулан бодлогын түвшний хэлэлцүүлэг өрнүүлэв.



"Монгол Улсын эдийн засаг дахь төрийн оролцоо" хэлэлцүүлгийн үеэр (2025.11)

“

**Судалгааны дүгнэлтийн хураангуй:**

- Эдийн засаг дахь төрийн оролцоо хэт өндөр байна. Сүүлийн 10 жилд улсын төсвийн орлого, зарлага, алдагдал, өрийн хэмжээ огцом өсөн, татварын орлого ДНБ-ий 34.2 хувьд хүрч, зарлага 30 их наяд төгрөг давсан нь зах зээлийн механизм болон хувийн хэвшлийн үйл ажиллагаанд ачаалал үүсгэж байна.
- Үр ашиг муутай Төрийн өмчит аж ахуйн нэгжүүд (ТӨААН)-ийн эдийн засаг дахь нөлөө их байна. ТӨААН-үүдийн хөрөнгө ДНБ-ий гуравны нэг орчим, орлого ДНБ-ий 33.2 хувьд хүрч, нийт ажиллагсдын 10 хувийг ажиллуулж буй нь тэдний эдийн засаг дахь давамгайл байр суурийг илтгэнэ.
- Бизнесийн орчин дахь төрийн оролцоо үр ашиггүй байна. Хууль, эрх зүйн орчныг үнэлэхэд зохицуулалт олон давхаргатай, зааг тодорхойгүй, хэрэгжилт сул, ТӨААН-үүдийн статус тодорхойгүй байгаа нь институцийн уялдаа, хариуцлагын механизм сул буйг илтгэнэ. Хөгжлийн банкны зээлийн бодлого, ТУЗ-ийн хараат байдал, түсгай зөвшөөрлийн хэт төвлөрөл зэрэг нь өрсөлдөөн, хөрөнгө оруулалтын орчинд эрсдэл үүсгэж байна. Эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөөний индекс буурсан нь энэ хандлагыг нотолно.
- Олон улсын туршлагаас харахад төрийн оролцоо ихэвчлэн стратегийн салбаруудад төвлөрөх боловч хөгжингүй орнуудад өндөр хяналт, ил тод байдал, зах зээлийн өрсөлдөөнтэй уялдсан байдлаар хэрэгждэг. OECD-ийн орнуудад төсвийн зардал ДНБ-ий 42 хувьтай (2023) байгаа бол Швед зэрэг улс оронд зардал ДНБ-ий талаас давдаг ч энэ нь хүний хөгжилд чиглэсэн салбаруудад төвлөрдөг байна. Харин хөгжиж буй орнуудад зардал дэд бүтэц, суурь үйлчилгээнд давамгайлж, нийгмийн хамгааллын хамралт харьцангуй бага хэвээр байна.

Судалгааны багийн зүгээс Монгол Улсын төрийн эдийн засаг дахь оролцоог оновчлох (1) төсвийн хэмжээ ба бүтээмж, (2) ТӨААН-үүдийн реформ, (3) бизнесийн орчны зохицуулалт гэсэн гурван гол чиглэлд нийт 8 бодлогын хувилбар дэвшүүлж харьцуулан үнэлжээ. Үнэлгээний үр дүнд боломжит бодлогуудыг дараах 3 үе шатад хуваажээ. Үүнд:

- Шүүрхай хэрэгжих боломжтой: Зөвшөөрлийн шинэчлэл, KPI суурьтай санхүүжилт, чиг үүргийн оновчлол;

- Дунд хугацааны реформ: ТӨААН-үүдийг нээлттэй хувьцаат компани болгох, мөчлөг сөрсөн сангийн бодлого нэвтрүүлэх;
- Стратегийн шинэчлэл: Төрийн өмчлөлийн дээд хязгаар тогтоох, ТӨААН-үүдийг татан буулгах бодлогууд стратегийн үр ашиг өндөртэй ч улс төр, институцийн сорилт ихтэй байна.



Судалгааны багийн дүгнэлтээр Монгол Улсад эдийн засаг дахь төрийн оролцоо нь институцийн сул

чадавх, бодлого төлөвлөлтийн алдаа, хариуцлагын механизмын дутагдлаас шалтгаалан үр ашиггүй болж, зах зээлийн гажуудал үүсгэх түвшинд хүрээд байна. Төсөв болон ТӨААН-үүдээр дамжин хэрэгжиж буй хэт өндөр, үр ашиг багатай оролцоо нь хувийн хэвшлийн өрсөлдөх чадвар, бүтээмж, урт хугацааны тогтвортой өсөлтөд сөргөөр нөлөөлж буйг онцлов. Төрийн оролцоо стратегийн салбар, нийтийн үйлчилгээний хүрээнд зайлшгүй байх ч цаашид зах зээлийн механизм давамгайлсан, хязгаарлагдмал, чанартай оролцооны загварт шилжих шаардлагатай. Санал болгож буй бодлогын хувилбаруудыг үе шаттай хэрэгжүүлснээр төрийн оролцоог илүү үр ашигтай, хариуцлагатай, судалгаа шинжилгээнд суурилсан оновчтой түвшинд хүргэж, урт хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлт, иргэдийн амьдралын чанар, төрд итгэх итгэлийг бэхжүүлэх боломж бүрдэнэ гэж үзэж байна.

**Эдийн засгийн өрсөлдөх чадварын судалгаа**

Монгол Улс Дэлхийн эдийн засгийн форум (ДЭЗФ)-аас эрхлэн гаргадаг Өрсөлдөх чадварын судалгаанд 2005 оноос хамрагдаж ирсэн юм. Уг судалгаа нь дэлхийн улс орнуудын нийгэм, эдийн засагт ихээхэн сөрөг үр дагавар авчирсан Ковид-19 цар тахал гарч, дэлхийн улс орнуудын нийгэм, эдийн засагт томоохон сөрөг нөлөө үзүүлсэн 2019 он хүртэл жил бүр улс орнуудын өрсөлдөх чадварын зэрэглэлийг тодорхойлон гаргасан юм. Энэ хүрээнд манай судлаачид салбарын мэргэжилтнүүдтэй хамтран, өрсөлдөх чадварын индексийг тодорхойлоход чухал ач холбогдолтой бизнесийн удирдах ажилтнуудын

санаа бодлыг жил тутам тандан судалж ирлээ.

ДЭЗФ Ковид-19 цар тахлаас хойш өрсөлдөх чадварын зэрэглэл гаргаагүй ч бизнесийн санал асуулгыг жил бүр авч, Дэлхийн эрсдэлийн тайлан (Global Risks Report), Дэлхийн жендерийн ялгааны тайлан (Global Gender Gap Report), Аялал, жуулчлалын хөгжлийн индекс (Travel and Tourism Development Index), Ажлын байрны ирээдүйн тайлан (The Future of Jobs Report) зэрэг тайланд ашиглаж байна. Энэ хүрээнд 2025 онд Монгол Улсын бизнесийн орчныг тодорхойлох олон улсын үнэлгээний судалгааг мөн гүйцэтгэлээ.

## Төсөвт иргэдийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр

Засгийн газраас төсвийн үйл явцад олон нийтийг оролцуулах тал дээр анхаарах шаардлагатайг олон улсын судалгаа харуулж байна. Тухайлбал, “Төсвийн нээлттэй байдлын олон улсын судалгаа”-ны 2023 оны үнэлгээгээр манай улс төсвийн үйл явц дахь олон нийтийн оролцооны үзүүлэлтээр 19 оноо авсныг дээр өгүүлсэн.

Төсвийн тухай хуульд 2023 онд орсон нэмэлт өөрчлөлтөөр төсөв боловсруулах явцад олон нийтийн оролцоог хангах нааштай зохицуулалтууд тусгагдсан. Үүнд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах, санал авах цахим хуудас ажиллуулах, салбар бүрээр хэлэлцүүлэг явуулах, гарсан саналыг төсөвт хэрхэн

тусгасныг нийтлэх зэрэг шаардлагууд багтсан бөгөөд тайлант оноос хэрэгжиж буй. Эдгээр заалтын хэрэгжилтийг эхнээс нь хангах нь цаашид хуулийн үр нөлөөг бататгахад чухал ач холбогдолтой.

Энэ хүрээнд “Монголын залуучуудын эвсэл” ТББ-ын “Төсвөө мэдье-Төсвөө мөшгөө” төслийг дэмжив. Төсөл нь хуулийн хэрэгжилтэд нөлөөлөх, дүн шинжилгээ хийх, 2024 оны төсвийн гүйцэтгэлийн аудитын дүнг энгийн, ойлгомжтой хэлбэрээр тайлбарлах контент бэлтгэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн хэлэлцүүлэг, мэдээллийн аян зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлээ.

## ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨР

Эрдэс баялгийн салбарын засаглалын хөтөлбөр нь өнгөрөгч онд байгалийн баялгаа урт хугацааны хөгжлийн бодлоготой үялдуулан тогтвортой, хүртээмжтэй өсөлт бий болгоход зохистой ашигладаг болоход хувь нэмэр оруулах зорилгын хүрээнд Үндсэн хуулиар тогтоосон тогтвортой хөгжлийн үзэл санааг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэх, төрийн өмчит компани (ТӨК)-ийн засаглал, олон нийтийн хяналтыг сайжруулах зорилт дэвшүүлэн ажиллалаа.

### Эрх зүйн шинэчлэлийг дэмжих нь

Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх эрх зүйн шинэчлэлийн үйл явц эрдэс баялгийн салбарт 2020 оноос эхлэн өрнөж буй ч дорвитой ахиц гаралгүй зургаа дахь жилийнхээ нүүрийг үзэж байна. Энэ хугацаанд салбарын яамны зүгээс дөрвөн удаа хуулийн төсөл боловсруулж, олон нийтэд танилцуулсан боловч УИХ-д өргөн бариагүй хэвээр байна. Дээрх хуулийн төсөлд тусгагдсан орон нутгийн харилцаа, ил тод байдал, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, байгаль орчны шаардлага зэрэг асуудлаарх шийдлүүд харилцан адилгүй бөгөөд эрс ялгаатай байгаа нь эдгээр нэн тулгамдсан засаглалын асуудлаарх салбарын яамны бодлого тодорхойгүй байгааг илтгэнэ. Нөгөөтээгүүр, эдгээр төслүүдийн аль нь ч 2020 онд УИХ-аас баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” тогтоолд заасан “...байгалийн баялаг ашиглах шийдвэр гаргах зарчим, журмыг боловсронгуй болгох, онцгой ач холбогдол бүхий зарим асуудлаар иргэдтэй зөвлөлдөх, тэдний саналыг авч тусгах механизмыг тодорхой болгох, үялдаа холбоог хангах, байгалийн тэнцлийг хангах, нөхөн сэргээхтэй холбоотой талуудын үүрэг хариуцлагыг тодорхой болгох” шаардлагад нийцэхгүй байв. Тэрчлэн хуулийн

төсөл боловсруулах үйл явц нь Хууль тогтоомжийн тухай хуулиар тогтоосон ил тод байдал, олон нийтийн хэлэлцүүлэг, нэн ялангуяа эрх, ашиг сонирхол нь хөндөгдөх талуудын оролцоог хангах, судалгаа, шинжилгээнд үндэслэх зарчим, шаардлагад бүрэн нийцээгүй билээ.

2024 онд явагдсан УИХ-ын сонгуулиас шалтгаалан Ашигт малтмалын тухай хуулийн шинэчлэлийн үйл явц бүрэн зогссон төдийгүй энэ зогсонги байдал өнгөрөгч оны сүүлийн улирал хүртэл үргэлжилсэн билээ. Харин Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам 2025 оны 10 дугаар сараас хуулийн төслийг шинэчлэн боловсруулж эхэлсэн гэх боловч олон нийтэд танилцуулаагүй хэвээр байна.

Ийм нөхцөлд хөтөлбөрийн зүгээс судалгаа шинжилгээний ажлаа үргэлжлүүлэхийн хамт хууль тогтоомжийн төсөл боловсруулах үйл явцыг нягт ажиглан, өнгөрсөн хугацаанд гарсан алдаа дутагдлыг давтахгүйн тулд судалгаа, тоо, баримтаар баталгаажуулахад анхаарч ажиллав. Хуулийн төсөл боловсруулах үйл явцад гарч буй алдаа дутагдал буюу Хуулийн тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийн талаарх цуврал шинжилгээ, хэлэлцүүлэг, нөлөөллийн үйл ажиллагааны талаар дор дэлгэрэнгүй өгүүлэх болно. Тэрчлэн судалгаа

шинжилгээ, олон нийтийн хэлэлцүүлэгт тулгуурлан боловсруулсан санал шүүмжээ УИХ-ын гишүүд, салбарын яамд, Хүний эрхийн үндэсний комисс зэрэг холбогдох байгууллагуудад хүргэхэд анхаарав.

Тухайлбал, УИХ-ын Хүний эрхийн дэд хорооны уулзалтад оролцож, ашигт малтмал болон байгаль орчны хууль тогтоомжийн шинэчлэлд анхаарах асуудлуудын талаар мэдээлэл хүргэлээ.



Хүний эрхийн дэд хорооны уулзалтаар ашигт малтмал, байгаль орчны хууль тогтоомжийн шинэчлэлийн талаар хэлэлцэв. (2025.04.24)

Түүнчлэн энэ онд газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг орон нутагт шударгаар хуваарилах, уул уурхайн ханган нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлэх, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтэд холбогдох асуудлуудаар бодлогын шинжилгээ хийж, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал шүүмж хүргүүлээ.

Эрдэс баялгийн салбарын засаглалын тулгамдсан асуудлын нэг нь орон нутгийн харилцааны зохицуулалт юм. Уул уурхайн үйл ажиллагаа нь

нийгэм, эдийн засгийн хувьд үр өгөөжтэй байхын зэрэгцээ хамгийн гол нь олборлолт явагдаж буй орон нутгийн иргэдийн амьдрах орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх учиртай. Орон нутгийг хөгжлийн албан ёсны түншлэгч хэмээн хүлээн зөвшөөрч, харилцан ашиг тустай, хариуцлагатай хамтын ажиллагааг бэхжүүлэх нь уг асуудлыг шийдвэрлэх суурь нөхцөл болно.

Газрын хэвлийн баялгаас орон нутагт нүдэнд үзэгдэж, гарт баригдахуйц бодит өгөөж бий болгох нэг арга зам нь Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС)-

аар дамжуулан хөрөнгийг эргэн хуваарилах явдал юм. Гэвч арав гаруй жилийн өмнөөс хэрэгжиж буй уг зохицуулалтын хэрэгжилт, сангийн хөрөнгө бүрдүүлэлт, эргэн хуваарилалт, ялангуяа уул уурхай бүхий сумдад хэрхэн хуваарилж, ямар үр нөлөө авчрах нь тодорхой бус байна. Иймд ОУИТБС-ын тайлан мэдээлэл, улсын төсөв болон ОНХС-ийн өгөгдөлд дүн шинжилгээ хийх замаар ашигт малтмалын тусгай зөвшөөрөл болон нөөц ашигласны төлбөр (АМНАТ)-ийн хуваарилалт, зарцуулалтад үнэлгээ хийлээ. Сэтгүүлч З.Цэлмэг, “Өгөөжийг өөрт нь үлдээхгүй бол уурхайтай нутагт хөгжил ирэхгүй” сэдэвт өгөгдлийн шинжилгээнд суурилсан сэтгүүл зүйн бүтээлээрээ ОНХС-д төвлөрөх орлого өссөөр 2021 оны түвшнээс бараг 4 дахин нэмэгдсэн боловч уурхай бүхий сумдад хуваарилалт хангалтгүй байгааг хөндсөн байна. Энэхүү нөхцөл байдал нь нэг талаар ОНХС-ийн хуваарилалт тооцох аргачлал тусгай зөвшөөрөл бүхий талбайн хэмжээнээс өөр орон нутагт уурхайн үзүүлэх бодит нөлөөлөл, байгаль орчин, нийгмийн ачааллыг харгалзан үздэггүйтэй холбоотой. Нөгөө талаар аргачлал, итгэлцүүр ямар байхаас үл хамааран сангийн хуваарилалтад улс төрийн нөлөөлөл, хууль зөрчих эрсдэл буйг Дорноговь аймгийн Даланжаргалан сумын жишээгээр харуулжээ.

Уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл төвлөрсөн, нутаг дэвсгэрийнх нь 15 хувийг эзлэх 80 гаруй тусгай зөвшөөрөлтэй уг сум сүүлийн таван жилд 20 гаруй тэрбум төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн боловч орлоготойгоо дүйцэхүйц өгөөж хүртэж чадахгүй байна. 2020-2025 онд Дорноговь аймагт хийсэн хөрөнгө оруулалтын ердөө нэг хувь нь Даланжаргалан суманд ногджээ. Энэ байдал ирэх жилүүдэд ч үргэлжлэх магадлал өндөр. 2026 онд тус сум 10.7 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, ОНХС-аар 493 сая төгрөгийн санхүүжилт авахаар төсөвт тусгагджээ. Гэтэл

тусгай зөвшөөрлийн тоо, төвлөрүүлэх орлогын хэмжээгээр Даланжаргалан сумаас харьцангуй бага Сайншанд, Замын-Үүд сумд жил бүр илүү өндөр санхүүжилт авдаг ба зарим тохиолдолд хүн амын тоонд суурилсан итгэлцүүрээр тооцоноос давсан хэмжээний санхүүжилт авдаг ажээ.

ОНХС-ийн хуваарилалт, зарцуулалтад аймаг, орон нутгийн удирдлага, улс төрийн нөлөөлөл түгээмэл бөгөөд олон нийтэд таалагдах, сонгуулийн мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх зорилгоор ашиглах хандлага илэрч байна. Аймгийн хэмжээнд ОНХС-ийн хуваарилалт тухайн сумын ИТХ-д аль нам олонх байгаагаас хамаарах явдал ажиглагдаж, бодит хэрэгцээ, хөгжлийн төлөвлөлтөд суурилагаас илүүтэй Засаг даргын мөрийн хөтөлбөрийн санхүүжилтийн хэрэгсэл болж хувирах тохиолдол гарч байна. Мөн сангийн зарцуулалтад тавих аудитын хяналт сул байгааг нийтлэлд дурджээ. Эцэст нь ОНХС-ийн хуваарилалтын энэхүү гажуудал нь уул уурхайн компани нутгийн иргэдийн хооронд итгэлцэлд суурилсан, харилцан ашигтай түншлэл бий болгох бодлогын үр нөлөөг сулруулж байна.

Өгөөжийг өөрт нь үлдээхгүй бол уурхайтай нутагт хөгжил ирэхгүй

<https://forum.mn/product/589443>

## Үндэсний баялгийн сангийн засаглалыг сайжруулах нь

Хөтөлбөрийн хүрээнд энэ онд Үндэсний баялгийн сангийн тухай хуульд шинжилгээ хийж, түүний хэрэгжилтэд анхаарах асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэв. Тус хууль 2024 онд батлагдсанаар Ирээдүйн өв сан, Хөгжлийн сан, Хуримтлалын сангаас бүрдэх Үндэсний баялгийн сан (ҮБС) байгуулагдаж, байгалийн баялгийн үр өгөөжийг арвижуулан өнөө ба ирээдүй үедээ тэгш, шударга хуваарилах Үндсэн хуулийн үзэл санааг хэрэгжүүлэх тогтолцооны эхлэл тавигдсан юм. Гэсэн хэдий ч уг хуулийг сонгуулийн өмнө олон нийтийн хэлэлцүүлэг, судалдаа шинжилгээний хангалттай үндэслэлгүйгээр яаравчлан баталсан нь чиг үүргийн хуваарилалт, хяналт тэнцлийн механизм, ил тод байдал, олон нийтийн хяналтын зохицуулалт зэрэг засаглалын суурь зарчмууд орхигдоход нөлөөлжээ. Энэ нөхцөлд Хүний хөгжил сан, Үндэсний хөгжлийн сан, ЖДҮ-ийн санхүүжилт, Хөгжлийн банкны сургамж давтагдахгүй гэх баталгаа үгүй билээ.

“Үндэсний баялгийн сангийн тухай хууль, түүний хэрэгжилтэд анхаарах асуудал: Эрсдэл ба шийдлийн хувилбар” сэдэвт бодлогын шинжилгээгээр Хуримтлалын сан, Хөгжлийн сан зэрэг төрөлжсөн сангуудын засаглал, удирдлагын тогтолцоо, хөрөнгийн удирдлагын мандат, ил тод байдал, тайлагналын зохицуулалт нь энэ төрлийн санд тавигдах олон улсын нийтлэг зарчим, стандартад бүрэн нийцэхгүй байгааг онцолсон юм. Бодлогын шинжилгээнд сангийн удирдлагыг салбарын яамнаас салгаж, бие даасан, хараат бус, мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, ил тод байдал, олон нийтийн болон хөндлөнгийн аудитын хяналтын

үр нөлөөтэй тогтолцоо бүрдүүлэхийг зөвлөмж болголоо. Түүнчлэн 2016 онд батлагдсан Ирээдүйн өв сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, “Ирээдүйн өв сан корпорац” байгуулан, олон улсын санхүүгийн хэрэгслээр дамжуулж сангийн хөрөнгийг өсгөн арвижуулах ажлыг нэн даруй эхлүүлэх шаардлагатайг сануулсан юм.

Бодлогын шинжилгээний дүнг 2025 оны 05 дугаар сард салбарын мэргэжилтнүүдийн оролцоотой хэлэлцүүлж, “Форум” подкастын 15 дахь дугаараар олон нийт, бодлого боловсруулагчдад хүргэлээ. Хэлэлцүүлэгт Сангийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Үндэсний аудитын газар зэрэг төрийн байгууллага, иргэний нийгэм, уул уурхайн компаниудын төлөөлөл, судлаачид, сэтгүүлчид оролцож, ҮБС-ийн төрөлжсөн сангуудын удирдлага, засаглалын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх, сан тус бүрд хөрөнгийн удирдлага хэрэгжүүлэх бие даасан корпорац байгуулах, хөрөнгө оруулалтын мандат зэрэг нэн шаардлагатай бодлогын баримт бичгүүдийг даруй батлах талаар ажил хэрэгч саналууд дэвшүүлсэн юм. Хамгийн гол нь баялгийн сангийн орлогыг нэмэгдүүлэх хүрээнд төрийн өмчит уул уурхайн компаниудын засаглалыг сайжруулах, төрийн шууд оролцоо болон төлөвлөгдөөгүй зардлын дарамтыг бууруулах, шаардлагатайг онцлон тэмдэглэв. Түүнчлэн стратегийн ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч компанид төрийн хувь эзэмшлийг тогтоохдоо компанийн үйл ажиллагаа, үнэ цэнийг алдагдуулахгүй байх зарчмыг чанд баримтлах нь зүйтэйг анхааруулж байв.



<https://forum.mn/product/533607>



<https://forum.mn/post/166980>



## Байгалийн баялгийн үр өгөөжийг тогтвортой хөгжилд чиглүүлэх нь

Газрын хэвлийн баялгийг урт хугацааны тогтвортой өсөлт, хөгжилд чиглүүлж, нөөц шавхагдсаны дараа ч үнэ цэнээ хадгалах, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх нь байгалийн баялагт түшиглэсэн эдийн засагтай улс орнуудад тулгарч буй сорилт юм. Эдийн засгийг төрөлжүүлэх, бизнесийн шинэ боломж нээхэд уул уурхайн салбар шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх боломжтой. Өөрөөр хэлбэл, салбарын үр өгөөжийг зөвхөн төсөвт төвлөрөх мөнгөн урсгалаар хязгаарлахгүйгээр технологи инновац, үр чадвар, ноу-хауг нутагшуулах, ханган нийлүүлэлтийн бодлогоор дамжуулан үйлдвэрлэл, үйлчилгээний шинэ чиглэлүүдийг хөгжүүлэхэд чиглэсэн алсын хараа, бодлогын үялдаа шаардлагатай байна.

Монгол Улсын уул уурхайн бодлого, зохицуулалтад “local content” буюу хүний хөгжил, технологи, инновац, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих

зохицуулалт хангалтгүй байна. Иймд “Уул уурхайн салбарт ханган нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх бодлого, зохицуулалт” сэдэвт харьцуулсан судалгаа хийж, үндэсний бодлого, эрх зүйн орчныг олон улсын стандарт, чиг хандлага болон Канад, Австрали, Гана, Танзани зэрэг улсын туршлагатай харьцуулан үнэлэв. Үүний үндсэн дээр “дотоодын ханган нийлүүлэлт” гэх ойлголтыг хууль эрх зүйн орчинд тодорхойлон тусгах, уул уурхайн компаниудын худалдан авалтын тодорхой хувийг дотоодоос, ялангуяа орон нутгаас бүрдүүлэх шаардлага бий болгох нь зүйтэйг онцолсон юм. Үүний зэрэгцээ төрөөс дотоодын ханган нийлүүлэгчдийг дэмжих, чадавч бэхжүүлэх арга хэмжээг системтэй төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатайг тэмдэглэв.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн шинэчлэл нь удтал шүүмжлэл

дагуулж ирсэн байгаль орчны үнэлгээний чанарыг сайжруулах, түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан иргэдийн мэдэх эрх, оролцоог хангахад нэн чухал юм. Өмнөх жилүүдэд бид иргэний нийгмийн байгууллагуудын дунд хэлэлцүүлэг өрнүүлж, хуулийн төслийг Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүрэг амлалттай харьцуулан шинжилсэн билээ. Тайлант онд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас боловсруулсан хуулийн төсөлд санал шүүмж хүргүүлэв. Хуулийн төсөлд өнөөг хүртэл бодитой хэрэгжүүлж чадаагүй байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг хэрэгжүүлэх зэрэг дэвшилттэй зохицуулалтууд тусгагдсан нь сайшаалтай. Гэсэн хэдий ч төсөл, хөтөлбөрийг оновчтой шалгуургүйгээр зэрэглэл тогтоон ангилах, зарим ангилалд тавих байгаль орчны үнэлгээ болон иргэдийн оролцооны шаардлагыг сулруулсан, нийгмийн нөлөөллийн үнэлгээг албажуулах оролдлого хийсэн боловч процессын нарийвчилсан шаардлагуудыг бүрэн тусгаагүй зэрэг анхаарах асуудлууд байна. Иймд хуулийн шинэчлэлийг зөвхөн нэмэлт, өөрчлөлтөөр хязгаарлахгүйгээр шинэчилсэн найруулгын

түвшинд авч үзэх, нийгмийн нөлөөллийн үнэлгээг баталгаажуулахад чиглэсэн зарчмын шинжтэй цогц өөрчлөлт хийх, эсхүл Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний тухай хууль болгон батлах саналыг уламжлав. Хууль боловсруулах ажиллагаанд Хууль тогтоомжийн тухай хуулийг чанд баримталж, өргөн хүрээний хэлэлцүүлэг зохион байгуулах шаардлагатайг тэмдэглэлээ.



<https://forum.mn/product/590097>

## Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах нь

Эрдэс баялгийн салбарт өнгөрсөн хугацаанд өрнөсөн эрх зүйн шинэчлэлийн үйл явцыг нэгтгэн дүгнэхэд Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулахгүйгээр нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, хэрэгжих чадвартай “сайн” хууль батлагдана гэсэн хүлээлт биелэхгүй гэдэг нь тодорхой байна. Иймд хууль бүтээх үйл ажиллагаанд тавих шаардлагыг улам чамбайруулж, хэрэгжилтийг сайжруулах зорилгоор Хууль тогтоомжийн тухай

хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, үр дүнг ажил хэрэг болгоход анхаарав.


Энэ хүрээнд 2025 онд УИХ-аас Хууль тогтоомжийн тухай хуулийг шинэчлэх ажлыг санаачлан хэрэгжүүлсэн нь судалгаа, шинжилгээний үр дүнг бодлого зохицуулалтад тусгуулах боломж бүрдүүлэв. Тухайлбал, УИХ-аас байгуулсан дэд ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж, 2024 онд хийсэн Төсвийн тухай хуулийн “дагалдах хууль”-ийн шинжилгээ, хуулийн

төслийн ил тод байдал, олон нийтийн оролцоо, хүний эрхийн нөлөөллийн үнэлгээний чанар, хууль батлах яаралтай горимын хэрэглээтэй холбоотой судалгааны дүнг холбогдох талуудаар хэлэлцүүлэн,


Хууль тогтоомжийн тухай хуулийн төсөлд санал шүүмж хүргүүлэв. Дээрх асуудлын хүрээнд “Форум” подкастын 7, 9, 10, 14 дэх дугаарыг бэлтгэн, олон нийтэд хүргэлээ.



Хууль тогтоомжийн тухай хуулийн асуудлаарх цуврал подкастыг ННФ-ын <https://forum.mn/podcast> веб хуудас болон YouTube <https://www.youtube.com/@OpenSocietyForumStudio/podcasts> сувгаас үзэх боломжтой.



“Хууль тогтоох үйл ажиллагаа: Хуулийн хэрэгжилт, зөвлөмж” хэлэлцүүлэг, (2025.03.20) <https://forum.mn/post/164619>



Судлаач Р.Оюундэлгэр, Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс зохион байгуулсан “Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системийн шинэчлэл: Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөл байршуулах, хэлэлцүүлэх, олон нийтээс санал авах систем” хэлэлцүүлэгт судалгааны үр дүнгээ танилцуулж буй нь (2025.04.01)

2025 оны 05 дугаар сард батлагдсан Хууль тогтоомжийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд ил тод байдал, олон нийтийн хэлэлцүүлэг, хүний эрхийн үнэлгээний чанарыг сайжруулахад чиглэсэн дэвшилтэй зохицуулалтууд тусгагдсан. Тодруулбал, хууль тогтоомжийн төслийг Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (www.legalinfo.mn)-ээр дамжуулан нийтэд мэдээлж, санал авах зохицуулалт хэрэгжиж эхэлснээр хууль санаачлагчид төслөө өөрсдийн цахим хуудсанд харилцан адилгүй хэлбэрээр, ихэнхдээ бүрэн бус, татан авах болон машинаар унших боломжгүй байдлаар нийтэлдэг байсан дутагдал арилах нөхцөл бүрдэж байна.

Энэ чиглэлийн судалгааг энэ онд мөн үргэлжлүүлж, хууль тогтоомжийн төсөл боловсруулах явцад хийх судалгаа, шинжилгээний чанар, нийтийн өргөдөл хянан шийдвэрлэх ажиллагаа, УИХ-ын тогтоолын төсөл боловсруулах үйл явц зэрэг асуудлуудыг шинжлэн судлав.

Хуулийн төслийг судалгаа, шинжилгээнд үндэслэн боловсруулах нь хууль бүтээх үйл ажиллагаанд баримтлах үндсэн зарчим юм. Юуны өмнө хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг тандан судалж, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд хэрэгжилт, үр дагаврыг нь үнэлсний үндсэн дээр үзэл баримтлалыг тодорхойлох шаардлагатай. Үүний дагуу боловсруулсан төслийн үр нөлөө, зардал, хэрэгжих чадамжийг дахин үнэлж, шаардлагатай сайжруулалт хийсний үндсэн дээр өргөн мэдүүлэх бэлтгэл хангагдсан гэж үзнэ.

Гэвч дээрх шаардлага бодит хэрэгжилтийн түвшинд хангалтгүй мөрдөгдөж, судалгаа огт хийхгүй байх, хийсэн ч тогтоосон аргачлалыг бүрэн баримтлахгүй байх дутагдал түгээмэл байна. “Хууль тогтоомжийн төсөл судалгаа, шинжилгээнд үндэслэх зарчмын хэрэгжилт” судалгааны тайланд 2020-2024 онд

батлагдсан хуулиудын 20 гаруй хувьд холбогдох судалгаа хийгдээгүй, өөрөөр хэлбэл дээрх зарчмын хэрэгжилт хангалтгүй байгааг онцлоод судалгаа хийсэн тохиолдлуудад ч аргачлалыг бүрэн мөрдөөгүй, зарим үе шат, шаардлагыг алгассан, баримт нотолгоонд тулгуурлаагүй, хэт ерөнхий дүгнэлт, зөвлөмж давамгайлсан зэрэг алдаа дутагдал нийтлэг байгааг тогтоожээ. Үүнээс гадна судалгааны үр дүнд үндэслэн хуулийн төслийг эргэн сайжруулах практик хангалтгүй байна. Эдгээр алдаа дутагдал байсаар атал хуулийн төслийг шалгасан шат шатны эрх зүйн дүгнэлтэд дээрх асуудлуудыг хангалттай тусгадаггүй бөгөөд судалгаагүй төслийг буцаасан тохиолдол огт бүртгэгдээгүй нь ерөөс тооцоо судалгаанд ач холбогдол өгдөггүйг илтгэж байна.

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх зохицуулалтын хэрэгжилт” сэдэвт бодлогын шинжилгээгээр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжид таван жил тутам тогтмол хийгдэхээр хуульчилсан үнэлгээний хэрэгжилтийг авч үзэв. Монгол Улсад нийт 938 хууль хүчин төгөлдөр байгаагийн 352 нь нийгмийн харилцааг тогтвортой зохицуулдаг буюу байнга дагаж мөрдөгдөх шинжтэй хууль байгаа бол бусад хуулиуд нь нэг удаагийн асуудлыг зохицуулах, зөвхөн тодорхой хугацаанд үйлчлэх, эсхүл бусад хуулийн хэрэгжилтийг хангах зорилготой дагаж мөрдөх журмын тухай хууль шинжтэй байна. Тогтвортой үйлчилж буй дээрх 352 хуулиас хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийгдсэн байх шаардлагатай буюу хүчин төгөлдөр болсноос хойш тав ба түүнээс дээш жилийн хугацаа өнгөрсөн 267 хууль байна. Гэвч эдгээрийн зөвхөн 44 хувь буюу 118 хуульд хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийгджээ. Үлдсэн 148 хуулийн хувьд үнэлгээний тайлан эсхүл үнэлгээ хийсэн тухай мэдээлэл олдоогүй нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг тогтмол үнэлэх, сайжруулах зохицуулалтын

хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна. Энэ нөхцөл байдлыг сайжруулах хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуульд тусгагдсан хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний зохицуулалт төдийгүй үнэлгээний аргачлалыг эргэн харж, боловсронгуй болгох шаардлагатайг судлаачид зөвлөсөн юм. Тухайлбал, хууль тогтоомжийн хэрэгжилт, түүнээс улбаатай үр дагаврыг үнэлэхдээ тухайн хуулийг боловсруулахад үндэс болгосон хүний эрх, эдийн засгийн өсөлт, хөгжил, нийгэм, байгаль орчинд үзүүлэх эерэг нөлөөллийн зорилтууд бодитоор биелсэн эсэхийг эргэж дүгнэх шаардлага тавьдаггүй ажээ. Тэрчлэн хуулийн хэрэгжилт, үр дагаврыг үнэлэх ажил хангалтгүй байгаа нь төрийн байгууллагуудын үүрэг хариуцлагын хуваарилалт оновчтой бус байгаатай холбоотой. Өөрөөр хэлбэл, үнэлгээг гүйцэтгэх засаглалын байгууллага хэрэгжүүлэхээр заасан нь хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах чиг үүрэгтэй нь зөрчилдөж, ашиг сонирхлын зөрчил үүсгэж байна. Яам, агентлагуудын боловсруулсан зарим үнэлгээнд байгууллагынхаа эрх хэмжээг

тэлэхэд чиглэсэн зөвлөмж нийтлэг туссан байна. Нөгөөтээгүүр, УИХ-ын Тамгын газар хэрэгжилтийн үнэлгээ хийх үүрэгтэй хэдий ч байгууллагын бүтэц, орон тоо, төлөвлөлт, зохион байгуулалт, төсөв санхүүгийн нөөцийн хувьд уг чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх боломж бараг байхгүй. Иймд үнэлгээнд аль болох хөндлөнгийн оролцоог нэмэгдүүлэх, ялангуяа иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог дэмжих нь зүйтэй. Харин УИХ, Засгийн газрын түвшинд тухайн жилд хийгдсэн үнэлгээний дүнг тогтмол хэлэлцэн, хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээ авах тогтолцоог бүрдүүлэх нь илүү оновчтой.

Шинэ оны өмнөхөн дээрх хоёр судалгааны дүнг олон нийтэд танилцуулан салбарын мэргэжилтнүүдийн хүрээнд хэлэлцүүлж, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хэрэгжүүлж буй хууль тогтоомжийн судалгааны аргачлалуудыг сайжруулах ажлын хэсэгт ажиллаж байна.



“Хууль тогтоомжийн төсөл судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх зарчмын хэрэгжилт” сэдэвт хэлэлцүүлгийн үеэр (2025.12.05) <https://forum.mn/post/170746>

Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” гэж заасан билээ.

Энэ зарчмын хүрээнд 2022 онд Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, нийтийн ашиг сонирхолтой холбоотой өргөдөл хүлээн авч шийдвэрлэх зохицуулалт тусгасан нь иргэдийн шууд оролцооны эрхийг хангах чухал алхам болсон юм. Үүний дагуу УИХ 2023 оны 10 дугаар сард “D-Өргөдөл” буюу Нийтийн цахим өргөдөл, гомдлын системийг ашиглалтад оруулав. Иргэд уг системээр дамжуулан нийтийн ашиг сонирхлыг хөндсөн, УИХ-ын бүрэн эрхэд хамаарах асуудлаар өргөдөл гаргах боломж нээгдсэн юм. Хуульд заасан шаардлага хангасан өргөдлийг УИХ-ын Тамгын газар цахим системд нийтэлж, олон нийтээс санал авах ажлыг зохион байгуулна. Тогтоосон тооны дэмжлэг авсан өргөдлийг холбогдох Байнгын хороо хянан хэлэлцээд тодорхой арга хэмжээ авах зохицуулалт хэрэгжиж байна.

2023 оны 10 дугаар сараас 2025 оны 11 дүгээр сар хүртэлх хугацаанд Нийтийн цахим өргөдөл, гомдлын системд нийт 1764 өргөдөл бүртгэгдсэнээс 326 өргөдлийг нийтэлж, олон нийтийн санал авчээ. Эдгээрээс дөнгөж 12 өргөдөл хуульд заасан тооны иргэдийн дэмжлэг авч, Байнгын хороодод хуваарилагдсан бөгөөд хоёр өргөдөл эцэслэн шийдвэрлэгджээ. Үүнд:

- 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр батлагдсан Хөрөнгө оруулалтын тухай

хуулийн нэмэлт өөрчлөлтөөр гадаадын иргэнд газрыг 60 хүртэл жилээр гэрээний үндсэн дээр эзэмшүүлэх, ашиглуулах, нэг удаа 40 хүртэл жилээр сунгах зохицуулалтыг хуулиас хассан.

- “Агаарын бохирдлыг бууруулах хүрээнд утааны асуудлаарх бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүн, шийдэл” сэдэвт ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулагдав.

Ийнхүү нийтийн өргөдөл хуульд заасан маш өндөр шалгуур бүхий босгыг давж, холбогдох байгууллагад хуваарилагддаг боловч шийдвэрлэлтийн явц ч мөн удаашралтай байна. Энэ нь өргөдөл Байнгын хороонд шилжсэнээс хойших УИХ-ын Тамгын газрын үүрэг, хариуцлагын зохицуулалт тодорхой бус байгаатай холбоотой. Мөн өргөдлийг анхлан хүлээн авах шатанд хуульд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах үйл ажиллагааны дотоод хуваарилалт оновчгүйгээс хугацаа алдах, шаардлага хангаагүй үндэслэлийг нийтэд мэдээлдэггүй, дэмжсэн саналын тоонд хэт өндөр босго тогтоосон, цахим гарын үсэг болон ДАН системээр нэвтрэх шаардлага нь иргэдэд төвөгтэй байдал үүсгэж буй зэрэг цаашид анхаарах олон асуудал бий.

Дээрх асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн санал зөвлөмж боловсруулан УИХ-ын гишүүн Ж.Золжаргалын санаачлан боловсруулсан “Нийтийн өргөдөл хүлээн авах, нийтлэх, санал авах, шийдвэрлэлтийн талаар өргөдөл гаргагчид мэдээлэх үйл ажиллагааг зохион байгуулах журам”-ын төсөлд тусгуулахаар хүргүүлээд байна.



<https://forum.mn/product/531311>



<https://forum.mn/product/597833>



<https://forum.mn/product/543753>



<https://forum.mn/product/459176>



<https://forum.mn/product/588437>

## Эрчим хүчний шилжилт: Сайн засаглал, шударга шилжилтийг дэмжих нь

Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнтэй хамтран тайлант онд "Эрчим хүчний шилжилт ба эрдэс баялгийн салбарын ил тод байдал" сэдэвт сургалт зохион байгууллаа. Тус сургалтад уул уурхай, байгаль орчин, хүний эрх, засаглалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус болон хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл оролцож, уур амьсгалын өөрчлөлт, түүний сөрөг нөлөөг сааруулахад чиглэсэн эрчим хүчний шилжилтийн үйл явц дахь иргэний нийгмийн оролцооны талаар хэлэлцэв.

Дэлхий даяар өрнөж буй цэвэр эрчим хүчний төлөө хүчин чармайлт нь манай улсад олон шинэ боломж нээхийн зэрэгцээ бодлогын шинэ шинэ сорилтууд бий болгож байна. Нүүрснээс өндөр хамааралтай экспортын орлого, эрчим хүчний салбар төдийгүй дэд бүтэц, засаглалын сул байдал нь хүлэмжийн хийн ялгаруулалтыг 2035 он гэхэд 30.3 хувиар бууруулах амлалтаа хэрэгжүүлэхэд томоохон хүндрэл болохоор байна.

Нөгөө талаас цэвэр эрчим хүчний технологид шаардлагатай чухал ашигт малтмалын өсөн нэмэгдэж буй эрэлт нь эрдэс баялгийн нөөцдөө тулгуурлан эдийн засгаа төрөлжүүлэх, тэлэх боломжийг ч мөн бүрдүүлж буй. Энэ боломжийг бүрэн дүүрэн ашиглаж чадах эсэх нь эрдэс баялгийн салбарын шинэчлэл, нөөцийн удирдлагын оновчтой бодлогоос хамаарна.

Чухал ашигт малтмалын төлөө өрсөлдөөн улам бүр нэмэгдэж, олон улсын харилцаа, гадаад худалдааны бодлогод нөлөөлөх болсонтой зэрэгцэн байгалийн баялаг ихтэй хөгжиж буй орнуудад хайгуул,

ашиглалтын үйл ажиллагааны зөвшөөрөл, хяналтын тогтолцоог хялбарчлах, байгаль орчин, нийгмийн стандартыг сулруулах хандлага ажиглагдаж байна. Энэ нь авлигын эрсдэлийг нэмэгдүүлж, засаглалын чанарт сөргөөр нөлөөлөх үр дагавартай. Сүүлийн жилүүдэд Монгол Улсад өрнөсөн эрдэс баялгийн салбарын хэлэлцүүлэг, хууль тогтоомжийн төсөл, түүнийг боловсруулах үйл явцаас үзэхэд дээрх эрсдэл манай улсыг тойрч гарахгүй нь харагдаж байна. Тухайлбал, Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг хэрэгжүүлэх зорилгын дор боловсруулагдаж буй Ашигт малтмалын тухай хуулийн төсөлд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны хариуцлагыг сулруулах, орон нутгийн оролцоо, иргэний орон зайг хүмийх эрсдэлтэй зохицуулалтууд тусаад буй. Үүнээс гадна Үндсэн хуулиар баталгаажсан иргэдийн мэдэх эрхийг хангахтай холбоотой зохицуулалт бараг тусаагүй байна.

Гэсэн хэдий ч НҮБ, ОУИТБС зэрэг олон улсын байгууллага, санхүүжүүлэгчдийн зүгээс эрчим хүчний шилжилтийн бодлогод "шударга" байдлын зарчмыг хангах, ялангуяа үндэсний бодлого, зохицуулалтыг тодорхойлох үйл явцад олон талын оролцоог хангах, ялангуяа эрх ашиг нь хөндөгдөх бүлгүүдийн оролцоог баталгаажуулахыг чухалчлах болов. Энэ хүрээнд Монгол Улсад сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаанд тулгуурлан хэрэгжиж ирсэн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС) нь эрдэс баялгийн салбарын засаглалын асуудлаарх олон нийтийн хэлэлцүүлгийн үр нөлөөтэй талбар болж чадах юм. Иймд дээрх сургалтын үеэр ОУИТБС-ын эрчим хүчний шилжилттэй холбоотой шинэ

шаардлагуудыг хэрэгжүүлэх, энэ үйл явцад иргэний нийгэм хэрхэн оролцох талаар ярилцаж, цаашдын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулав.

Сургалт, хэлэлцүүлгийн үр дүнд тулгуурлан 12 дугаар сарын 17-ны өдөр "ОУИТБС-ын хэрэгжилт: Эрчим хүчний шилжилт" хэлэлцүүлэг зохион байгууллаа. Уг арга хэмжээг Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн, ОУИТБС-ын Ажлын албатай хамтран зохион байгуулж, санаачилгын хэрэгжилтэд оролцдог төрийн болон төрийн бус байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын төлөөлөл оролцон эрчим хүчний шилжилтийн явцад ил тод байдал, олон нийтийн хяналт, оролцоог бэхжүүлэх асуудлаар санал солилцов. Эрдэс баялгийн салбарт ил тод байдлыг хангах уг санаачилга цар хүрээгээ тэлж, эрчим хүчний салбар, нэн ялангуяа шилжилтэд чиглэсэн бодлого, төлөвлөгөө, тэдгээрийн хэрэгжилт,

төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалт, төрөөс явуулж буй үнийн зохицуулалт, татаастай холбоотой мэдээллийг нээлттэй болгох замаар иргэдийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх шаардлагыг дэвшүүлж байна.

Иймд уг хэлэлцүүлэгт эрчим хүч, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох чадавхыг бэхжүүлэх үндсэн чиг үүрэг бүхий Эрчим хүчний яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Статистикийн үндэсний хороо зэрэг байгууллагуудын холбогдох албан тушаалтнууд оролцож, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах талаар ярилцав. Оролцогчид эрдэс баялгийн салбарт хэвшин тогтсон ил тод байдал, түншлэлийн тогтолцоонд тулгуурлан эрчим хүчний салбарт ил тод, нээлттэй байдлыг хангах боломжтой гэдэгт санал нэгдсэн төдийгүй энэ чиглэлээр цаашид авч хэрэгжүүлэх алхмууд, талуудын үүрэг оролцоог тодорхойллоо.



"Эрчим хүчний шилжилт ба эрдэс баялгийн салбарын ил тод байдал" сэдэвт иргэний нийгмийн байгууллагуудад зориулсан сургалт (2025.12.04) <https://forum.mn/post/170485>



“ОУИТБС-ын хэрэгжилт: Эрчим хүчний шилжилт” олон талт хэлэлцүүлэг (2025.12.17) <https://forum.mn/post/170930>

## Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах нь

Эдийн засаг дахь төрийн оролцоо улам бүр өсөн нэмэгдсээр улс орны эдийн засаг Үндэсний баялгийн сан, улсын төсвийн орлогын томоохон хэсгийг бүрдүүлэгч төрийн өмчит уул уурхайн компаниудын нуруун дээр л тогтож байна гэхэд бараг хилсдэхгүй хэмжээнд хүрчээ. Төрийн өмчит компанийн тоог бууруулах, шинээр нэмж байгуулахыг хязгаарлах, засаглалыг сайжруулах асуудал олон жилийн турш яригдаж, улс төрийн намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдсаар ирсэн. Харамсалтай нь өнгөрсөн онд Засгийн газраас олон нийтэд танилцуулсан Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөлд дорвитой, зарчмын шийдэл туссангүй. Хуулийн төслийн нэр нь л улам сүржин болсноос агуулга, зохицуулалтын цар хүрээний хувьд 2022-2024 онд ХЗДХЯ-аас боловсруулсан төслүүдтэй харьцуулахад зарчмын ялгаа бага байна.


Үүнээс харахад, өнгөрсөн хугацаанд өрнөсөн ТӨК-тай холбоотой авлигын хэргүүд, улс төрийн томилгоо, төрөөс удирдамж, чиглэл өгч үйл ажиллагаанд нь шууд оролцон төлөвлөгдөөгүй зардлын дарамт үүсгэх, төсвийн алдагдлыг нөхөх хэрэгсэл болгон ашигладаг зэрэг зөрчил, дутагдал ойрын үед арилах эсэх нь эргэлзээтэй байна.

Энэ нөхцөлд Нээлттэй нийгэм форум өмнө хийсэн судалгаа шинжилгээний үр дүнд тулгуурлан хуулийн хэлэлцүүлгүүдэд идэвхтэй оролцохын зэрэгцээ ТӨК-тай холбоотой төрийн шийдвэрүүдэд хууль зүйн шинжилгээ хийж эхлээд байна. Үүнд ТӨК-ийг нэгтгэх, нийлүүлэх, ТУЗ-ийн гишүүн, бүрэн эрхт төлөөлөгч, бүтээмжийн менежер томилох, ногдол ашиг хуваарилах, томоохон төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх чиглэл өгч буй асуудлууд багтаж байна.

Эхний шинжилгээгээр сүүлийн таван жилийн хугацаанд хийгдсэн ТӨК-ийн удирдах түвшний томилгоог авч үзэхэд дараах нийтлэг асуудлууд давтагдсан юм. Тухайлбал, ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулалтгүйгээр томилсон, Засгийн газар компанийн ТУЗ-ийг давж гүйцэтгэх захирлыг нэр заан тулгах, “бүтээмжийн менежер” гэх хүний нөөцийн стратеги, төлөвлөлтөд огт байхгүй цоо шинэ албан тушаал бий болгож, УИХ-д төлөөлөлтэй улс төрийн намуудын төлөөний хүнийг хуваарилсан, ингэхдээ албан ёсны шийдвэр бус Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр чиглэл өгдөг, уг тэмдэглэл нь нээлттэй биш зэрэг асуудлыг баримтжуулж, хууль тогтоомжийн нийцэлд дүгнэлт өгөв.

Засгийн газраас Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төслийг танилцуулсантай холбогдуулан сүүлийн жилүүдэд хийсэн судалгаа, шинжилгээний тайланг УИХ-ын гишүүдэд хүргүүлээ. Мөн ТУЗ-ийн хараат бус байдал, томилгоо, бүрэн эрх, хариуцлагын асуудлаарх судалгааны үр дүнг нэгтгэн “Форум” подкастын 5 дахь дугаараар олон нийтэд хүргэв. “ТӨК-ийн ТУЗ-ийн үүрэг, хариуцлага: Хуулийн төсөлд анхаарах асуудал” сэдэвт уг ярилцлагад хууль зүйн ухааны доктор судлаач М.Түвшинжаргал оролцож, ТУЗ-д төрийг төлөөлөх гишүүдийг мэргэжил, үр чадварыг харгалзан томилох, ТУЗ-ийн хэлэлцэх асуудлаар тэдэнд удирдамж, чиглэл өгч болох ч эцсийн шийдвэр гаргах ТУЗ-ийн бүрэн эрхийг хүндэтгэн хэрэгжүүлэх, үүний тулд хараат бус гишүүдийг нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгох, ТУЗ-ийн үйл ажиллагаанд зүй бус нөлөөлөл

үзүүлсэн гуравдагч этгээдэд хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг бүрдүүлэх шаардлагатайг дурдав.



“Форум” подкаст №5. ТӨК-ийн ТУЗ-ийн үүрэг, хариуцлага: Хуулийн төсөлд анхаарах асуудал”, <https://forum.mn/post/162924>

Түүнчлэн төрийн нээлттэй мэдээлэлд тулгуурласан өгөгдлийн шинжилгээг хөгжүүлсэн туршлага, сургамжийг олон улсын түвшинд танилцуулав. Тодруулбал, уул уурхайн ТӨК-ийн худалдан авалттай холбоотой авлига, ашиг сонирхлын зөрчлийг тодорхойлсон туршлага, сургамжаа Филиппин Улсын Манила хотод зохион байгуулагдсан Нээлттэй засаглалын түншлэлийн Ази, Номхон далайн бага хурлын үеэр танилцуулсан юм. Төрөөс аливаа мэдээллийг ил тод болгохдоо нээлттэй мэдээллийн стандартыг бүрэн хэрэгжүүлж, мэдээллийн системүүдийн үялдаа, зохицон ажиллах чадавхыг хангах нь авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийн хяналтыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтойг тус хурлын оролцогчид онцолж байв.

## НИЙТИЙН АШИГ СОНИРХЛЫГ НЭХЭМЖЛЭН ХАМГААЛАХ НЬ

Манай байгууллага төрийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хэрэгжилт, хариуцлагыг нэмэгдүүлэх хүрээнд нийтийн эрх ашгийн өмгөөллийг түгээн дэлгэрүүлэхэд анхаарал хандуулан ажиллаж ирлээ. Энэ чиглэлээр 2025 онд хэрэгжүүлсэн ажлуудаас тоймлон дурдвал, 2024 онд Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимтай хамтран зохион байгуулсан “Нийтийн ашиг сонирхлыг шүүхэд төлөөлөн хамгаалах нь: Асуудал ба шийдэл” сэдэвт хэлэлцүүлгийн мөрөөр “Нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэх эрхийг өргөжүүлэх нь” харьцуулсан судалгаа, “Захиргааны хэргийн шүүх дэх олон улсын гэрээ, конвенцын хэрэглээ” сэдэвт бодлогын шинжилгээ хийн нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэн хамгаалахад хуульчдын сайн дурын оролцоог өргөжүүлэх асуудлаар тэдний дунд хэлэлцүүлэг өрнүүлээ. Улмаар Улаанбаатар хотын нийтийн эзэмшлийн зам, талбайн засвар үйлчилгээнд хуулийн хэрэгжилт, ил тод байдлыг сайжруулах хуульчдын санаачилгыг дэмжин ажиллаж байна.

“Нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэх эрхийг өргөжүүлэх нь” харьцуулсан судалгаагаар Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Өмгөөллийн тухай хуулиудаар тодорхойлсон нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэх эрх, түүний агуулга, цар хүрээ, хууль хэрэглээний практикийг АНУ, Канад, Герман, Англи, Нидерланд, Эстони, Хятад, Япон зэрэг улсын туршлагатай харьцуулан судаллаа.

Дээрх улсуудын туршлагаас харахад “нийтийн ашиг сонирхол” гэх ойлголтыг улс бүр өөр өөрийн эрх зүйн тогтолцоо, нийгмийн онцлогт тулгуурлан харилцан адилгүй тодорхойлжээ. Гэвч Монгол Улсад мөрдөгдөж буйтай адил “хүрээлэн буй орчин, хүүхдийн эрх, нийтийн өмч, нийтийн эрүүл мэнд”

зэрэг цөөн хүрээгээр хязгаарласан жишээ түгээмэл бус байна. Тодруулбал, нийтийн ашиг сонирхлын маргаанд хүний амьд явах эрх, газар болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх, шаардлагад нийцсэн орон байртай байх эрх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, эрүүл мэндийн тусламж авах эрх, сурч боловсрох эрх, хөдөлмөрлөх эрх, мэдээлэл авах эрх, сонгох, сонгогдох эрх, хоол хүнс, үндны усны эрх, төсөв, татвар, санхүүтэй холбоотой эрх, хэрэглэгчийн эрх, нийгэм, эдийн засгийн эмзэг болон ялгаварлагдан гадуурхагдсан бүлгийн эрх, шилжилт хөдөлгөөн, цагаачлал, дүрвэгсдийн эрх, охид, эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрх зэрэг иргэний болон улс төрийн, эдийн засаг нийгэм соёлын олон эрхийг хамруулан өргөн цар хүрээгээр тодорхойлж байна. Тэрчлэн шударга ёсны тогтолцоог хамгаалах, мэдээллийн ил тод байдал, мэдээллийн технологи, цахим орчин, хиймэл оюун ухаантай холбоотой асуудлаар нэхэмжлэл гаргах боломж бүрдүүлжээ.

Нэхэмжлэл гаргах эрхийн зохицуулалтын тухайд БНХАУ, Япон, ХБНГУ-д субъектив эрхийн хамгаалалтыг түлхүү баримталж, тухайн эрх нь бодитоор зөрчигдөөгүй тохиолдолд нэхэмжлэл гаргах боломжийг хязгаарлах хандлага давамгайлсан хэвээр байгаа бол Канад, Нидерланд, Эстони зэрэг улсад хууль дээдлэх ёс, төрийн сахилга, хариуцлагыг бэхжүүлэх зорилгоор нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг харьцангуй өргөн хүрээнд зөвшөөрсөн байна. Эдгээрээс Нидерланд Улсын туршлага нэлээд онцлог бөгөөд иргэний нийгмийн байгууллагын нийтийн ашиг сонирхлыг төлөөлж шүүхэд хандах эрхийг өргөн хүрээнд хүлээн зөвшөөрснөөр захиргааны актын шинжийг хангаагүй хэдий ч эрх зүйн чухал үр дагавартай баримт бичгүүдийг ч шүүхээр хянуулах

боломж бүрдсэн байна. Тухайлбал, хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах төлөвлөгөө болон түүний хэрэгжилт хангалтгүй байгаатай холбоотой гомдлыг шүүх хүлээн авч шийдвэрлэсэн тохиолдол ч байгаа юм.

Монголын Хуульчдын холбоо, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хамтран зохион байгуулсан Азийн 13 дахь удаагийн Про Боно чуулганы үеэр “Өөрчлөлтийн төлөөх Про Боно: Нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэн хамгаалах нь” сэдэвт салбар хуралдаан зохион байгууллаа. Тус хуралдаанаар нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэн хамгаалахад хуульчдын оролцоог нэмэгдүүлэх, төрийн бус

байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх болон энэ төрлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд тулгамдаж буй бусад олон асуудлын шийдлийг хэлэлцэв. Хуралдаанд нийтийн өмч, байгаль орчин, хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөллүүд болон хуульчид оролцож өмгөөллийн туршлага, сургамжаа хуваалцсанаас гадна DLA Piper олон улсын хуулийн фирмийн Ази дахь Про Боно үйл ажиллагааг хариуцсан ажилтан Арон Чан оролцон нийтийн эрх ашгийн өмгөөллийг дэмжих чиглэлээр Хонконг болон бусад улсын туршлагаас танилцуулсан нь онцлог байлаа.



Азийн 13 дахь Про Боно чуулга уулзалтын салбар худалдаан “Өөрчлөлтийн төлөөх Про Боно: Нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэн хамгаалах нь” (2025.10.04) <https://forum.mn/post/169016>

Хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн Монгол Улсад хуульчдын про боно үйл ажиллагаа, тэр дундаа нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэн хамгаалах идэвх оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн багц санал боловсруулж Монголын хуульчдын холбоонд уламжлав. Зөвлөмжид нийтийн ашиг сонирхлыг хамгаалах асуудлыг хуульчийн, тэр дундаа

шүүгчийн үргэлжилсэн сургалтын хөтөлбөрт тусгах, сургалтад төрийн захиргааны байгууллагын хуулийн мэргэжилтнүүдийг хамруулах, сайн жишиг тогтоосон кэйс, шүүхийн шийдвэрийг сурталчлах, нийтийн ашиг сонирхлын нэхэмжлэлийг буцаасан, хүлээн авахаас татгалзсан, хэрэгсэхгүй болгосон үндэслэлд дүн шинжилгээ хийх талаар тусгав. Түүнчлэн энэ

төрлийн өмгөөллийг дэмжих санхүүгийн тогтвортой эх үүсвэр бүрдүүлэх, нийтийн эрх ашгийн өмгөөллийг хөгжүүлэхэд чиглэсэн про боно үйл ажиллагааг дэмжих бодлого, гарын авлага боловсруулж, хуулийн фирмүүдэд танилцуулах, Хууль зүйн туслалцааны төвөөр дамжуулан Про Боно үйлчилгээ үзүүлэхийг хуульчдад уриалан, тэднийг бүртгэх замаар Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-6.3 дахь хэсэгт зааснаас бусад асуудлаар төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх өмгөөллийн үйлчилгээнд хуваарилан ажиллуулах зэрэг бусад

үлс орны туршлагад үндэслэн боловсруулсан санал зөвлөмж хүргүүлээ.

Ташрамд, Азийн 13 дахь Про Боно чуулган нь Монголын хуульчдын хувьд дэлхийн 30 гаруй орны 300 гаруй хуульч, судлаач, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллөөс суралцах, мэдлэг, туршлагаа хуваалцан хүний эрх, нийтийн эрх ашиг, шударга ёсны төлөөх хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон юм.



## САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нээлттэй Нийгэм Форум 2025 онд нийт 5,958,002 мян.төгрөгийн санхүүжилттэй ажилласан ба үүнээс 3,556,660 мян.төгрөг нь Нээлттэй Нийгэм Хүрээлэн болон түүний сүлжээний хөтөлбөрүүд, 2,401,342 мян.төгрөг нь бусад болон өөрийн санхүүжилтийн орлогоос санхүүжигдсэн болно. Санхүүжилтийн зарцуулалтыг дор хүснэгтээр харуулав.

НИЙТ ЗАРЦУУЛАЛТ

мян.төгрөг

Хөтөлбөр	Тэтгэлгийн зардал	Үйл ажиллагааны зардал	Нийт зардал
<b>АРДЧИЛСАН САЙН ЗАСАГЛАЛ</b>			
Ардчиллын институциудыг бэхжүүлэх хөтөлбөр	-	648,063	648,063
Иргэний орон зайн хөтөлбөр	74,300	407,243	481,543
<b>ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН БОДЛОГО</b>			
Эрх зүйн хөтөлбөр	34,950	635,827	670,777
<b>НИЙТИЙН БАЯЛГИЙН УДИРДЛАГА, ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ</b>			
Төсвийн хариуцлагыг дээшлүүлэх хөтөлбөр	32,200	534,468	566,668
Эрдэс баялгийн салбарын засаглалын хөтөлбөр	20,000	571,770	591,770
<b>ЗАХИРГАА</b>		814,512	814,512
<b>ТАТВАРЫН ЗАРДАЛ</b>		209,994	209,994
<b>НИЙТ ДҮН</b>	<b>161,450</b>	<b>3,821,878</b>	<b>3,983,328</b>

2025 ОНД ОЛГОСОН ТЭТГЭЛГИЙН ЖАГСААЛТ (БАЙГУУЛЛАГААР)

мян.төгрөг

№	Байршил	Тэтгэлэг авагч байгууллага, иргэн	Төслийн нэр	Төрөл	Тэтгэлгийн дүн
1	Улаанбаатар	БОДЛОГОД ЗАЛУУСЫН ХЯНАЛТ НҮТББ	"Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний томилгоонд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь"	ТББ	15,000
2	Улаанбаатар	БОЛОРМАА Батмөнх	"Иргэний нийгмийн долоо хоног- 2025" арга хэмжээнд оролцох аяллын тэтгэлэг	Хувь хүн	5,500
3	Улаанбаатар	МАНДХАЙХАТАН Цэвэгмид	"Иргэний нийгмийн долоо хоног- 2025" арга хэмжээнд оролцох аяллын тэтгэлэг	Хувь хүн	5,500
4	Улаанбаатар	МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБОО	"Монголын хуульчдын холбоонд Азийн 13 дахь удаагийн Про Боно чуулга уулзалт ("13АРВС")-ыг Монгол Улсад зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах"	ТББ	20,000
5	Улаанбаатар	УЛС ТӨРИЙН БОЛОВСРОЛЫН АКАДЕМИ	"Азийн барометр судалгааны 20 жилийн ойд зориулсан судалгааны бүтээлийн онол, арга зүйн хэсгийг "Шинэ толь" сэтгүүлийн 87 дах дугаар болгож хэвлэх"	ТББ	3,800
6	Улаанбаатар	МОНГОЛЫН ЗАЛУУЧУУДЫН ЭВСЭЛ ТББ	"Төсвөө мэдье-Төсвөө мөшгөө"	ТББ	32,200
7	Улаанбаатар	ИРГЭНИЙ ҮНДСЭН ЭРХ ХӨГЖИЛ ТББ	"Нийслэл хотын явган хүний зам, талбайн засварын ажилтай холбоотойгоор шаардах эрхийг хэрэгжүүлэх нь"	ТББ	9,500
8	Улаанбаатар	МОНГОЛЫН ЗАЛУУЧУУДЫН ЭВСЭЛ ТББ	Завсарлага подкаст	ТББ	19,950
9	Улаанбаатар	МОНГОЛЫН ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ ТББ	Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль (төсөл)-ийн хэрэгжилтэд мониторинг хийх	ТББ	50,000
<b>НИЙТ ОЛГОСОН ТЭТГЭЛЭГ</b>					<b>161,450</b>

2025 ОНД ОЛГОСОН ТЭТГЭЛГИЙН ЖАГСААЛТ (ХӨТӨЛБӨРӨӨР)

мян.төгрөг

Хөтөлбөр	Байгууллагад олгосон тэтгэлэг	Хувь хүнд олгосон тэтгэлэг	Нийт тэтгэлгийн зардал
<b>АРДЧИЛСАН САЙН ЗАСАГЛАЛ</b>			
Ардчиллын институциудыг бэхжүүлэх хөтөлбөр	-	-	-
Иргэний орон зайн хөтөлбөр	63,300	11,000	74,300
<b>ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН БОДЛОГО</b>			
Эрх зүйн хөтөлбөр	34,950	-	34,950
<b>НИЙТИЙН БАЯЛГИЙН УДИРДЛАГА, ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ</b>			
Төсвийн хариуцлагыг дээшлүүлэх хөтөлбөр	34,950	-	34,950
Эрдэс баялгийн салбарын засаглалын хөтөлбөр	20,000	-	20,000
<b>НИЙТ ОЛГОСОН ТЭТГЭЛЭГ</b>	<b>150,450</b>	<b>11,000</b>	<b>161,450</b>

**НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМЫН  
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД, АЖИЛТНУУД**

Удирдах Зөвлөлийн гишүүд

Д.Энхжаргал	УЗ-ийн дарга, МОНФЕМНЕТ, Ерөнхий зохицуулагч
Ж.Үнэнбат	УЗ-ийн гишүүн, Компанийн засаглалын хөгжлийн төв ТББ-ын зөвлөх
Ч.Болортуяа	УЗ-ийн гишүүн, Бодлогын судалгааны форум НҮТББ-ийн гүйцэтгэх захирал
Н.Энхбаяр	УЗ-ийн гишүүн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга
Х.Наранжаргал	УЗ-ийн гишүүн, "Глоб Интернэшнл төв" ТББ-ын Удирдах зөвлөлийн дарга

Гүйцэтгэх захирал

П.Эрдэнэжаргал

Ажилтнууд

Ж.Алтанчимэг	Нягтлан бодогч, тэтгэлгийн менежер
П.Бадамрагчаа	Эрх зүйн хөтөлбөрийн менежер
Б.Бат-Эвлэл	Захиргааны туслах ажилтан
А.Гэрэлмаа	Иргэний нийгмийн орон зайн хөтөлбөрийн менежер
Б.Мөнхгэрэл	Хэвлэл мэдээлэл, олон нийт хариуцсан ажилтан
Д.Оюунбадам	Засаглалын хөтөлбөрийн менежер
Б.Ундармаа	Хөтөлбөрийн зохицуулагч
О.Сэлэнгэ	Хөтөлбөрийн зохицуулагч
Э.Сайнтүвшин	IT, Оффис менежер
В.Халиунцэцэг	Санхүүгийн менежер
Д.Эрдэнэчимэг	Засаглалын хөтөлбөрийн менежер
Д.Энхцэцэг	Засаглалын хөтөлбөрийн менежер

Нийтлэг И-мэйл: [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)

## ЖИЛИЙН ТАЙЛАН 2025

---

Нээлттэй Нийгэм Форум  
Л.Түдэвийн гудамж-5/3, Сүхбаатар дүүрэг,  
Улаанбаатар - 14240, Монгол Улс  
Утас: 76113207  
<http://www.forum.mn>  
<http://www.twitter.com/ForumOS>  
<http://facebook/OpenSocietyForum>  
[http://www.instagram.com/open\\_society\\_forum](http://www.instagram.com/open_society_forum)